



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ IV УЛИРАЛ



Цахим хувилбар

Энэхүү тайланд тусгагдсан үр дүн, тайлбар, дүгнэлт нь Эдийн засаг, хөгжлийн яамны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

Уг тайланг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд “Макро эдийн засгийн танилцуулга, 2025 оны 4 дүгээр улирал, Эдийн засаг, хөгжлийн яам” гэж эх сурвалж хэсэгт тодотгоно уу. Санал, хүсэлт ирүүлэх, бусад мэдээллийн талаар тодруулах бол MEPD@med.gov.mn цахим шуудан эсвэл дараах хаягаар хандана уу.

Эдийн засаг, хөгжлийн яам, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр, Улаанбаатар хот 15141, Монгол Улс

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА
2025 оны IV улирал

Агуулга

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ	7
БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ	9
1. БОДИТ СЕКТОР	11
1.1. Нийлүүлэлт	12
1.2. Эрэлт	15
1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж	17
1.4. Эдийн засгийн мөчлөг	22
2. ТӨСВИЙН СЕКТОР	17
2.1. Төсвийн гүйцэтгэл	18
2.2. Төсвийн төлөв	18
1.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал	19
2. МӨНГӨНИЙ СЕКТОР	23
3.1. Инфляц	24
3.2. Мөнгө ба санхүүгийн салбар	28
3. ГАДААД СЕКТОР	33
4.1. Гадаад худалдаа	34
4.2. Төлбөрийн тэнцэл, гадаад өр	38
4. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ	42
5.1. Дэлхийн эдийн засаг	43
5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага	45
5.3. Олон улсад зарлагдсан индексүүд	47
5.4. Ногоон санхүүжилт	49
5. Макро эдийн засгийн нөхцөл байдал (2021-2025)	54
6.1. Эдийн засгийн өсөлт	54
6.2. Инфляц	60
6.3. Хөдөлмөр эрхлэлт	61
6.4. Нэгдсэн төсөв	62
6.5. Гадаад худалдаа	64
6.6. Төлбөрийн тэнцэл	66
7. Эдийн засгийн түүхэн хураангуй (2006-2020)	67
7.1. Эдийн засгийн өсөлт	67
7.2. Инфляц	73
7.3. Хөдөлмөр эрхлэлт	75
7.4. Нэгдсэн төсөв	78
7.5. Гадаад худалдаа	80
7.6. Төлбөрийн тэнцэл	82
8. Хавсралт	86

Зураг, хүснэгт, шигтгээний жагсаалт

Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт (нийлүүлэлт).....	14
Зураг 1.2. Бодит ДНБ-ий өсөлт (эрэлт талаас).....	16
Зураг 1.3. Хөдөлмөрийн зах зээл.....	17
Зураг 1.4. Аж ахуйн нэгж.....	19
Зураг 1.5. Хэрэглэгчийн итгэлийн индекс, улирлаар.....	20
Зураг 1.7. Үйлдвэрлэлийн зөрүү.....	22
Зураг 2.1. Төсвийн орлого.....	19
Зураг 2.2. Төсвийн зарлага.....	18
Зураг 2.3. Төсвийн тэнцэл ба төлөв.....	18
Зураг 2.4. Засгийн газрын өр.....	19
Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн.....	24
Зураг 3.2. Тэйлорын хүү, мөнгөний нөхцөлийн индекс.....	25
Зураг 3.3. Голлох бүтээгдэхүүний үнэ.....	27
Зураг 3.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд.....	28
Зураг 3.5. Хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд.....	29
Зураг 4.1. Экспорт.....	34
Зураг 4.2. Импорт.....	36
Зураг 4.3. Суудлын автомашины.....	37
Зураг 4.4. Урсгал болон санхүүгийн дансны тэнцэл, төгрөгийн ханш.....	38
Зураг 4.5. Урсгал данс, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад өр.....	40
Зураг 5.1. Дэлхийн тодорхой бус байдлын индекс.....	43
Зураг 5.2. Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ.....	45
Зураг 5.3. Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн Монгол Улсын оноо, эрэмбэ.....	47
Зураг 5.4. Ногоон санхүүжилтийн өсөлт, эх үүсвэр.....	49
Зураг 5.5. Ногоон зээлийн өнөөгийн нөхцөл байдал.....	52
Зураг 6.1. Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар).....	54
Зураг 6.2. Эдийн засгийн бүтэц хувь.....	54
Зураг 6.3. Инфляцын бүрэлдэхүүн.....	60
Зураг 6.4. Ажиллагчдын тоо, салбараар (нийт ажиллагчдад эзлэх хувь).....	61
Зураг 6.5. Нийт орлого (ДНБ-д эзлэх хувь).....	63
Зураг 6.6. Нийт зардал (ДНБ-д эзлэх хувь).....	63
Зураг 6.7. Экспорт (сая ам.доллар).....	65
Зураг 6.8. Импорт (сая ам.доллар).....	65
Зураг 6.9. Экспортын бүтэц (хувь).....	65
Зураг 6.10. Импортын бүтэц (хувь).....	65
Зураг 6.11. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар).....	66
Зураг 6.12. Гадаад валютын албан нөөц, ам.долларын ханш (сая ам.доллар).....	66
Зураг 7.1. ДНБ-ий дундаж өсөлт, салбаруудаар (хувь).....	69
Зураг 7.2. ДНБ-ий өсөлтийн бүтэц, эрэлт талаас, (хувь).....	69
Зураг 7.3. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орон урсгал (тэрбум, ам.доллар).....	71
Зураг 7.4. Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт (тоо).....	72
Зураг 7.5. Түүхий эдийн үнийн индекс ба эдийн засгийн өсөлт.....	72
Зураг 7.6. Инфляцын түвшин (хувь).....	73
Зураг 7.7. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн).....	75
Зураг 7.8. Ажиллагчид (мян.хүн), ажиллах хүчний оролцооны түвшин (хувь).....	75
Зураг 7.9. Ажиллагчдын тоо, салбараар (нийт ажиллагчдад эзлэх хувь).....	77
Зураг 7.10. Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүд (ДНБ-д эзлэх хувь).....	78
Зураг 7.11. Экспорт (сая ам.доллар).....	82
Зураг 7.12. Импорт (сая ам.доллар).....	82
Зураг 7.12. Экспортын бүтэц (хувь).....	82

Зураг 7.13. Импортын бүтэц (хувь)	82
Зураг 7.14. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)	84
Зураг 7.15. Гадаад валютын албан нөөц, ам.долларын ханш (сая ам.доллар).....	84
Хүснэгт 1.2. Хэрэглэгчийн итгэлийн индексийн бүрэлдэхүүн	20
Хүснэгт 3.1. Санхүүгийн салбарын эмзэг байдал	31
Шигтгээ 1. Хэрэглэгчийн итгэлийн индекс.....	20
Шигтгээ 2. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/1348 дугаар захирамж	37
Шигтгээ 3. Ногоон санхүүжилтийн тухай ойлголт	51
Шигтгээ 4. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл.....	85

Товчилсон үг

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж, ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОУВС	Олон улсын валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УЦС	Усан цахилгаан станц
ҮНО	Үндэсний нийт орлого
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНХСҮСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үеэс сайжирлаа. ДНБ нэрлэсэн дүнгээр 89.9 их наяд төгрөгт хүрч 11.5 хувиар, бодит дүнгээр 34.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өсөв. Хөдөө аж ахуй, боловсруулах, барилгын салбаруудын өсөлт улирал дамнан хадгалагдаж, уул уурхайн салбар оны сүүл хагаст сэргэснээр эдийн засгийн өсөлтийг тэтгэсэн бол үйлчилгээний бусад үйл ажиллагаа болон худалдааны салбар агшиж эдийн засгийн өсөлтийн эрчмийг сулрууллаа.

Уул уурхайн салбар оны хоёрдугаар хагасаас эхлэн сэргэж, урьдчилсан гүйцэтгэлээр 10.6 хувьд хүрснээр нийт эдийн засгийн өсөлтийн 1.4 нэгж хувийг бүрдүүлээ. Өсөлтийг нүүрс, зэс, төмөр, жонш, цайрын баяжмал үйлдвэрлэл голлон дэмжсэн бол алт, газрын тосны үйлдвэрлэл хязгаарлалаа. Тээврийн салбар, тэр дундаа авто замаар тээвэрлэх нүүрс тээврийн орлого уул уурхайн эрчимжилтийг даган оны сүүл хагаст сэргэснээр тээврийн салбар 4.8 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 0.3 хувийг бүрдүүлэв.

Хаваржилт тогтуун байж, мал төллөлт, бойжилт хэвийн үргэлжилсний дүнд мал аж ахуйн үйл ажиллагаа сэргэн, хөдөө аж ахуйн салбар 33.2 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг 2.9 нэгж хувиар дэмжив. Мөн Улаанбаатар хотын орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын голлох нөлөөгөөр барилгын салбар 15.9 хувиар өслөө. Түүнчлэн барилга угсралт, их засварын ажлын өсөлтийг дагасан төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн өсөлтийг дагасан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэнээр боловсруулах салбар сэргэж, эдийн засгийн өсөлтийг дэмжив.

Харин экспортын нүүрс тээврийн зай багассанаар авто тээврийн салбарын шатахуун зарцуулалт буурсан, автомашины импортын худалдаа багассан, нийслэл дэх хатуу түлшний худалдааг БНХАУ-аас оруулж ирэх болсон зэргээс шалтгаалан бөөний болон жижиглэн худалдааны салбар 4.6 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 0.6 нэгж хувиар сааруулав.

Эрэлт талаас цэвэр экспорт, өрхийн хэрэглээ нийт өсөлтийг голлон дэмжлээ. Уул уурхайн салбарын үйл ажиллагааны идэвх хадгалагдан экспорт нэмэгдэж, импорт буурснаар цэвэр экспорт эдийн засгийн өсөлтийг голлон дэмжлээ. Мөн төрийн хэрэглээ буурсан ч хөдөлмөрийн зах зээл тэлж, өрхийн бодит орлогын өсөлт оны турш тогтвортой хадгалагдсанаар өрхийн хэрэглээ өсөж, нийт өсөлтийг дэмжсэн байна. Харин нийт хөрөнгийн хуримтлал агшиж, өсөлтийг хязгаарлалаа. Орон сууцны барилгын бүтээн байгуулалт болон биологийн өсөж үрждэг хөрөнгийн өсөлтийн хурд эрчимжиж үндсэн хөрөнгийн хуримтлалыг дэмжсэн боловч машин, тоног төхөөрөмжийн хуримтлалын өмнөх оны өндөр суурийн нөлөө болон тайлант онд материаллаг эргэлтийн хөрөнгө буурснаар нийт хөрөнгийн хуримтлал агшиж, өсөлтийг хязгаарласан байна.

Экспорт өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдсан боловч импорт буурснаар нийт худалдааны бараа эргэлт өмнөх оноос буурлаа. 2025 онд Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан хэдий ч нийт бараа эргэлт өмнөх оноос 1 хувиар буурлаа. Экспорт өмнөх оны түвшинд хадгалагдсан бөгөөд нүүрсний экспортын биет хэмжээ өссөн ч дэлхийн зах зээл дэх үнийн огцом бууралтаас шалтгаалан экспортын орлогод сөргөөр нөлөөлөв. Харин зэсийн баяжмал, төмрийн хүдэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт өсөж, уул уурхайн биржийн арилжаа идэвхэжсэнээр нүүрсний үнийн бууралтын нөлөөг нөхлөө. Импорт 2025 оны 2.6 хувиар буурсан бөгөөд тэр дундаа эдийн засаг, үйлдвэрлэлийг дэмждэг хөрөнгө оруулалтын болон аж үйлдвэрийн орцын бүтээгдэхүүнүүдийн импорт

буурсан байна. Түүнчлэн, суудлын автомашины импорт буурсан нь хэрэглээний бүтээгдэхүүний импортыг буурууллаа.

Төсвийн тодотголоор нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийг хязгаарлалаа. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого болон татварын бус орлогын өсөлтийн нөлөөгөөр 2025 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 30.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.4 их наяд төгрөг буюу 1.3 хувиар өссөн байна. Нөгөө талаас, төсвийн нийт зарлага 31.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.7 их наяд төгрөг буюу 2.3¹ хувиар өссөн байна. Урсгал зарлагын өсөлтөд төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгал болон халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Улмаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.

Инфляц 2025 оны эцэст 7.5 хувь, төв банкны зорилтот интервалд байна. Эрэлтийн гаралтай инфляц алгуур саарах хандлагатай байсан бол нийлүүлэлтийн шалтгаантай инфляц мах, хүнсний ногоо зэрэг хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан өсөв. Харин импортын болон хүнснээс бусад дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт саарсан байна. Төв банкнаас мөнгөний бодлогын хүүг 2025 оны 3 дугаар сард 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 12 хувьд хадгалав.

Зээлийн өсөлт үргэлжлэн саарлаа. Арилжааны банкнуудын зээлийн жилийн өсөлт 2025 оны эцэст 18.9 хувьд хүрч саарсан байна. Шинээр олгосон зээлийн хувьд бизнесийн зээлийн өсөлт харьцангуй өндөр хадгалагдаж байгаа бол хэрэглээний зээлийн өсөлт буурчээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эргэн эрчимжиж, 10.6 хувьд хүрсэн бөгөөд үүнд дотоодын зээл голлон нөлөөлсөн хэвээр байна. Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 18.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин нийт хадгаламжийн өсөлт 2025 оны эцэст 16.4 хувьд хүрсний дийлэнх хэсгийг иргэдийн төгрөгийн хадгаламж бүрдүүлээ.

¹ Нэгдсэн төсвийн нийт зарлага сүүлийн 10 жилд дунджаар 16.6 хувиар, сүүлийн 5 жилд 18.1 хувиар өссөн байна.

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

Дэлхийн тодорхой бус байдал цаашид ч нэмэгдэх эрсдэлтэй байна. Дэлхийн тодорхой бус байдлын индекс 2025 оны 3 дугаар улиралд түүхэн дээд түвшинд хүрч, 4 дүгээр улиралд бага зэрэг саарсан ч сүүлийн 10 жилийн дунджаас 4 дахин өндөр түвшинд байна. Худалдааны дайн эргэн сэдэрч болзошгүй байгаа нь дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт, ОХУ-Украины дайн болон Ойрх Дорнодын тогтворгүй байдал зэрэг эдийн засаг, геополитикийн тогтворгүй байдлын эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвийг сулруулж болзошгүй байна.

Зэс, алтны үнийн өсөлт хадгалагдах төлөвтэй байгаа бол нүүрс, төмрийн хүдрийн үнэ сэргэх хандлага бага байна. Дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал нэмэгдэж, төв банкнуудын алт худалдан авалт өссөн нь аюулгүй хөрөнгийн эрэлтэд түлхэц болж, алтны үнийг өсөхөд хүргэлээ. Мөн цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүч, тоон өгөгдөл боловсруулах төвүүд, технологийн салбарын хурдацтай хөгжлөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж үнэ өсөхөөр байгаа бөгөөд 2025 онд зэсийн дундаж үнэ 9,200 ам.долларт хүрэх төлөвтэй байна. Харин худалдааны дайн болон БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналтаас шалтгаалан нүүрсний үнэ 2025 оны эхний хагас жилийн байдлаар 66 ам.доллар болж, 41 хувиар буураад байна. Олон улсын шинжээчид нүүрсний үнэ богино хугацаанд огцом сэргэхгүй гэж үзсэн тул 2025 онд нүүрсний дундаж үнэ 70 орчим ам.долларт хадгалагдах төлөвтэй байна.

Эдийн засгийн өсөлт 2026 онд 5.4 орчим хувь байхаар тооцоолж байна. Салбаруудаар авч үзвэл, хөдөө аж ахуй, барилгын салбарын үйлдвэрлэлийн өсөлт үргэлжилж, худалдаа үйлчилгээний салбарууд сэргэснээр эдийн засгийн өсөлтийг тэтгэхээр байна. Мөн, Оюу толгойн баяжмал дахь зэс, алтны агуулга нэмэгдэн дэлхийн зах зээл дээр эрэлттэй энэ үед өсөлтийг дэмжихээр байна. Эрэлт талаас томоохон төслийн хөрөнгө оруулалт болон цэвэр экспорт эдийн засгийн өсөлтийг үргэлжлүүлэн дэмжих хүлээлттэй байна. Харин Зээл олголтын хэмжээ өнгөрсөн оны түвшинд байж эдийн засгийн үйл ажиллагааны дотоод идэвхийг дэмжих хэдий ч инфляцын дарамт нэмэгдсэнээр эцсийн хэрэглээний өсөлт өмнөх оноос алгуур саарах төлөвтэй.

Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдийн өсөлтийн хурд саарах хандлагатай байна. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн нөлөөгөөр 2025 онд ажиллагчдын тоо нэмэгдэхээр хүлээгдэж байна. Энэхүү өсөлтөд нийт ажиллагчдын 4 хүн тутмын нэг нь ажиллаж буй хөдөө аж ахуйн салбарын сэргэлтээс шалтгаалан тус салбарын ажиллагчдын тоо нэмэгдэх нь голлон нөлөөлж, нийт ажил эрхлэлтийн өсөлтийг дэмжихээр байна.

Инфляц 2026 онд төв банкны зорилтоос өндөр байх төлөвтэй байна. Тухайлбал, дотоодын хүнсний үнийн өсөлт өндөр байгаагийн зэрэгцээ геополитикийн хурцадмал байдал, шатахууны үнийн хэлбэлзэл, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатал, гадаад инфляц зэргээс үүдэн инфляц өдөөгдөх эрсдэлүүд хадгалагдаж байна.

Бүлэг 1

БОДИТ СЕКТОР

- 1.1. Нийлүүлэлт
- 1.2. Эрэлт
- 1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж
- 1.4. Эдийн засгийн мөчлөг

1. БОДИТ СЕКТОР

ТОЙМ

Эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, нийлүүлэлт талаас уул уурхай, хөдөө аж ахуй, барилгын салбарын өсөлт эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол эрэлт талаас өрхийн хэрэглээ, цэвэр экспорт өсөлтийг дэмжив. Ажиллах хүчний оролцооны түвшин 62.3 хувьд хүрч, өрхийн бодит орлого 5 хувиар өссөн нь өрхийн хэрэглээг дэмжлээ. Уул уурхайн салбарын үйл ажиллагааны идэвхийн нөлөөгөөр нийт эдийн засгийн үйлдвэрлэлийн хэмжээ потенциал түвшнээс 1.4 хувь дээгүүр гарлаа.

1.1. Нийлүүлэлт

1. Эдийн засгийн өсөлт 6.8 хувьд хүрлээ. ДНБ 2025 онд нэрлэсэн дүнгээр 89.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар, бодит дүнгээр 34.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар нэмэгдэхэд хөдөө аж ахуйн салбарын сэргэлт болон уул уурхай, барилга, боловсруулах салбаруудын тогтвортой өсөлт голлон дэмжсэн бол худалдааны салбар агшсан нь өсөлтийг сааруулав.

2. Уул уурхайн салбарын өсөлт 10.6 хувьд хүрч сэргэн, нийт эдийн засгийн өсөлтийн 1.4 хувийг бүрдүүлэв. Уул уурхайн салбар оны эхний хагаст 1.1 хувийн өсөлттэй байсан бол нүүрс экспортын хэмжээ оны сүүл хэсэгт нэмэгдсэний нөлөөгөөр сэргэлээ. Түүнчлэн зэсийн баяжмал үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 36 хувиар, тухайлбал Оюу толгой гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр оны эхний гурван улиралд 42.2 хувиар өссөн нь уул уурхайн салбарын өсөлтийг дэмжив. Мөн төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн өсөлт хадгалагдаж 8.8 сая тоннд хүрснээр өмнөх оны мөн үеэс 31.8 хувиар өслөө. Нүүрс олборлолт оны эхний гурван улиралд агшилттай байсан ч 4 дүгээр улиралд нэмэгдсэнээр 95.5 сая тоннд хүрч 0.4 хувиар өслөө. Мөн алтны олборлолт 11 улирал дараалан буурч байснаас сэргэн 13.1 тоннд хүрч, 4.1 хувиар өсөв. Харин газрын тос олборлолт 8 улирал дараалан буурч 3.8 сая тонн болсноор уул уурхайн салбарын өсөлтийг саарууллаа.

3. Уул уурхайн бус салбар 6.3 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийг 5.4 нэгж хувийг бүрдүүлэв. Хөдөө аж ахуйн салбарын өсөлт хадгалагдаж, барилга, боловсруулах, эрчим хүчний салбарын өсөлт эрчимжлээ.

² Аж үйлдвэрийн салбарт уул уурхай, боловсруулах, цахилгаан, усан хангамжийн салбар орно. Тус хэсэгт уул уурхайн салбараас бусад аж үйлдвэрийн салбаруудыг хамруулан дүгнэв.

Үйлчилгээний салбаруудын өсөлтийн эрчим алгуур саарч байгаа бол худалдааны салбар оны эцэст агшилттай гарлаа.

4. Хөдөө аж ахуйн салбарын өсөлтийн эрчим өндөр хэвээр хадгалагдлаа. Бойжсон төлийн тоо толгой 21.7 саяд хүрч (төл бойжилт 96.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.5 сая толгой малаар нэмэгдэж, том малын зүй бус хорогдол 359 мянга болж, өмнөх оны мөн үеэс 9 сая толгой малаар буурснаар хөдөө аж ахуйн салбарын 90 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн өсөлтийн эрчим өндөр хэвээр хадгалагдлаа. Харин газар тариалангийн салбарын хувьд оны эхний хагаст тариалангийн гол бүс нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас унаснаар нийт хураасан үр тариа өмнөх оноос 148.6 мянган тонн, төмс 137.3 мянган тонн, хүнсний ногоо 42.5 мянган тонн, тэжээлийн ургамал 61 мянган тонноор тус тус буурч хөдөө аж ахуйн салбарын өсөлт 2025 онд урьдчилсан гүйцэтгэлээр 33.2 хувиар өсөж төсөөллийн орчимд гарсан бөгөөд нийт өсөлтийн 2.9 нэгж хувийг бүрдүүлээ.

5. Аж үйлдвэрийн салбарын² өсөлт эрчимжлээ. Боловсруулах салбарын өсөлт эрчимжиж, 2025 онд 10 хувиар өслөө. Үүнд төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл³, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл боловсруулах салбарын өсөлтийг голлон дэмжсэн байна.

Эрчим хүчний салбарын өсөлт тогтвортой хадгалагдаж 10.2 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийн 0.2 нэгж хувийг бүрдүүлэв. Үүнд шинээр ашиглалтад орсон Тосон, Бөөрөлжүүт зэрэг ДЦС-уудын үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөлөв. Тухайлбал, цахилгаан

³ Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд цемент, шохой, бетон, цемент болон гипсээр хийсэн бусад материал, чулуу засах, чулуун тавилга, галд тэсвэртэй бүтээгдэхүүн, барилгын шавран материал зэрэг үйлдвэрлэл орно.

эрчим хүч үйлдвэрлэл 9.6 тэрбум кВт цагт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар, дулааны эрчим хүч үйлдвэрлэл 17.3 сая Гкалд хүрч, 8.5 хувиар нэмэгдэн эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн өсөлт тогтвортой хадгалагдлаа.

Барилгын салбарын өсөлтийг Улаанбаатар хот дахь эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд, Сэлэнгэ аймаг дахь 70 МВт хүчин чадал бүхий дулааны цахилгаан станц, Дорнод аймгийн авто замын бүтээн байгуулалтын ажлууд зэрэг нь үргэлжлүүлэн тэтгэснээр 2025 онд 15.9 хувиар өслөө.

6. Үйлчилгээний салбарын өсөлт 2025 онд 2.0 хувьд хүрч, өмнөх улирлаас нэмэгдлээ. Үйлчилгээний салбарыг тээвэр, мэдээлэл, холбоо, худалдаа болон бусад үйлчилгээний салбарууд бүрдүүлдэг.

Тээврийн салбар 2025 онд 4.8 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 0.3 нэгж хувийг бүрдүүлэв. Зам, тээврийн салбар 2025 онд бүх төрлийн тээврээр нийт 146.4 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 10.3 хувиар нэмэгдсэн бөгөөд төмөр замын ачаа тээвэр 50 сая тоннд хүрч 8.7 хувиар, авто замын ачаа тээвэр 96.5 сая тоннд хүрч 10 хувиар, агаарын тээврийн ачаа 12.5 мянган тоннд хүрч 20 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөллөө. Нийт ачаа тээврийн 65.9 хувийг авто тээвэр, 34.1 хувийг төмөр замын тээвэр, 0.01 хувийг агаарын тээврийн ачаа эзэлж байна.

Мэдээлэл, холбооны салбар 7.2 хувиар өссөн бол үйлчилгээний бусад салбар 1.5 хувиар саарсан байна.

7. Бөөний болон жижиглэн худалдааны салбар 2025 онд 4.6 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг 0.6 нэгж хувиар саарууллаа.

Худалдааны салбарын нэрлэсэн борлуулалтын орлого 69.3 их наяд болж 0.6 хувиар өссөн бол бодит орлого 34.3 их наяд болж 4.4 хувиар удаашрав. 2025 оны байдлаар салбарын 27.2 хувийг хүнсний бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа бол 73 орчим хувийг хүнсний бус бүтээгдэхүүн бүрдүүлж байна. Хүнсний бүтээгдэхүүний борлуулалт 2025 онд 15 их наяд төгрөгт хүрч 5.3 хувиар нэмэгдсэн бол хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт 40 их наяд төгрөг болж өмнөх оноос 26.2 хувиар буурсан нь иргэдийн удаан эдэлгээт бараа бүтээгдэхүүний эрэлт буурч байгааг харуулж байна. Хүнсний бус бүтээгдэхүүний худалдан авалт буурахад машин тоног төхөөрөмж, мотоцикл, моторт тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэгийн худалдааны бууралт голлон нөлөөлөв. Дотоодын худалдаа эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг илэрхийлэх худалдан авалтын менежерийн индекс (ХМИ)⁴ 2025 оны төгсгөлд 46 хувь гарсан бөгөөд сүүлийн 4 улирал дараалан өсөж байна.


8. Бүтээгдэхүүний цэвэр татвар өмнөх оны түвшинд хадгалагдлаа. Дотоодын бараа, үйлчилгээ болон импортын бараанаас төвлөрсөн НӨАТ-ын орлого тус тус 13.5 хувь болон 1.0 хувиар өсөж, нийт НӨАТ-ын орлого 6.1 хувиар нэмэгдэв.

⁴ ХМИ 50-аас дээш байвал тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ өсөх хандлагатай байгааг харуулдаг бол 50-аас доош бол ерөнхийдөө буурах буюу уруудах хандлагатайг харуулдаг. Харин

яг 50 бол ямар нэг өөрчлөлт, хөдөлгөөн гараагүй байгааг илтгэдэг бөгөөд өнгөрсөн дөрвөн улирлын туршид агших мужид буюу 50-аас доош түвшинд байна.

Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт (нийлүүлэлт)


1. Өсөлт дэх салбаруудын оролцоо (нэгж хувь)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт дэх салбаруудын оруулах хувь нэмрийг харуулав.


2. Салбаруудын бодит өсөлт (хувь)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Салбаруудын бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлтийн хувийг харуулав.

3. Хөдөө аж ахуй (мянган толгой мал)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Төл бойжилт, том малын зүй бус хорогдлын хэмжээг харуулав.

1.2. Эрэлт

9. Өрхийн хэрэглээ болон цэвэр экспорт эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Эцсийн ашиглалтын аргачлалаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн 2025 онд 6.9 хувиар өслөө. Эцсийн хэрэглээ 5.7 хувиар өсөж, нийт өсөлтийг 5.3 нэгж хувиар дэмжсэн байна. Үүнд, төрийн хэрэглээ буурсан хэдий ч өрхийн бодит орлогын өсөлт оны турш тогтвортой хадгалагдсанаар өрхийн хэрэглээ 2025 онд 9.2 хувиар өссөн нөлөөлөв. Цэвэр экспорт оны эхний хагас жилд эдийн засгийн өсөлтийг бууруулах нөлөө үзүүлж байсан бол оны сүүл хагаст өнгөрсөн оны мөн үеэс 8.5 хувиар сайжран, нийт өсөлтийг 5.1 нэгж хувиар дэмжлээ. Харин нийт хөрөнгийн хуримтлал буурч, өсөлтийг 3.6 нэгж хувиар хязгаарласан байна.

10. Өрхийн хэрэглээний өсөлтийн хурд саарч байгаа хэдий ч сүүлийн 5 жилийн дунджаас дээгүүр хадгалагдаж байна. Өрхийн хэрэглээ 2025 онд 9.2 хувиар өсөж, өсөлтийн эрч өмнөх оноос алгуур удааширлаа. Өрхийн хүнсний хэрэглээний өсөлт алгуур эрчимжиж, хүнсний бус хэрэглээ саарав. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, ус, ундаа, тамхины хэрэглээ өсөж, хүнсний хэрэглээг голлон дэмжсэн байна. Хүнсний бус бараа, үйлчилгээний хэрэглээ 2025 онд 11.3 хувиар өсөж, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс удааширлаа. Хүнсний бус хэрэглээ удаашрахад хувцас, бөс бараа, гутал, амралт, аялал жуулчлалын зардлын бууралт нөлөөлөв.

11. Өрхийн бодит орлогын өсөлт алгуур саарч 5.0 хувь болсон ч, өсөлтийн түвшин сүүлийн 5 жилийн дунджаас дээгүүр байна. Ажиллагчдын тоо 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар, өрхийн цалингийн орлого нэрлэсэн дүнгээр 210.4 мянган төгрөгөөр тус тус өсөж, өрхийн орлогын өсөлтийг дэмжлээ. Төрийн албан хаагчийн цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэх шийдвэрийн голлох нөлөөгөөр өрхийн цалингийн орлогын өсөлт

оны туршид тогтвортой хадгалагдаж, өрхийн бодит орлогын өсөлтөд голлох нөлөө үзүүлээ. Түүнчлэн, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр өрхийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орлого нэмэгдэж, өрхийн орлогыг дэмжив. Харин тэтгэвэр, тэтгэмжийн орлого нэрлэсэн дүнгээр 29.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн ч бодит дүнгээр өсөлтийг 0.7 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлэв. Тэтгэвэр, тэтгэмжийн орлогын бууралттай уялдуулан Засгийн газрын 2025 оны 242 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 769.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 652.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 2026 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж, мөрдөхөөр батлав. Мөн "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2025 оны 241 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэврийн сард олгох хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 16 насанд хүрсэн одой иргэнд олгох нийгмийн халамжийн тэтгэврийн сард олгох хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж 478.0 мянган төгрөгөөр, ахмад настан, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэгт олгох нийгмийн халамжийн тэтгэврийн сард олгох хэмжээг 8.6 хувиар нэмэгдүүлж 432.0 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон. Дээрх шийдвэрүүд 2026 онд өрхийн тэтгэвэр, тэтгэмжийн орлогын өсөлтийг дэмжих хүлээлттэй байна.

12. Хөдөөгийн өрхийн орлогын өсөлт эрчимжлээ. Манай улсын нийт өрхийн 30 хувь нь хөдөө, орон нутагт амьдарч байна. Хөдөөгийн өрхийн орлогын 37 хувийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орлого, 21 хувийг тэтгэвэр тэтгэмж, 20 орчим хувийг цалингийн орлого

бүрдүүлж байна. Өнгөрөгч 2024 оны зудын улмаас хөдөө аж ахуйн орлого буурсан. Уг суурийн нөлөөгөөр 2025 онд хөдөө аж ахуйн орлого нэмэгдэж, хөдөөгийн өрхийн орлогыг дэмжлээ. Түүнчлэн, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн албан хаагчид үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төвийн суманд 20 хувиар тус тус тооцож орон нутгийн нэмэгдэл олгох бодлогын шийдвэр гаргасан. Уг шийдвэрийн нөлөөгөөр хөдөөгийн өрхийн орлогод эзлэх цалин хөлсний орлогын хувь хэмжээ алгуур нэмэгдэж, өрхийн орлогыг дэмжиж байна.


13. Үндсэн хөрөнгийн хуримтлал тогтвортой өсөж байгаа боловч эргэлтийн хөрөнгө буурснаар нийт хөрөнгийн хуримтлал буурлаа. Хөрөнгийн хуримтлал нь тайлант хугацаанд эдийн засагт шинээр нэмэгдсэн болон хорогдсон үндсэн болон эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийг харуулдаг. Үндсэн хөрөнгө 2025 онд 9.0 хувиар нэмэгдсэн бол эргэлтийн хөрөнгө 56.1 хувиар буурснаар нийт хөрөнгийн хуримтлал 7.2 хувиар агшлаа. Үндсэн хөрөнгийн өсөлтөд орон сууцны барилга байгууламжийн нөөц бодитоор 29.1 хувиар, орон сууцны бус барилга 19.6 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөлөв. Мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл тогтворжсоноор өмнөх онд

бууралттай байсан биологийн өсөж үрждэг хөрөнгө өсөлттэй гарч хөрөнгийн хуримтлалыг дэмжлээ. Харин уул уурхайн ашигт ажиллагаа саарсны нөлөөгөөр машин тоног төхөөрөмжийн нөөц өмнөх оны мөн үеэс 12.2 хувиар буурсан байна. Эргэлтийн хөрөнгө буюу бараа, материал, дусаагүй үйлдвэрлэлийн нөөц өмнөх онд нэрлэсэн дүнгээр 6.8 их наяд төгрөгтэй тэнцэж байсан бол 2025 онд 3.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 55 хувиар агшиж, нийт хөрөнгийн хуримтлалыг бууруулав. Үүнд нүүрсний үнийн бууралттай холбоотой овоолгын үнэлгээ буурсан, худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа удааширч татан авалт багассан зэрэг голлон нөлөөллөө.

14. Үйлчилгээний экспорт нэмэгдэж, барааны импорт буурснаар цэвэр экспортын сөрөг нөлөө саарав. Цэвэр экспорт нь бараа, үйлчилгээний экспортын орлого болон бараа, үйлчилгээний импортын зардлын зөрүүгээр илэрхийлэгддэг. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ нэмэгдэж, бараа үйлчилгээний экспорт өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өсөж, нийт өсөлтөд 4.0 нэгж хувийг бүрдүүллээ. Мөн өнгөрсөн оны өндөр суурийн нөлөөгөөр бараа, үйлчилгээний импорт буурснаар нийт өсөлтийг 1.1 нэгж хувиар дэмжсэн байна.


Зураг 1.2. Бодит ДНБ-ий өсөлт (эрэлт талаас)

1. Эдийн засгийн өсөлт
(нэгж хувь)




Эх сурвалж: ҮСХ
Тэмдэглэл: Жилийн өсөлтөд оруулсан хувь
НЭМЭР.

2. Өрхийн бодит орлогын өсөлт
(нэгж хувь)



Эх сурвалж: ҮСХ
Тэмдэглэл: Жилийн өсөлтөд оруулсан хувь
НЭМЭР.

3. Үндсэн хөрөнгийн өсөлт
(нэгж хувь)



Эх сурвалж: ҮСХ
Тэмдэглэл: Жилийн өсөлтөд оруулсан хувь
НЭМЭР.

1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж

11. Хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын ажиллагчдын өсөлт нийт ажиллагчдын өсөлтийг дэмжлээ. 2025 оны 4 дүгээр улиралд ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 30 мянгаар нэмэгдэж 1 сая 384 мянгад хүрлээ. Үүнд хөдөө аж ахуйн салбарын өсөлт хадгалагдсанаар салбарын ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 30 мянгаар нэмэгдсэн, уул уурхайн салбарын ажиллагчид өмнөх оны мөн үеэс 25 мянгаар нэмэгдэж буюу 39 хувиар өсөж 93 мянгад хүрсэн нь нийт ажиллагчдын тооны өсөлтийг голлон тайлбарлаж байна. Түүнчлэн боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарын ажиллагчид 19 мянгаар нэмэгдсэн нь өсөлтийг дэмжсэн байна. Харин худалдааны салбарын бууралтын нөлөөгөөр салбарын ажиллагчид өмнөх оны мөн үеэс 23 мянгаар буюу 12 хувиар буурч 166 мянгад, тээврийн салбарын ажиллагчид 12 мянгаар буюу 14 хувиар буурч 69 мянгад хүрсэн нь өсөлтийг сааруулсан байна.

Байршлаар авч үзвэл, ажиллагчдын тоо Улаанбаатар хотод өмнөх оны мөн үеэс 36 мянгаар өсөж 642 мянга, харин хөдөөд 5 мянгаар буурч 742 мянга болсон байна. Тодруулбал, ажиллагчдын тоо Хангайн болон Зүүн бүсэд тус тус 4 мянган хүнээр нэмэгдсэн байна. Харин Баруун бүсэд ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 12 мянга, Төвийн бүсэд 1 мянгаар буурсан үзүүлэлттэй байна.


12. Ажиллах хүч нэмэгдсэнээр ажиллах хүчний оролцооны түвшин өсөв. Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 38 мянгаар буюу 2.6 хувиар өсөж 1 сая 466 мянгад хүрэв. Энэхүү өсөлтийн дийлэнх хэсгийг ажиллагчдын тооны өсөлт тайлбарлаж байгаа бол нөгөө талаас ажилгүй иргэд мөн өмнөх оны мөн үеэс 7 мянган хүнээр буюу 10 хувиар өсөж 83 мянга болсон нь ажиллах хүчний өсөлтийг дэмжсэн байна. Ажилгүй иргэдийн тоог шалтгаанаар авч үзвэл тухайн жилд сургууль төгссөн шалтгаанаар ажилгүй байсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.5 мянга, мэргэжил, дадлага туршлага байхгүй шалтгаанаар ажилгүй байсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.6 мянгаар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй шалтгаанаар ажилгүй байсан иргэдийн тоо нийт 2 мянгаар буурсан байна. Нөгөө талаас ажил хайгаад олдохгүй байгаа иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 7 мянгаар нэмэгдсэн байна.

Ажилгүй иргэдийн тоо өссөнөөр ажилгүйдлийн түвшин 5.6 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өссөн байна. Ажиллах хүчний өсөлт ийнхүү нэмэгдсэнээр ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өсөж 62.3 хувь болжээ.

13. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам өслөө. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 17 мянган хүнээр буюу 2 хувиар нэмэгдэж


Зураг 1.3. Хөдөлмөрийн зах зээл

1. Ажиллагчдын тоо, ажиллах хүчний оролцооны түвшин (мянган хүн, хувь)



Эх сурвалж: ҮСХ

2. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн)



Эх сурвалж: ҮСХ

3. Хөдөлмөрийн бүтээмж (мянган төгрөг)



Эх сурвалж: ҮСХ

886 мянгад хүрсэн байна. Шалтгаанаар харвал суралцдаг, тэтгэвэрт гарсан, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 38 мянгаар нэмэгдсэн бол мэргэжил, дадлага туршлага байхгүй, мэргэжилд тохирох ажил олдохгүй, тухайн жил сургууль төгссөн, ажиллах сонирхолгүй байсан, байгууллага татан буугдсан, ажил хайгаад олдохгүй байсан зэрэг шалтгаантай иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.5 мянгаар буурсан байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амыг задлан харвал боломжит ажиллах хүч буюу хөдөлмөр эрхлэх сонирхолтой хэдий ч боломжгүй байсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 21 мянгаар буюу 188 хувиар, бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам 3 мянгаар буюу 0.4 хувиар тус тус нэмэгдсэн байна.

14. Нэрлэсэн дундаж цалин өссөн хэдий ч бодит цалингийн өсөлт сул хэвээр байна. 2025 оны 4 дүгээр улиралд дундаж цалин өмнөх оны мөн үеэс 205 мянган төгрөгөөр өсөж 2 сая 878 мянган төгрөг, голч цалин өмнөх оны мөн үеэс 253 мянган төгрөгөөр өсөж 2 сая 482 мянган төгрөгт хүрсэн байна. Харин 2020 оны нэрлэсэн дундаж цалинг суурь болгон тооцвол дундаж цалингийн хэмжээ 117 хувиар өссөн бол худалдан авах чадварыг илэрхийлэх хэрэглээний үнийн түвшнээр засварлагдсан бодит цалингийн өсөлт 2020 оноос хойш 32 хувиар өссөн нь нэрлэсэн цалингийн өсөлттэй харьцуулахад өсөлт сул байна.

Салбараар авч үзвэл, боловсруулах, цахилгааны салбарын цалингийн хэмжээ хамгийн өндөр өсөлттэй байв. Түүнчлэн тээвэр, ус хангамж, мэргэжлийн болон техникийн үйл ажиллагааны салбарын дундаж цалин өссөн үзүүлэлттэй байна. Харин нөгөө талаас олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарын дундаж цалингийн хэмжээ 18 орчим хувиар буурч 4 сая 53 мянгад хүрсэн байна.

15. Хөдөлмөрийн бүтээмж уул уурхайн бус салбаруудад өслөө. Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин өмнөх оны мөн үеэс 466 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар өсөж, 6 сая 881 мянган төгрөгт хүрлээ. Салбараар авч үзвэл, хөдөө аж ахуйн салбарын бүтээмж 281 мянган төгрөгөөр буюу 19.2 хувиар, үйлчилгээний салбар 573 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар, аж үйлдвэрийн салбар 604 мянган төгрөгөөр буюу 7.6 хувиар тус тус өссөн байна. Харин хөдөлмөрийн бүтээмж хамгийн өндөр уул уурхайн салбарын ажиллагчдын тоо нэмэгдсэнээр бүтээмжийн түвшин 2 сая 933 мянган төгрөгөөр буюу 19.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

16. Шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдлээ. 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 263.4 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 583 - аар буюу 0.2 хувиар буурлаа. Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-үүд өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар нэмэгдсэн бол, үйл ажиллагаа зогсоосон болон олдохгүй байгаа аж ахуйн нэгжүүд 10.9 хувиар буурсан байна. Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо буурсан хэдий ч идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж буй нь эдийн засгийн идэвхжилттэй байгааг харуулж байна. (Зураг 1.4).

17. Худалдаа, үйлчилгээний салбарын ААН-ийн тоо нэмэгдэв. Салбараар харвал, худалдаа, үйлчилгээний салбарт шинээр байгуулагдсан ААН өмнөх оны мөн үеэс 2.6 мянгаар, үйл ажиллагаа явуулж буй ААН 4.6 мянгаар нэмэгдсэн нь ААН-ийн тооны өсөлтийн гол хэсгийг бүрдүүлж байна. Тодруулбал, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгч шинээр байгуулагдсан болон үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд 4.2 мянгаар, мэргэжлийн, шинжлэх ухааны салбарын ААН-үүд 932 оор, зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа эрхэлдэг ААН үүд 540 өөр, үйлчилгээний бусад үйл

ажиллагаа эрхэлдэг ААН үүд 419 ээр нэмэгдсэн нь гол жинг эзэлж байна.

18. Шинэ хоршоо хөдөлгөөний нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар дахь хоршоодын тоо нэмэгдэв. Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолоор хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотойгоор 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар хөдөө аж ахуйн салбарт шинээр бүртгэгдсэн ААН тоо өмнөх оны мөн үеэс 1069 аар нэмэгдсэн байна.

19. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй бусад салбаруудын өсөлт саарч байна. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад уул уурхайн салбар 102, тээврийн салбарт 757-р, барилгын салбар 708, боловсруулах үйлдвэрлэл 999-р аж ахуйн нэгжээр нэмэгджээ. Тодруулбал, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 38-р шинээр байгуулагдсан ААН тоо 64-р, барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 408-р шинээр байгуулагдсан ААН тоо 300-р,

боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй ААН ийн тоо 570-р, шинээр байгуулагдсан ААН 429-р тус тус нэмэгдсэн байна.

20. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч жижиг ААН-үүд нэмэгдлээ. Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 116.8 мянган ААН-ийн 86.8 хувь буюу 101.4 мянган ААН 1-9 ажилтантай байна. ААН тоо өмнөх оны мөн үеэс 6.7 мянгаар нэмэгдсэнээс 6.5 мянга нь 1-9 ажилтантай жижиг ААН байна. Харин 10-19 ажилтантай ААН 6.9 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 211 ААН-ээр нэмэгдэхэд хөдөө аж ахуй, үйлчилгээ, боловсруулах салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүд нэмэгдсэн нь нөлөөллөө. Харин үйл ажиллагаа явуулж буй 20-49 ажилтантай ААН 23-аар, 50-аас дээш ажилтантай ААН 6-аар нэмэгдсэн байна (Зураг 1.4).

Зураг 1.4. Аж ахуйн нэгж

Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-ийн тооны өөрчлөлт, салбараар (ААН-ийн тоо)




Эх сурвалж: ҮСХ

Нийт бүртгэлтэй ААН-ийн тоо (мянга)



Эх сурвалж: ҮСХ

Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлт, ажиллагчдын тоогоор



Эх сурвалж: ҮСХ

Шигтгээ 1. Хэрэглэгчийн итгэлийн индекс

2025 оны 4 дүгээр улиралд хэрэглэгчдийн ирээдүйн хүлээлт муудаж Хэрэглэгчийн итгэлийн индекс 91.9-д хүрснээр өмнөх оны мөн үеэс 12.8 нэгжээр буурлаа.


Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК) болон Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс тооцон гаргадаг Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ)-ээр эдийн засгийн ерөнхий байдал болон өрхийн санхүүгийн байдлын талаар хэрэглэгчид хэр зэрэг өөдрөг бодолтой байгааг хэмждэг. Хэрэглэгчийн итгэлийн индекс нь Өнөөгийн байдлын индекс /бизнесийн нөхцөл, ажлын олдоц/, Ирээдүйн хүлээлтийн индекс /бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлого/ гэсэн 2 дэд индекс /5 үзүүлэлтээс бүрдэх/-ээр тооцогдож байна. Ингэхдээ улс даяар санамсаргүй түүврийн аргаар хэрэглэгчдээс санал асуулга авч 0-200-ийн хооронд үнэлдэг бөгөөд индекс 200-д дөхөх тусам хэрэглэгчийн итгэл өндөр, 0-д дөхөх дусам хэрэглэгчийн итгэл сул, харин индекс 100-тай тэнцүү үед эдийн засаг хэвийн байна гэж үздэг.

ХИИ 2025 оны 4 дүгээр улиралд 91.9-д хүрэхэд иргэдийн ирээдүйн хүлээлт муудсан голчлон нөлөөллөө. Индексийн үнэлгээг бүрэлдэхүүн хэсгээр задалж Хүснэгт 2-т үзүүлэв.

Өнөөгийн байдлын индекс: Ажлын олдоцын үнэлэмж сайжирсан ч Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 10.6 нэгжээр буурсан. Өнөөгийн байдлын индекс нь иргэд эдийн засгийн одоогийн нөхцөл байдлыг бизнесийн нөхцөл болон ажлын олдоц хэр байгаагаар үнэлснээр хэмждэг. 2025 оны 4 дүгээр улиралд Өнөөгийн байдлын индекс 116.5-д хүрч буурахад ажлын олдоц “сайн” гэж үнэлсэн иргэд өмнөх оны мөн үеэс 2.8 нэгжээр буурсан нь нөлөөллөө. Харин бизнесийн нөхцөлийг “сайн” гэж үнэлсэн иргэд 5.4 нэгжээр буурсан байна.

Ирээдүйн хүлээлтийн индекс: Хэрэглэгчдийн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлт муудаж Ирээдүйн хүлээлтийн индекс өмнөх оны мөн үеэс 5.1 нэгжээр буурлаа. Ирээдүйн хүлээлтийн индекс нь эдийн засгийн ойрын ирээдүйн нөхцөлийг иргэд хэрхэн харж буйг бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлтийн үнэлгээгээр хэмждэг. 2025 оны 4 дүгээр улиралд Ирээдүйн хүлээлтийн индекс 83.9-д хүрч буурахад ирэх 6 сард бизнесийн нөхцөл “сайн” болон “муу” байна гэж үнэлсэн иргэд өмнөх оны мөн үеэс тус тус 5.4 0.7 нэгжээр буурсан (нэмэгдсэн) нөлөөллөө. Түүнчлэн, хэрэгдэгчдийн ирэх 6 сарын ажлын олдоц болон орлогын хүлээлт мөн адил гутранги байна. Тухайлбал ажлын олдоц “сайн” байна гэж үнэлсэн иргэд 9.9 нэгжээр буурч, “муу” гэж үнэлсэн иргэд 1.3 нэгжээр нэмэгджээ. Мөн орлого “сайн” байна гэж үнэлсэн хэрэглэгчид өмнөх оны мөн үеэс 3.2 нэгжээр буурч, харин орлого “муу” байна гэсэн иргэд 2.4 нэгжээр нэмэгджээ.

Зураг 1.5. Хэрэглэгчийн итгэлийн индекс улирлаар (2018=100)



Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний (Эн-Ар-Си-Си)

Тайлбар: ХИИ болон түүний бүрэлдэхүүн индексүүдийн нөлөөгөөр засварлаж 2018 оны 4 дүгээр улиралд индексийг харьцуулж тооцсон б

Хүснэгт 1.1. Хэрэглэгчийн итгэлийн индексийн бүрэлдэхүүн

	2024.IV	2025.IV	Өөрчлөл
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ▼			
<i>Бизнесийн нөхцөл</i>			
Сайн	10.9	5.5	-5.4 ▼
Хэвийн	36.0	41.2	
Муу	51.0	52.4	1.4 ▲
<i>Ажлын олдоц</i>			
Сайн	36.0	33.2	2.8 ▲
Хэвийн	31.4	37.7	
Муу	30.0	27.1	-2.9 ▼
ИРЭЭДҮЙН ХҮЛЭЭЛТ ▼			
<i>Бизнесийн нөхцөл ▼</i>			
Сайн	16.6	11.0	-5.4 ▼
Хэвийн	57.1	62.3	
Муу	23.4	22.7	0.7 ▲
<i>Ажлын олдоц ▼</i>			
Сайн	27.6	17.7	-9.9 ▼
Хэвийн	53.8	61.8	
Муу	15.9	17.2	1.3 ▲
<i>Орлого ▼</i>			
Сайн	21.7	18.5	-3.2 ▼
Хэвийн	60.7	66.5	
Муу	15.6	13.2	-2.4 ▼

Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК)

1.4. Эдийн засгийн мөчлөг

21. Үндсэн хөрөнгийн хуримтлалын өсөлт нь потенциал үйлдвэрлэлийг дэмжсэн хэвээр байна.


Барилгын бүтээн байгуулалтын ажил эрчимжсэнээр үндсэн хөрөнгийг хуримтлал 2025 онд 9.0 хувиар өсөж, потенциал үйлдвэрлэлийг голлон дэмжлээ. Тухайлбал, Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр зам болон орон нутаг дах авто зам, эрчим хүч зэрэг орон сууцны бус барилгын ажлууд үндсэн хөрөнгийн хуримтлалын өсөлтийг 7.0 нэгж хувиар дэмжив. Мөн Улаанбаатар хот, Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь, Ховд, Орхон зэрэг аймгуудад орон сууцны барилгын ажил нэмэгдэж, үндсэн хөрөнгийн хуримтлалыг 4.2 нэгж хувиар дэмжлээ. Орон сууцны бүтээн байгуулалтууд хүн ам ихтэй аймгуудад нэмэгдэх хандлагатай байгаа нь цаашид үндсэн хөрөнгийн хуримтлал эергээр нөлөөлөх хандлагатай байна. Харин, өмнөх оны машин, тоног төхөөрөмжийн суурийн өндөр нөлөө үндсэн хөрөнгийн хуримтлалыг сааруулах нөлөө үзүүлэв. Түүнчлэн, тайлант онд цаг агаар таатай байж, биологийн өсөж үрждэгийн хөрөнгө нэмэгдсэнээс гадна, хөдөө аж ахуйн салбар дах ажиллагчдын тоо нэмэгдэж,

хөдөлмөрийн зах зээлийн өсөлтийг дэмжсэн нь потенциал үйлдвэрлэлийн өсөлтөд эергээр нөлөөллөө. Потенциал үйлдвэрлэлийн өсөлтийн хурд тайлант онд 5-6 орчим хувьд хүрч, өнгөрсөн оноос сайжирлаа.

22. Уул уурхайн салбар сэргэж, аж үйлдвэрийн салбарын идэвх сайжирснаар нийт үйлдвэрлэл потенциал түвшнээс дээгүүр байна. 2025 оны эхний улирал уул уурхайн биржийн идэвх суларч, түүхий эдийн экспортын үнэ буурснаар олборлолт буурч, үйлдвэрлэл сөрөг зөрүү нэмэгдээд байв. Харин 2025 оны 2 дугаар улирлаас биржийн идэвх сайжирч, экспортын түүхий эдийн үнэ алгуур өссөнөөр үйлдвэрлэл сэргэж, уул уурхай, тээврийн салбарын үйлдвэрлэл потенциаллаас дээгүүр гарлаа. Уул уурхайн бус салбарын үйлдвэрлэлийн зөрүү 2025 оны 4 дугаар улиралд аж үйлдвэрийн салбарын идэвхжил нэмэгдсэний нөлөөгөөр потенциалын орчимд гарав. Ингэснээр нийт үйлдвэрлэл потенциал түвшнээс 1.4 хувиар дээгүүр байна.

Зураг 1.6. Үйлдвэрлэлийн зөрүү

1.Потенциал ДНБ-ий өсөлт
(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Потенциал үйлдвэрлэлийг нэг хувьсагчтай шүүлтүүр буюу Ходрик-Прескотт, олон хувьсагчтай шүүлтүүр буюу Калман шүүлтүүр болон үйлдвэрлэлийн функцийн аргачлалаар тус тус тооцов.

2.Үйлдвэрлэлийн зөрүү

(потенциал ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Үйлдвэрлэлийн зөрүүг бодит болон потенциал ДНБ-ий зөрүүгээр тооцно. Үйлдвэрлэлийн зөрүүг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP загварт тулгуурлан олон хувьсагчийн Калманы шүүлтүүрийн аргаар тооцов.

Бүлэг 2

ТӨСВИЙН СЕКТОР

2.1. Төсвийн гүйцэтгэл

2.2. Төсвийн бодлогын төлөв

2.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

2. ТӨСВИЙН СЕКТОР

ТОЙМ

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого болон татварын бус орлогын өсөлтийн нөлөөгөөр 2025 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 30.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.4 их наяд төгрөг буюу 1.3 хувиар өссөн байна. Нөгөө талаас, төсвийн нийт зарлага 31.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.7 их наяд төгрөг буюу 2.3 хувиар өссөн байна. Үүнд урсгал зарлагын өсөлт, тэр дундаа төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгал болон халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Улмаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 35.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 39.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.0 их наяд төгрөг буюу 5.9 хувиар өслөө. Гадаад өрийн эргэн төлөлт 2025 онд 391.8 сая ам.доллар, 2026 онд 978 сая ам.доллар, 2027 онд 918.5 сая ам.доллар, 2028 онд хамгийн өндөр буюу 1,078.5 сая ам.долларын өрийн төлбөр хүлээгдэж байна.

2.1. Төсвийн гүйцэтгэл

23. Нэгдсэн төсвийн орлогын өсөлт өмнөх онтой харьцуулахад саарлаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 32.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өссөн хэдий ч 2024 оны төсвийн орлогын өсөлттэй харьцуулахад 25.2 нэгж хувиар буурсан байна.

Үндэсний баялгийн санд 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2.0 их наяд төгрөг төвлөрч, өмнөх оны мөн үеэс 0.7 их наяд төгрөг буюу 51.0 хувиар өссөн байна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Ирээдүйн өв санд 2025 онд 40 хувиар буюу өмнөх оноос 2 дахин их хуваарилалт хийхээр 2025 оны төсвийн тухай хуулиар батлагдсан нь баялгийн сангийн орлогын хуримтлалыг нэмэгдүүлэхэд нөлөөллөө.

Төсвийн тогтворжуулалтын санд 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 562.5 тэрбум төгрөг төвлөрч, өмнөх оны мөн үеэс 118.6 тэрбум төгрөг буюу 26.7 хувиар өссөн байна. Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ, тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсантай холбогдуулан зөвхөн зэсийн орлогоос санд хуримтлагдсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 30.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 их наяд төгрөг буюу 1.3 хувиар өссөн байна. Тэнцвэржүүлсэн орлогын өсөлт өмнөх онтой харьцуулахад 26.1 нэгж хувиар буурсан бөгөөд үүнд уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх орлого 9.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн онтой харьцуулахад 12.8 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.

24. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа харьцангуй идэвхэжсэн хэдий ч нүүрсний үнийн уналтаас шалтгаалан ААНОАТ болон АМНАТ-ийн орлого буурлаа. Нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдсэн хэдий ч оны эхнээс үргэлжилсэн нүүрсний үнийн уналтаас ([Гадаад сектор бүлгийн 62-р хэсэг](#)) шалтгаалан уул

уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаа саарч, татварын орлогын төвлөрүүлэлт өмнөх оны мөн үеэс буурахад нөлөөлсөн. 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр ААНОАТ 5,664.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 754.5 тэрбум төгрөг буюу 11.8 хувиар, АМНАТ-ийн орлого 2,350.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1,186.8 тэрбум төгрөг буюу 33.6 хувиар тус тус буурсан байна. Нэгдсэн төсвийн орлогын 30 орчим хувийг, ААНОАТ-ын 50 гаруй хувийг уул уурхайн салбар төвлөрүүлдэг бөгөөд гадаад нөхцөл байдал, нүүрсний үнийн бууралт төсвийн орлого төвлөрүүлэлтэд эрсдэл дагуулсан хэвээр байна.

25. Ажиллагсдын тоо, цалин хөлс нэмэгдсэнээр хөдөлмөр эрхлэлтэд суурилсан татварын орлогыг дэмжиж, ХХОАТ болон Нийгмийн даатгалын орлого өслөө. 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийгмийн даатгалын орлого 5.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 892.3 тэрбум төгрөг буюу 18.9 хувиар, ХХОАТ-ын орлого 3.0 их наяд төгрөгт хүрч, 334.6 тэрбум төгрөг буюу 12.7 хувиар тус тус өссөн байна.

Энэхүү өсөлтөд хөдөлмөр эрхлэлтийн түвшин болон даатгуулагчдын тоо нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Тухайлбал, нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчдын тоо 1,181.0 мянга хүрч өмнөх оны мөн үеэс 19 мянгаар буюу 1.7 хувиар, сайн дураар даатгуулагчдын тоо 170.0 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 21.2 хувиар өссөнөөр нийт даатгуулагчдын тоо 1,350.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өссөн байна.

Түүнчлэн, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4,715 төгрөг буюу сард 792 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.” Өмнөх зохицуулалтаар 660 мянган төгрөгийн цалингаас дунджаар 89.1 мянган төгрөг НДШ-д

төлдөг байсан бол дээрх шийдвэрээр 106.3 мянган төгрөгийн төлөхөөр болсон нь нэрлэсэн цалингийн өсөлтийг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтэд суурилсан татварын орлогын өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн байна.

26. НӨАТ-ын орлого төвлөрөлт өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдаж байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар өссөн нь дотоодын зах зээлийн худалдан авах чадвар харьцангуй тогтвортой байгааг илтгэж байна.

Тухайлбал, дотоодын барааны НӨАТ өмнөх оны мөн үеэс 342.0 тэрбум төгрөг буюу 13.5 хувиар, импортын барааны НӨАТ 38.6 тэрбум төгрөг буюу 1.0 хувиар тус тус өссөн байна. Импортын эрэлт саарсан хэдий ч импортын НӨАТ болон импортын гаалийн албан татварын орлого өмнөх оны түвшинд хадгалагдсан байна.

27. Суудлын автомашины улсын бүртгэлийн дугаар олгох хязгаарлалттай холбоотойгоор импортын суудлын автомашины тоо хэмжээ буурч, онцгой албан татварын орлого буурлаа.

Онцгой албан татварын орлого 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 955.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 152.3 тэрбум төгрөгөөр буюу 13.8 хувиар буурсан байна. Үүнд суудлын автомашины онцгой албан татварын орлогын бууралт голлон нөлөөлсөн бөгөөд жилийн эцэст 417.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 164.4 тэрбум төгрөгөөр буюу 28.2 хувиар буурсан байна.

Нийслэлийн Засаг даргын “Нийслэл хотод авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгох шалгуур үзүүлэлтийг батлах тухай” А/1348 дугаар захирамжаар суудлын автомашины улсын дугаар олголтыг хязгаарлах шийдвэртэй холбоотойгоор импортын суудлын автомашин тоо хэмжээ өмнөх оноос 32.7 мянган ширхгээр буюу 26.6 хувиар буурч, үнийн дүн 5.5 хувиар нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл 10 жилээс дээш насжилттай, он хуучин, бага үнэтэй суудлын автомашины тоо хэмжээг хязгаарласнаар импортын суудлын автомашины тоо хэмжээ буурч улмаар онцгой албан татварын орлого буурахад голлон нөлөөлсөн байна.


Зураг 0.1. Төсвийн орлого

1.Төсвийн нийт орлого, бүрэлдэхүүнээр (их наяд төгрөг)




Эх сурвалж: Сангийн яам

2.Нийт орлогын өсөлтөд эзлэх хувь, салбараар (хувь)



Эх сурвалж: Сангийн яам

3.Татварын орлогын өсөлтөд эзлэх хувь, төрлөөр (хувь)



Эх сурвалж: Сангийн яам

28. Төсвийн тодотголоор нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийг хязгаарлалаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 31.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өссөн хэдий ч 2024 оны төсвийн зарлагын өсөлттэй харьцуулахад 33.6 нэгж хувиар буурсан байна.

Олон улсын геополитикийн нөхцөл байдал, худалдаа, эдийн засгийн тодорхойгүй байдлын улмаас 2025 эхний 5 сард манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 39.0 хувиар унаж, төсөвт төвлөрөх орлогын хэмжээ төлөвлөснөөс 3.3 их наяд төгрөгөөр дутаж, нийт зардлыг хангах боломжгүй нөхцөл байдал бий болсон. Иймд төрийн зардлыг бууруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээг төсвийн тодотголын хүрээнд авч хэрэгжүүлэхээр 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн төсвийн тодотголоор нийт зардлыг 31,573.9 тэрбум төгрөгөөр баталж, анх батлагдсан дүнгээс 1,858 тэрбум төгрөг буюу 5.6 хувиар бууруулсан.


29. Өрхийн орлогыг дэмжих зорилгоор цалин, тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн нь нийт зардлын өсөлтийн голлох шалтгаан боллоо. Төсвийн урсгал зардал 24.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.0 их

наяд төгрөг буюу 9.1 хувиар өссөн нь нийт зарлагын өсөлтөд голлох нөлөө үзүүлээ. Тодруулбал, нийт зардлын өсөлтийн ойролцоогоор 70 хувийг цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт дангаараа тайлбарлаж байна. Монгол Улсын Засгийн газраас нийт төрийн албан хаагчдын цалинг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дунджаар 6.0 хувиар нэмэгдүүлсэн, мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн итгэлцүүрийг 2025 онд шинэчилснээр тэтгэврийн зөрүүг бууруулж, уг сууриас тэтгэврийг 2025 оны 1 дүгээр сараас 6 хувь тус тус нэмэгдүүлсэн нь урсгал зардлын өсөлтөд голлон нөлөөлжээ.

30. Төсвөөс олгож буй татаасны дийлэнх хувийг нийтийн тээврийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар олголоо. Нэгдсэн төсвөөс 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт 799.5 тэрбум төгрөгийн татаас олгосон нь өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар буурсан байна. Төрөөс хувийн хэвшилд олгосон татаасны хэмжээ 657.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өссөн хэдий ч төрийн өмчит байгууллагад олгох татаас 54.8 хувиар буурсан байна. Тодруулбал, нийтийн тээврийн алдагдалд олгосон татаас 340.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 17.7 хувиар, зээлийн хүүгийн татаас 63.3 тэрбум


Зураг 02.2. Төсвийн зарлага

1. Төсвийн зарлагын эдийн засагт харьцах харьцаа (хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Нэгдсэн төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувиар тооцов.

2. Төсвийн зарлага, эдийн засгийн ангиллаар (нэгж хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Нэгдсэн төсвийн зарлагын тэлэлтэд эдийн засгийн ангилал тус бүрийн эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс өссөн дүнгээр тооцов.

3. Төсвөөс олгосон нийт татаасны өсөлт, зориулалтаар (нэгж хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Нэгдсэн төсвөөс төрийн өмчит болон хувийн байгууллагад олгосон татаасны өсөлтөд зориулалт тус бүрийн эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс өссөн дүнгээр тооцов.

төгрөгт хүрч, 21.5 хувиар тус тус өссөн байна. Нийтийн тээврээр зорчих үнийг хоёр дахин нэмэгдүүлж өдөрт 1,000 төгрөг болгон цагийн хязгаарлалтгүй дөрвөн удаа зорчих шинэ зохицуулалт 2025 оны нэгдүгээр сараас эхлэн хэрэгжиж эхэлсэн хэдий ч нийтийн тээврийн алдагдалд олгох төсвийн татаас өсөлттэй хэвээр байна.

31. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардал буурлаа. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардал 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар буурсан байна. Эдийн засгийн ангиллаар авч үзвэл, хөрөнгө оруулалтын зардлын 73.1 хувийг барилга байгууламж, 13.0 хувийг бусад хөрөнгө, 8.4 хувийг тоног төхөөрөмж, 5.4 хувийг их засварт зарцуулжээ. Их засварын зардал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.4 хувиар өсөж, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зардал тус тус 3.2 хувь, 26.0 хувиар буурсан нь хөрөнгийн зардлын бууралтад голлон нөлөөлсөн байна. Түүнчлэн Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 31-ний дотор худалдан авах ажиллагааг бүрэн дуусгаж, гэрээ байгуулаагүй төслүүдийн санхүүжилтийг хэмнэлтэд тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор “Төсвийн хэмнэлтэд тооцох тухай” асуудлыг Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 02 дугаар

тогтоолоор баталсан. Уг тогтоолын хүрээнд нийт 535.9 тэрбум төгрөгийг төсвийн хэмнэлтэд тооцсон нь хөрөнгийн зардлын бууралтад нөлөөлсөн байна. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд нийт 9.5 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан хэдий ч 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7.1 их наяд төгрөг зарцуулж, 75.0 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Хөрөнгө оруулалтын зардлыг эх үүсвэр талаас авч үзвэл, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.1 их наяд төгрөг, гадаадын зээл, тусламжаар 1.7 их наяд төгрөг (Хүснэгт 2.1), орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3.3 их наяд төгрөг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 0.1. Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг)*

ТЕЗ	ХО-ын зардал	Эзлэх хувь
Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	433.5	29%
Эрчим хүчний сайд	283.5	19%
Сангийн сайд	203.5	14%
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	140.8	9%
Нийслэлийн Засаг дарга	114.9	8%
Зам, тээврийн сайд	94.5	6%
Эрүүл мэндийн сайд	70.7	5%
Боловсролын сайд	52.3	4%
Бусад	98.3	7%
Нийт	1,492.0	100%

1.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

34. Засгийн газрын нийт өрийн нэрлэсэн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс өслөө. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 35.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 39.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.0 их наяд төгрөг буюу 5.9 хувиар өслөө.

Засгийн газрын нийт өрийн 25.3 хувийг гадаад үнэт цаас, 65.2 хувийг гадаад зээл, 1.9 хувийг дотоод үнэт цаас үлдсэн 7.6 хувийн бусад өр төлбөр бүрдүүлж байна.

Хүснэгт 0.2. Засгийн газрын өрийн үлдэгдэл, 2025* оны урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Өрийн хэрэгсэл	2024	2025*
Засгийн газрын дотоод өр	400.5	688.5
Засгийн газрын гадаад өр	30,296.6	32,052.8
Үнэт цаас	8,655.0	8,817.5
Зээл	21,641.6	23,088.1
Засгийн газрын бусад өр	2,736.4	2,678.8
Өрийн баталгаа	178.0	164.7
Орон нутгийн зээллэг	2,558.4	2,514.1
НИЙТ ӨР	33,433.5	35,420.1

35. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээл сэргэж байна. Засгийн газрын нийт гадаад өр буюу гадаад зээл, үнэт цаасны үлдэгдэл 2025


оны урьдчилсан гүйцэтгэлээр 32.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.8 их наяд төгрөг буюу 5.8 хувиар өссөн байна. Уг өсөлтөд гадаад зээл, тусламжийн ашиглалт 1,881.3 тэрбум төгрөг болж нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бөгөөд 2025 оны эхний улиралд гаргасан "Сенчири-IV" үнэт цаас болон валютын ханшийн өөрчлөлт мөн нөлөөллөө.

36. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээл сэргэж байна. Засгийн газар 2017 оны аравдугаар сараас хойш дотоод зах зээлд нээлттэй хэлбэрээр дотоод үнэт цаас арилжаалаагүй тул дээрх хугацаанаас хойш дотоод үнэт цаасны үлдэгдэл 48.5 дахин буурч 2024 оны гуравдугаар улиралд 96.8 тэрбум төгрөгт хүрээд байв. Засгийн газрын зүгээс 2024 оны 11 дүгээр сард 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Нийгмийн даатгалын санд 300 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалсан, түүнчлэн Засгийн газар дотоод зах зээлийг дэмжих, төгрөгийн бондын суурь хүүг тогтоох, зах зээлийн гүнзгийрлийг сайжруулах зорилгоор 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр анхдагч зах зээл дээр дотоод үнэт цаас нээлттэй арилжихыг сэргээснээр 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 688.5 тэрбум төгрөг байна.

Зураг 0.4. Засгийн газрын өр

1.Засгийн газрын өр


(зүүн тэнхлэг: их наяд төгрөг, баруун тэнхлэг: хувь)



Эх сурвалж: Сангийн яам

2.Засгийн газрын өрийн өөрчлөлтийн задаргаа, жилийн өсөлт


(хувь)



Эх сурвалж: Сангийн яам, ЭЗХЯ-ны тооцоолол

3.Өрийн үйлчилгээний төлбөрийн динамик

(ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Олон Улсын Валютын сан
Тэмдэглэл: *ОУВС-гийн төсвөөлөл

** 2025 оны батлагдсан хүүгийн төлбөрийн хүлээгдэж буй ДНБ-д эзлэх хувь.

37. Засгийн газрын орон нутгийн зээллэг өмнөх оны түвшинд байна. Орон нутгийн зээллэг буюу нийслэлээс гаргасан үнэт цаасны үлдэгдэл 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт 2,514.1 тэрбум төгрөг байна. Зориулалтаар нь авч үзвэл Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах 1.8 их наяд төгрөг, зам засвар, арчилгааны 401.0 тэрбум төгрөг, Батарей хуримтлуурын станц барих төслийн 283.7 тэрбум төгрөг тус тус бүрдүүлж байна.

38. Засгийн газрын өрийн баталгааны нэрлэсэн үлдэгдэл өмнөх оны түвшинд байна. 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 164.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь Хятадын хөгжлийн банкнаас Чойбалсан ДЦС-ыг өргөтгөх төсөлд зориулан Монгол Улсын Хөгжлийн банканд гаргасан Засгийн газрын өрийн баталгаанд хамаарах зээлийн үлдэгдэл юм.

39. Засгийн газрын гадаад өрийн эргэн төлөлт 2027-2029 онд өндөр байна. Нийт гадаад өрийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2026 онд 469.2 сая ам.доллар, 2027 онд 1,235.7 (500.0 сая ам.доллар нь нийслэлийн "Сэлбэ" үнэт цаас) сая ам.доллар, 2028 онд 882.6 сая ам.доллар, 2029 онд 689.1 сая ам.долларын өрийн төлбөр хүлээгдэж байна. 2027-2029 онд нийт 2.8 тэрбум ам.доллар төлөхөөр байна. Засгийн газрын гадаад өрийн дарамт 2021 оноос тогтвортой буурч ирсэн боловч 2027 оноос өсөх төлөвтэй байгаа тул цаашид валютын нөөцөө нэмэгдүүлэх, ханшийн хэлбэлзлээс үүдэлтэй эрсдэлийг бууруулах, гадаад зээлийг эдийн засгийн үр өгөөжтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглүүлэх нь чухал байна.


40. Засгийн газрын өр дунд хугацаанд макро эдийн засгийн шок болон суурь таамаглалын өөрчлөлтөд мэдрэг хэвээр байна. Өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр Засгийн

газрын өрийн дунд хугацааны төлөв макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдээс хэр мэдрэг байгааг дүгнэлээ. Өрийн динамик шинжилгээний суурь төсөөллөөр 2026-2029 онуудад харгалзан ДНБ-ий өсөлт 5.4 хувь, 5.8 хувь, 6.0 хувь, 6.3 хувьд, ханшийн сулрал сүүлийн 10 жилийн дундаж түвшинд, ДНБ-ий дефлятор болон үндсэн тэнцэл төсөөллийн орчимд байна гэж үзвэл дунд хугацаанд Засгийн газрын өр 2029 он гэхэд алгуур буурч 38.2 хувьтай тэнцэхээр байна. Голлох үзүүлэлтүүдэд 2026 оноос эхлэн жил бүр 1 стандарт хазайлт бүхий шок тусган, өрийн динамикийн тодорхой бус байдлыг сэнсэн (fan chart) графикаар дүрсэллээ. Өрийн төсөөллийн тархалтын хамгийн өөдрөг (5 хувь) болон хамгийн эрсдэлтэй (95 хувь) хувилбарын хоорондох зөрүү 2026 онд 36.4 нэгж гарсан бол 5 жилийн дараа 70.1 нэгж болж эрчимтэй тэлж байна. Энэ нь засгийн газрын өр макро эдийн засгийн тодорхой бус байдал, шокийн нөлөөнөөс ихээхэн мэдрэг байгааг харуулж байна.


41. Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад үндсэн тэнцэл, бодит ДНБ-ий нөлөө өндөр байна. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлсийг өрийн динамик шинжилгээгээр үнэлэв. Засгийн газрын нэрлэсэн өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 2026 онд 1.8 хувиар буурахад буурахад үндсэн тэнцлийн алдагдал 2.2 нэгж хувиар, бодит ДНБ-ий өсөлт 2.3 нэгж хувиар, валютын ханшийн сулрал 0.9 нэгж хувьтай эерэг нөлөө үзүүлсэн бол бодит хүү болон харьцангуй инфляц 1.0 нэгж хувьтай тэнцэх сөрөг нөлөө үзүүлсэн байна. Цаашид Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад ДНБ-ий бодит өсөлт болон үндсэн тэнцлийн алдагдал, валютын ханшийн хэлбэлзэл голлох үүрэг гүйцэтгэхээр байна.

Зураг 0.5. Засгийн газрын өрийн тогтвортой байдал


1. Засгийн газрын өрийн төсөөллийн тархалт (ДНБ-д эзлэх хувь)



2. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс (өөрчлөлтөд эзлэх хувь)



3. Засгийн газрын өрийн тогтвортой байдалд нөлөөлөгч хүчин зүйлс (ДНБ-д эзлэх хувь)



Бүлэг 3

МӨНГӨНИЙ СЕКТОР

3.1. Инфляц

3.2. Мөнгө ба санхүүгийн салбар

2. МӨНГӨНИЙ СЕКТОР

ТОЙМ

Инфляц 2025 оны 4 дүгээр улиралд 7.5 хувьд хүрч, төв банкны зорилтот интервалд орлоо. Эдийн засгийн идэвхжил саарснаар эрэлтийн гаралтай инфляц алгуур саарах хандлагатай байсан бол нийлүүлэлтийн гаралтай инфляц мах болон хүнсний ногооны үнийн өсөлтөөс үүдэн нэмэгдэв. Түүнчлэн импортын болон хүнснээс бусад дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт саарлаа. Төв банк 2025 оны 4 дүгээр улиралд мөнгөний бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалав. Арилжааны банкнуудын зээлийн өсөлт үргэлжлэн саарч, 2025 оны эцэст 18.9 хувьд хүрсэн байна. Хэдийгээр зээлийн өсөлт саарч байгаа ч мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсээр байна. Мөн арилжааны банкнуудын чанаргүй зээлийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна.

3.1. Инфляц

42. Инфляц 2025 оны 4 дүгээр улиралд 7.5 хувьд хүрч, төсөөллийн орчимд байв. Инфляц 2025 оны 12 дугаар сард 7.5 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар буурсан байна. Инфляцын 3.0 нэгж хувийг хүнс, 0.9 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутал, 0.8 нэгж хувийг боловсролын үйлчилгээ, 0.5 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүрдүүлээ. Инфляц өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар буурахад цахилгааны тарифын нэмэгдлийн нөлөө арилсан, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлт саарсан нь голчлон нөлөөлсөн байна.

43. Импортын болон дотоодын бараа, үйлчилгээний инфляц оны эцэст саарлаа. Импортын барааны инфляц 2025 оны 12 дугаар сард 4.3 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурч, нийт инфляцын 26.8 хувийг бүрдүүлээ. Импортын инфляцын 74 орчим хувийг хүнсний бус барааны үнийн өсөлт тайлбарлаж байна. Үүнд хувцас, бөс бараа, гутал, автомашин, шатахууны үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Импортын инфляц харьцангуй тогтвортой хадгалагдахад ханшийн зах зээл тогтворжсон нь эергээр нөлөөллөө. Дотоодын бараа, үйлчилгээний инфляц 2025 оны эцэст 10.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар


саарч, нийт инфляцын 73.2 хувийг бүрдүүлсэн байна. Дотоодын инфляцад хүнс болон үйлчилгээний үнийн өсөлт голлох нөлөөтэй байна. Тухайлбал, 2025 оны эцэст үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар өссөн бол өмнөх оны мөн үеэс 4.7 нэгж хувиар саарсан үзүүлэлттэй байна. Үйлчилгээний үнийн өсөлт саарахад цахилгааны тарифын нэмэгдлийн суурь үеийн нөлөө арилсан болон түрээсийн үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөллөө.

44. Эрэлтийн инфляц сүүлийн 8 сар дараалан саарсан бол нийлүүлэлтийн шалтгаантай инфляц өндөр хэвээр байна. Хүнс, шатахуун, түлш, эрчим хүчийг хасаж тооцсон эрэлтийн (суурь) инфляц 2025 оны 12 дугаар сард 6.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар саарсан байна. Эрэлтийн инфляц сүүлийн 8 сар дараалан буурсан үзүүлэлттэй байна. Эрэлтийн инфляц саарахад 2025 оны төсөвт тодотгол хийж, төсвийн урсгал зардлыг бууруулсан, ханшийн зах зээл тогтворжсон, хэрэглээний зээлд зохицуулалт хийсэн, бодлогын хүүг 12 хувьд хадгалсан зэрэг бодлогын арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн нь голлон нөлөөллөө. Эрэлтийн инфляц нийт инфляцын 55 орчим хувийг тайлбарлаж байна. Нийлүүлэлтийн гаралтай инфляц 2025 оны 12 дугаар сард 8.8 хувь гарч,

Зураг 2.1. Инфляцын бүрэлдэхүүн

1.Инфляц ба зорилтот түвшин

(хувь)




Эх сурвалж: YCX

Тэмдэглэл: Улирлын инфляцын хувь хэмжээг улирлын сүүлийн саруудаар тооцов.

2.Инфляцын бүрэлдэхүүн

(хувь)




Эх сурвалж: YCX

Тэмдэглэл: Инфляцыг бүлгүүдээр задлан харуулав.

3.Суурь инфляц

(хувь)



Эх сурвалж: YCX

Тэмдэглэл: Суурь инфляцыг хүнс, шатахуун ба хатуу түлшийг нийт инфляцаас хасаж тооцов.

өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 нэгж хувиар эрчимжсэн байна. Нийлүүлэлтийн гаралтай инфляц оны сүүлийн саруудад эрчимжихэд хүнсний барааны үнэ 11.3 хувиар өссөн нь голчлон нөлөөлөв.

45. Хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц алгуур буурах хандлагатай байсан бол хүнсний инфляц өсөх хандлагатай байв. Хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 6.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.0 нэгж хувиар буурсан байна. Хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц өмнөх оноос буурахад өрхийн цахилгааны төлбөрийн суурь үеийн нөлөө арилсан, орон сууцны түрээс болон хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөллөө. Харин хүнсний инфляц 2025 оны эцэст 11.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.4 нэгж хувиар өссөн байна. Нийт инфляцын 3.0 нэгж хувийг бүрдүүлсэн хүнсний инфляц сүүлийн улирал нэмэгдэхэд мах, махан бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үнийн өсөлт голлон нөлөөлөв. Тодруулбал, мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар, хүнсний ногооны үнэ 30.3 хувиар тус тус өссөн байна. Хүнсний ногооны үнийн өсөлтөд цаг агаарын нөлөөгөөр ургац буурсан нь нөлөөлжээ. Тухайлбал, нийт хүнсний ногооны

ургац өмнөх оноос 15 хувиар, төмсний ургац 55 хувиар тус тус буурсан байна.

46. Олон улсад чингэлэг тээврийн үнэ болон хүнсний үнийн индекс буурав. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ АНУ-ын тарифын бодлогоос үүдэлтэйгээр өсөөд байсан бол 2025 оны сүүлийн хагаст аажмаар буурч эхэлсэн. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ 2025 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 40 фут чингэлэг тутам 2,213 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 28 хувиар буурсан бол цар тахлын өмнөх үеэс 58 хувиар өндөр байна.


Хүнсний үнийн индекс 2025 оны 4 дүгээр улирлын эцэст 124.5 болж, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар буурлаа. Дэлхийн зах зээл дээр үр тариа, элсэн чихрийн үнэ өссөн бол сүүн бүтээгдэхүүн, мах болон ургамлын тосны үнэ буурсан байна.

2025 оны эцсийн байдлаар Орос, Солонгос, Япон, Казахстан, Киргизстан, Гүрж, Турк, Америк, Их Британи, Евро бүсийн инфляц буурсан бол Хятад, Шри-Ланк улсуудын инфляц өссөн байна.

47. Бодлогын хүү зохистой түвшинд байна. Төв банк 2025 оны 4 дүгээр улирлын турш бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгаллаа. Бодлогын хүүний зохистой утгыг илэрхийлэх Тэйлорын дүрмээр

Зураг 2.2. Тэйлорын хүү, мөнгөний нөхцөлийн индекс


1.Бодлогын хүү ба Тэйлорын хүү



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Тэйлорын дүрмээр тооцсон хүү нь бодлогын хүүний зохистой утгыг илэрхийлэх бөгөөд өмнөх улирлын бодлогын хүү, инфляц, инфляцын хүлээлт, нэрлэсэн хүү зэрэг хувьсагчдыг агуулсан тэгшитгэл юм.

2.Мөнгөний нөхцөлийн индекс



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол


Тэмдэглэл: Мөнгөний нөхцөлийн индекс нь эдийн засаг дахь мөнгөний бодлогын нөлөөг хэмжих үзүүлэлт юм. Мөнгөний нөхцөлийн индексийг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP арга зүйг ашиглан тооцоолов.

тооцсон хүү 12.3 хувь байгаа нь бодлогын хүүний дундаж түвшинтэй ойролцоо буюу нийцтэй байна. Түүнчлэн 2025 оны 2 дугаар улирлаас эхлэн бодит хүүний зөрүү мөнгөний нөхцөлийг бага зэрэг чангаруулах нөлөөтэй байна. Мөн 2025 оны 4 дүгээр улиралд бодит ханшийн зөрүүний мөнгөний нөхцөлийг чангаруулах нөлөө өмнөх улиралтай харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.


Цаашид шинээр олгосон зээлийн өсөлт, геополитикийн хурцадмал байдал, тодорхой бус байдал, газрын тосны үнэ, тарифын бодлого зэрэг инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлүүд хэвээр хадгалагдаж байгаа тул бодлогын хүүг богино хугацаанд бууруулахгүй байх нь тохиромжтой байна.

Зураг 2.3. Голлох бүтээгдэхүүний үнэ


1.Хонины мах (кг/төгрөг)




2.Үхрийн мах (кг/төгрөг)




3.Гурил, 1-р зэрэг (кг/төгрөг)



4.Талх, Атар (төгрөг)




5.Ургамлын тос (төгрөг)




6.Төмс (төгрөг)



7.Сүү, савласан (литр/төгрөг)



8.Дизель түлш (литр/төгрөг)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Голлох зарим бүтээгдэхүүний үнийн динамикийг сараар харуулав.

3.2. Мөнгө ба санхүүгийн салбар


48. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн улирал эрчимжих хандлагатай байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2025 оны 4 дүгээр улирлын эцэст 10.6 хувьд хүрч, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 4.9 нэгж хувиар буурлаа. Эх үүсвэр талаас төгрөгийн хадгаламж мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голлон бүрдүүлж байна. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 9.5 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 2.1 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 0.2 нэгж хувийг гадаад валютын харилцах, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.05 нэгж хувийг бүрдүүлсэн бол төгрөгийн харилцах -1.1 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлээ. Байршуулалт талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 8.4 нэгж хувийг дотоод цэвэр актив гадаад цэвэр актив 2.2 нэгж хувийг бүрдүүлсэн. Дотоод цэвэр активын өсөлтөд дотоодын зээл голлон нөлөөлж байна.

49. Зээлийн өсөлт үргэлжлэн саарлаа. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны эцэст 43.8 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 18.9 хувьд хүрлээ. Нийт зээлийн үлдэгдлийн 70 хувь буюу 30.8 их наяд төгрөгийг бизнесийн зээл, 30 хувь буюу 13.0 их наяд төгрөгийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Бизнесийн зээлийн үлдэгдлийн өсөлт 2025 оны сүүлийн улиралд 21.2 хувь болж,

өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 14.3 нэгж хувиар саарсан байна. Бизнесийн зээлийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдааны зээл өмнөх оны мөн үеэс 30.8 хувиар, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны зээл 16.3 хувиар, барилгын зээл өмнөх оны мөн үеэс 34.5 хувиар, хөдөө аж ахуйн зээл 25.9 хувиар тус тус өссөн нь голчлон нөлөөлжээ. Хэрэглээний зээлийн үлдэгдлийн өсөлт 2025 оны 4 дүгээр улиралд 14.0 хувьд хүрч, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 21.5 нэгж хувиар саарав. Тэтгэврийн зээл хэрэглээний зээлийн өсөлтөд голлох нөлөөтэй байна. Тодруулбал, цалингийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар өссөн бол мөнгөний бодлогын хорооноос 2025 оны 7 дугаар сард тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн зохицуулалтыг хүчингүй болгож, шинээр олгох зээлд өр, орлогын харьцаа мөрдөхгүй болсноор тэтгэврийн зээлийн өсөлт 2025 оны 4 дүгээр улиралд 58.1 хувьд хүрч эргэн эрчимжлээ.

50. Шинээр олгосон зээлийн өсөлт бизнесийн зээлийн хувьд харьцангуй өндөр хэвээр байгаа бол хэрэглээний зээлийн өсөлт саарах хандлагатай байна. 2025 онд банкны салбарын шинээр олгосон зээлийн нийт хэмжээ 66.7 их наядад хүрч, өмнөх онтой харьцуулахад 9.6 их

Зураг 2.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

наяд төгрөгөөр буюу 16.8 хувиар өслөө. Үүнээс 66.6 хувийг бизнесийн зээл, 33.4 хувийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. 2025 оны эхний 4 улирлын байдлаар шинээр олгосон бизнесийн зээлийн жилийн өсөлт 21.5 хувьд хүрч, өсөлтийн хурд 19.2 нэгж хувиар саарлаа. Бизнесийн шинээр олгосон зээлийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдаа, уул уурхай, олборлолт, барилга, боловсруулах үйлдвэрлэл, болон санхүү, даатгалын үйл ажиллагааны салбаруудад зээл олголт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Харин шинээр олгосон хэрэглээний зээлийн өсөлт 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 8.5 хувь болж, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 21.7 нэгж хувиар буурчээ. Шинээр олгосон хэрэглээний зээлийн өсөлтийг хадгаламж барьцаалсан зээл болон тэтгэврийн зээл голлон бүрдүүлж байна. Төв банкнаас тэтгэвэр, тэтгэмж барьцаалсан зээлийн хувьд мөрдөж байсан зохицуулалтыг 2025 оны 7 дугаар сард хүчингүй болгосон. Ингэснээр 2025 оны 4 дүгээр улиралд олгосон тэтгэврийн зээл өмнөх улиралтай харьцуулахад 1.1 их наяд төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


51. Чанаргүй зээлийн хэмжээ өслөө. Чанаргүй зээлийн нийт хэмжээ 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 2.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн

үеэс 18.8 хувиар нэмэгдсэн байна. Чанаргүй зээлийн 23.3 хувийг цалин, 15.9 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 15.7 хувийг барилга, 11.4 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, 9.8 хувийг уул уурхай, олборлолтын зээл бүрдүүлж байна. Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэхэд чанаргүй цалингийн зээл өмнөх оны мөн үеэс 140.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн өрхийн хэрэглээнд зориулсан чанаргүй зээлийн үлдэгдэл 221.0 хувиар өссөн нь сөрөг нөлөөтэй байна. Харин уул уурхайн салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар буурлаа. Улмаар чанаргүй зээлийн нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь 5.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс өөрчлөлтгүй бол өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Зээлийн чанар өмнөх улирлаас сайжрахад чанаргүй өрхийн хэрэглээнд зориулсан зээл 5.7 хувиар болон уул уурхайн зээл 12.8 хувиар тус тус буурсан нь голчлон нөлөөллөө.

52. Нийт хадгаламжийн өсөлтийн дийлэнхийг иргэдийн төгрөгийн хадгаламжийн өсөлт бүрдүүлж байна. Банкнуудын нийт хадгаламж 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 30.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар өслөө. Үүнээс иргэдийн хадгаламж 25.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар өссөн байна. Тодруулбал, иргэдийн төгрөгийн


Зураг 2.5. Хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд

1.Хадгаламжийн өсөлт
(хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

2. Банк хоорондын захын хүү болон шинээр татсан хадгаламжийн хүү
(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

3.Бодит үйлчилж буй хүү
(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

Тэмдэглэл: Бодит үйлчилж буй хүү=(1+Зарласан хүүгийн хувь/хүү бодох давтамж)⁴(Хүү бодох давтамж)-1

хадгаламж 21.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар өссөн бол иргэдийн валютын хадгаламж 3.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 13.3 хувиар өслөө. Харин байгууллагын нийт хадгаламж 5.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 29.6 хувиар тус тус өссөн байна. Төгрөгийн шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 12.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өссөн бол валютын хадгаламжийн хүү 3.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурчээ. Иргэдийн төгрөгийн хадгаламж өсөлттэй хэвээр байгаа ч өсөлтийн хурд саарах хандлагатай байна.

53. Активын долларжилтын түвшин өмнөх оны мөн үеэс өслөө. Гадаад валютын харилцах ба хадгаламжийн мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хэмжээ 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 20.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.03 нэгж хувиар өссөн бол, өмнөх улирлаас 0.9 нэгж хувиар буурсан байна. Активын долларжилтын түвшин өмнөх оны мөн үеэс өсөхөд гадаад валютын хадгаламж 18.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

54. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү бодлогын хүүний орчимд байна. 2025 оны 4 дүгээр улиралд мөнгөний бодлогын хүү 12 хувьд хадгалагдсан бол банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү мөн 12 хувь байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.1 нэгж хувиар өссөн бол өмнөх улиралтай харьцуулахад өөрчлөлтгүй байна.

55. Зээл ба хадгаламжийн бодит үйлчилж буй хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс өслөө. Арилжааны банкнуудын бодит үйлчилж буй зээлийн хүү 2025 оны 4 дүгээр улиралд 17.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар өсөж, өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар бууржээ. Харин бодит үйлчилж буй хадгаламжийн хүү 12.6 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар тус тус өссөн байна. Зээл ба хадгаламжийн бодит үйлчилж буй хүүний зөрүү өмнөх оноос 0.4 нэгж хувиар өслөө. Бодит

үйлчилж буй хүүний зөрүү өмнөх оноос өсөхөд зээлийн хүү хадгаламжийн хүүнээс өндрөөр өссөн нь нөлөөлөв.

56. Зээлийн тэлэлт сулрах хандлагатай байна. 2025 онд нийт зээл дотоодын нийт бүтээгдэхүүний 48.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.0 нэгж хувиар өссөн байна. Зээлийн тэлэлт 2022-2023 онд саарсан байсан бол 2024 оны эхний хагасаас сэргэж эхэллээ. Мөн банкны салбарын нийт зээл ба хадгаламжийн харьцаа 2025 оны 4 дүгээр улиралд 1.4 (142 хувь) болж, өмнөх оны мөн үеэс 0.03 нэгж хувиар өссөн бол өмнөх улирлаас 0.08 нэгж хувиар буурлаа. Уг харьцаа өсөхөд нийт хадгаламжийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Зээл ба хадгаламжийн харьцаа өндөр байгаа нь хөрвөх чадварын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

57. Банкны салбарын ашигт ажиллагаа эерэг хэвээр байгаа боловч сүүлийн улирлуудад саарах хандлагатай байна. Тухайлбал, банкны салбарын активын өгөөж 2025 оны эцэст 1.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурлаа. Хэдийгээр банкны салбарын активын өгөөж өмнөх оны мөн үеэс бууралттай байгаа ч эерэг хадгалагдаж, банкны салбар ашигтай ажиллаж байна. Харин активын өгөөж өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурахад чанаргүй зээлийн хэмжээ өссөн нь нөлөөлсөн байж болзошгүй байна.

58. Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үлдэгдлийн өсөлт өндөр хэвээр байна. 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 575 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт зээлийн хэмжээ 7.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 25.5 хувиар өссөн байна. Нийт олгосон зээлийн 91.5 хувийг иргэдэд, 8.5 хувийг хуулийн этгээдэд олгосон зээл бүрдүүлжээ. 2025 оны 4 дүгээр улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлдэгчдийн 90.1 хувь буюу 2.8 сая харилцагч финтек зээлийн үйлчилгээгээр нийт 2.3 их наяд төгрөгийн зээл авсан байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жинлэсэн

дундаж хүү сарын 3.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өсжээ.

Хүснэгт 2.1. Санхүүгийн салбарын эмзэг байдал

		Зээлийн тэлэлт	Хөрөнгийн чанар	Ашигт ажиллагаа	Төлбөр гүйцэтгэх чадвар	Хөрвөх чадвар
		Нийт зээл/ДНБ	Чанаргүй зээл/Нийт зээл	Банкны активын өгөөж	Зээл/Хадгаламж	Хөрвөх актив/Богино хугацаат өр төлбөр
2020	I	44.8	10.8	0.3	123	40.9
	II	45.4	11.1	1.2	114	38.1
	III	45.4	11.4	1	104	38.6
	IV	45	11.8	0.5	95	48.0
2021	I	39.1	11.5	1.1	95	48.0
	II	42.4	10.3	2.2	100	53.3
	III	44.8	9.9	1.5	105	48.8
	IV	46.2	10	0.7	110	53.3
2022	I	39.9	9.7	2	123	44.2
	II	42.4	9	3.5	128	45.1
	III	41.5	11.2	1.3	134	42.0
	IV	40.1	9.2	2.8	127	56.7
2023	I	32.3	9.6	2.4	122	48.3
	II	35.6	8.7	2.7	131	49.0
	III	36.3	8.5	2.4	131	50.7
	IV	38.1	7.5	2.6	124	57.8
2024	I	36.1	7.1	2.8	129	57.2
	II	41.5	5.9	3.4	139	51.7
	III	43.7	5.7	2.3	141	49.2
	IV	45.9	5.1	2.6	139	52.0
2025	I	42.9	5.3	2.4	144	49.2
	II	46.9	4.9	2.1	153	43.2
	III	47.5	5.2	1.6	150	43.3
	IV	48.6	5.1	1.9	142	49.4

Тэмдэглэл: Хөрвөх активыг касс дахь бэлэн мөнгө, төв банк дахь харилцах ба хадгаламж (төгрөг, валют), төв банкны үнэт цаас болон төв банк дахь бусад хадгаламжийн нийлбэрээр тооцов. Богино хугацаат өр төлбөрт харилцах болон хугацаатай хадгаламж, бусад санхүүгийн байгууллагуудын, банк хоорондын, гадаадын байгууллагын, болон төрийн байгууллагын өр төлбөрөөр тооцсон болно. Нийт зээл ба ДНБ-ий харьцааг тооцоход ЭЗХЯ-ны 2025 оны нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөллийг ашиглав. Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

Бүлэг 4

ГАДААД СЕКТОР

4.1. Гадаад худалдаа

4.2. Төлбөрийн тэнцэл, гадаад өр

3. ГАДААД СЕКТОР

ТОЙМ

Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн голлох бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өмнөх оноос өссөн боловч дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал нэмэгдэж, эрэлт саарснаас нүүрсний үнэ огцом буурч, экспортын орлогод сөрөг нөлөө үзүүлээ. Харин дотоодын эрэлт сул байснаар импортын өсөлт хязгаарлагдмал түвшинд хадгалагдав. Ингэснээр урсгал дансны алдагдал буурч, төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа.

4.1. Гадаад худалдаа

59. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан хэдий ч худалдааны эргэлт өмнөх оны мөн үеэс буурлаа. Монгол Улс 2025 онд дэлхийн 158 улстай худалдаа хийж, худалдааны тэнцэл 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан хэдий ч нийт бараа эргэлт 27.2 тэрбум ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурлаа.

60. Экспорт өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдлаа. 2025 онд Монгол Улсын экспорт 15.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Оны эхний хагас жилд нийт 6.6 тэрбум ам.долларын экспорт хийж, сарын дундаж экспорт 1.1 тэрбум ам.доллар байв. Харин хоёрдугаар хагаст 9.2 тэрбум ам.долларын бараа, үйлчилгээ экспортолж, сарын дундаж 1.5 тэрбум ам.доллар болж өмнөх хагас жилээс 30 орчим хувиар өссөн байна. Өсөлтөд нүүрс, зэсийн баяжмалын экспорт нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

61. Нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдсэн хэдий ч хилийн үнэ буурлаа. 2025 онд нүүрсний экспорт 90.0 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар нэмэгдсэн хэдий ч хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 38 хувиар буурлаа. Улмаар нүүрсний экспортын орлого 34 хувиар буурч, нийт экспортын өсөлтөд сөрөг нөлөө үзүүллээ. (Зураг 4.1.1)

62. Зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын хэмжээ нэмэгдлээ. 2025 онд зэсийн


баяжмалын экспорт 2,290 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 35 хувиар, төмрийн хүдрийн экспорт 8,846 мянган тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 18 хувиар тус тус өссөн байна. Энэхүү өсөлт нь далд уурхайн нөлөөгөөр олборлолт нэмэгдсэн, төмөр замын тээвэр зохион байгуулалт сайжирсантай холбоотой.

63. Боловсруулах үйлдвэрийн өсөлтийн нөлөөгөөр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт нэмэгдлээ. Боловсруулах салбарын өсөлт болон ноолуурыг заавал самнаж гаргах шийдвэртэй холбоотойгоор 2025 онд малын махны экспорт 313 сая ам.долларт хүрч өмнөх оноос 17 хувиар, ноолуурын экспорт өмнөх оноос 2 хувиар тус тус өссөн байна.

64. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны идэвх нэмэгдлээ. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 онд 22.8 сая тонн нүүрсийг 1 тэрбум 554 сая ам.доллараар, 5,894 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 378 сая ам.доллараар, 45.3 мянган тонн зэсийн баяжмалыг 106 сая ам.доллараар тус тус арилжаалаад байна. Эрчим хүчний нүүрсийг индексжүүлэн зарах, Хилийн Гашуунсухайт боомтоор нэн тэргүүнд нэвтрүүлэх зэрэг Засгийн газраас экспортын нэмэгдүүлэхтэй холбоотой арга хэмжээ хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор 2025 оны 3 дугаар улирлаас уул уурхайн биржийн арилжаа буцаад сэргэж эхэллээ.

Зураг 3.1. Экспорт

1.Экспортын жилийн өсөлт (нэгж хувь)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2.Экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ

Бүтээгдэхүүн	2024	2025	Өсөлт
Зэсийн баяжмал /мян.тонн/	1,695	2,290	35%
Нүүрс /сая тонн/	83.8	90.0	7.5%
Алт /кг/	11.7	10.8	-7%
Төмрийн хүдэр /мян.тонн/	7,510	8,846	18%
Газрын тос /мян. баррель/	4,074	3,532	-13%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

3.Уул уурхайн бирж дээр амжилттай болсон арилжааны тоо



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

65. Импортын эрэлт суларлаа. 2024 онд эдийн засгийн идэвхжил өндөр байж, өрхийн орлого, зээл олголт нэмэгдсэнээр иргэд, аж ахуй нэгжийн худалдан авах чадвар сайжирч импортын бараа, бүтээгдэхүүний урсгал өндөр байв. Харин 2025 онд импорт өмнөх оноос 303 сая ам.доллар буюу -2.6 хувиар буурч, импортын эрэлт сулав. Импортын жилийн өөрчлөлтийг барааны бүлгээр авч үзвэл: нийт импортын бууралтад хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн -1.6 нэгж хувь, хэрэглээний бүтээгдэхүүн -0.5 нэгж хувь, аж үйлдвэрийн орц -0.2 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна.

66. Суудлын автомашины импорт саарснаар хэрэглээний бүтээгдэхүүний импортыг буурууллаа. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт 4.1 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс -1.3 хувиар буурав. Уг бууралтад суудлын автомашин болон автобензиний импорт голлох нөлөөг үзүүллээ. Нийслэл хотод 10-аас дээш жилийн насжилттай суудлын автомашинд тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгохгүй гэж шийдвэрлэсэнтэй холбоотойгоор суудлын автомашины импорт 1,003 сая ам.долларт хүрч өмнөх оноос -5.5 хувиар буурсан байна. Суудлын автомашины импортыг даган автобензиний импорт 602 сая ам.долларт хүрч, -6.4 хувиар буурав. Харин хүнс, эм тариа зэрэг өрхийн зайлшгүй хэрэгцээт бүтээгдэхүүний импорт 4 болон 11 хувиар тус тус өслөө.

67. Төслүүдийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, барилгын материалын импорт өслөө. 2025 онд барилгын материалын импорт 1,452 сая


ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөн байна. Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэн УЦС, Сэлбэ дэд төв, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам зэрэг томоохон төслүүдийн бүтээн байгуулалт барилгын материалын импортын өсөлтийг дэмжлээ.

68. Импортын барааны зардал өслөө Импортын үнийн дүнгийн индекс 102.8 хувь буюу өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өссөн байна. Тухайлбал, хүнс, гутал, хувцас зэрэг хэрэглээний бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл болон түүний эд ангийн үнийн өсөлт импортын үнийн индексийг нэмэгдүүлсэн байна. Харин машин, тоног төхөөрөмж, металл, хуванцар зэрэг зарим бүлгийн үнийн бууралт нь индексийн өсөлтийг тодорхой хэмжээнд сааруулжээ.

Манай улсын импортын 24 хувийг бүрдүүлж буй ОХУ-ын инфляц 2025 онд 5.6 хувь байгаа ч тус улсаас импортолж буй бүтээгдэхүүний 21 хувийг АИ-92 автобензин, 48 хувийг дизелийн түлш бүрдүүлж байгаа бөгөөд дээрх нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлт бага байна. Тухайлбал ОХУ-ын Роснефть компанитай 2022 онд байгуулсан хэлэлцээрийн дагуу АИ-92 шатахууныг тогтвортой үнээр худалдан авч байгаа бөгөөд харин ОХУ-ны дизелийн түлшний үнэ буурч байгаа нь импортын барааны үнийн өсөлт бага байхад нөлөөллөө.

Зураг 3.2. Импорт

1.Импортын жилийн өсөлт (нэгж хувь)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2.Импортын үнийн индекс (хувь, өмнөх оны мөн үеэс)



Эх сурвалж: УСХ

3.Импортын голлох бүтээгдэхүүн (сая ам.доллар)

Бүтээгдэхүүн	2024	2025	Жилийн өөрчлөлт
Суудлын автомашин	1,062	1,003	-5.5%
Хүнс	1,169	1,217	4.1%
Барилгын материал	1,326	1,452	9.6%
Тоног төхөөрөмж	2,284	2,297	0.6%
Шатахуун	2,211	2,174	-1.6%
Ачааны машин	1,221	794	-34.9%
Нийт	11,615	11,312	-2.6%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Шигтгээ 2. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/1348 дугаар захирамж

Нийслэлийн засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн "Нийслэл хотод автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгох шалгуур үзүүлэлтийг батлах тухай" А/1348 дугаар захирамжаар Улаанбаатар хотын улсын бүртгэлийн дугаар олгох шаардлага болон дугаар олгох дэс дарааллын тогтоох шалгуур үзүүлэлтийг баталсан. Тухайлбал Улаанбаатар хотын улсын бүртгэлийн дугаар олгох шаардлагыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:


- Тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч нь нийслэлд бүртгэлтэй иргэн, хуулийн этгээд байх;
- Татвар, төлбөр, зөрчил, торгуулийг барагдуулсан байх;
- Даатгуулсан байх;
- Хөдөлгүүрийн экологийн ангилал нь "евро-4" эсвэл түүнтэй дүйцэхүйц буюу түүнээс дээш байх;
- **Сүүлийн 10 жилийн дотор үйлдвэрлэгдсэн тээврийн хэрэгсэл байх;**
- Батлагдсан шалгуур үзүүлэлтээр тогтоосон дэс дарааллын эхэнд байх;
- **Экспортын өмнөх техник хяналтын үзлэгт хамрагдсан байх.**

Тус захирамжийн сүүлийн 10 жилийн дотор үйлдвэрлэсэн буюу шинэ тээврийн хэрэгсэлд Улаанбаатар хотын улсын бүртгэлийн дугаарыг олгох болон экспортын өмнөх техник хяналтын үзлэгт хамрагдсан байх шаардлага 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхээр заасан.

Дээрх шийдвэрийн үр дүнд суудлын автомашины импорт 2025 оны эхний хагаст огцом өсөж, харин шийдвэр мөрдөгдөж эхэлсний дараа буюу 2025 сүүл хагаст эрс буурав. Тухайлбал 2025 оны эхний хагас жилд суудлын автомашины импорт 661 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 45 хувиар, импортолсон автомашины тоо 62.6 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 10 хувиар тус тус өсөв. Харин 2025 оны сүүл хагаст суудлын автомашины импорт 342 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 44 хувиар, импортолсон автомашины тоо 26.5 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 60 хувиар тус тус буураад байна.

НИТХ-ын 2024 оны 18 дугаар тогтоолоор Нийслэлд олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дээд хязгаарыг 730,000 байхаар тогтоосон. Үүнтэй холбоотойгоор суудлын автомашины импорт 2024 оны 3 дугаар улиралд огцом нэмэгдэж 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр дугаарын хязгаартаа хүрсэн. Иймд 2025 оны сүүлийн хагаст автомашины импорт ихээхэн буурсанд мөн суурийн нөлөө өндөр байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Зураг 3.3. Суудлын автомашины импорт
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

4.2. Төлбөрийн тэнцэл, гадаад өр

69. Бараа, үйлчилгээний дансны тэнцэл сайжирч урсгал дансны алдагдал агшлаа. 2025 онд бараа, үйлчилгээний импорт агшиж, үйлчилгээний болон анхдагч орлогын дансны алдагдал өмнөх оны мөн үеэс буурлаа. Мөн оны эхний хасагт огцом буурч байсан барааны экспорт сайжирч 15.8 тэрбум ам.долларт хүрснээр урсгал дансны алдагдал 2.1 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 12 хувиар буурлаа.

70. Тээврийн болон барилгын үйлчилгээний алдагдал буурсан нь нийт үйлчилгээний дансны тэнцэл сайжрахад голлон нөлөөллөө. Үйлчилгээний дансны алдагдал 2025 онд 2.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 462 сая ам.доллороор буурлаа. Үйлчилгээний дансны алдагдлын 35 хувь буюу 1.0 тэрбум ам.долларыг аялал жуулчлалын үйлчилгээ, 30 хувь буюу 0.9 тэрбум ам.долларыг бизнесийн бусад үйлчилгээ, 17 хувь буюу 0.7 тэрбум ам.долларыг тээврийн үйлчилгээний алдагдал бүрдүүлж байна. Тээврийн үйлчилгээний зардал 140 сая ам.доллороор буурч, нөгөө талаас орлого 182 сая ам.доллороор өссөнөөр тээврийн үйлчилгээний алдагдал өмнөх оны мөн үеэс 321 сая ам.доллороор буюу 40 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа. Мөн өмнөх онд 224 сая ам.доллар байсан барилга, угсралтын үйлчилгээний зардал 115 сая ам.долларт хүрч буурсан нь нийт үйлчилгээний дансны алдагдал буурахад эергээр нөлөөллөө.

71. Аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал өмнөх оны нэмэгдлээ. Нийт аялал жуулчлалын үйлчилгээний дансны алдагдал 1,004 сая

ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5 хувиар нэмэгдлээ. Эмчилгээтэй холбоотой аяллын үйлчилгээний зардал өмнөх оны мөн үеэс 80 сая ам.доллороор буюу 59 хувиар буурсан ч бусад хувийн аяллын зардал 220 сая ам.доллороор өссөн нь нөлөөллөө.

72. Санхүүгийн дансны ашиг өмнөх оны түвшинд хадгалагдлаа. Санхүүгийн дансны ашиг 2025 онд 3.3 тэрбум ам.доллар байна. Үүнд өмнөх оны эхний хагаст төв банк своп хэлцлийн 0.6 тэрбум ам.долларын төлбөрийг гүйцэтгэсэнтэй холбоотойгоор бэлэн мөнгө ба харилцах дансны гарах урсгал өндөр байсан суурийн нөлөө голлон нөлөөллөө.



73. Шууд хөрөнгө оруулалтын орох урсгал буурлаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт орох урсгал 2025 онд 3,831 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8 хувиар буюу 349 сая ам.доллороор буурлаа. Нийт шууд хөрөнгө оруулалтын бууралтад уул уурхайн салбарын шууд хөрөнгө оруулалт 3,067 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 315 сая ам.доллороор буюу 9 хувиар буурсан нь голлон нөлөөллөө. Мөн мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны шууд хөрөнгө оруулалт өмнөх оноос 78 сая ам.доллороор, худалдааны салбарын шууд хөрөнгө оруулалт 13 сая ам.доллороор тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин санхүү болон даатгалын үйл ажиллагааны шууд хөрөнгө оруулалт 94 сая ам.доллороор, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хөрөнгө оруулалт 29 сая ам.доллороор тус тус өссөн байна.

Зураг 3.4. Урсгал болон санхүүгийн дансны тэнцэл, төгрөгийн ханши

1.Урсгал дансны тэнцэл
(сая ам.доллар)

2.Санхүүгийн дансны тэнцэл
(сая ам.доллар)

3.Төгрөгийн ханшийн индексийн өөрчлөлт
(хувь)



Тэмдэглэл: Улирлын өссөн дүнгээр харуулав.

74. Гадаад валютын нөөц нэмэгдэж төгрөгийн ам.доллартой харьцах ханш тогтворжлоо. Гадаад валютын улсын нөөц 2025 оны эцэст 7,005 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1,495 сая ам.доллаар, өмнөх улирлаас 1,131 сая ам.доллаар тус тус өслөө. Ингэснээр энэ оны эхний хагаст 160 төгрөгөөр огцом суларч байсан төгрөгийн ам.доллартой харьцах албан ханш 2025 оны эцэст 3,556 төгрөгт хүрч тогтворжлоо. Худалдааны түнш орнуудын валютаар жигнэсэн төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс өмнөх оноос 4.0 нэгж хувиар суларсан бол үнийн өөрчлөлтийн нөлөөг хассан бодит ханшийн индекс өмнөх оноос 3.9 нэгж хувиар суларсан байна.

75. Нийт эдийн засгийн хөрөнгө оруулалт буурснаар урсгал дансны алдагдал агшлаа. Урсгал дансны тэнцлийг тухайн улсын нийт хадгаламж болон хөрөнгө оруулалтын зөрүүгээр мөн тайлбарладаг. Сүүлийн 10 жилийг авч үзвэл манай улсын хөрөнгө оруулалтын хэрэгцээ хадгаламжаас давж, 2023 оноос бусад онд урсгал данс алдагдалтай байсан. Урсгал дансны алдагдал 2025 оны эцэст ДНБ-ий 8.2 хувьтай тэнцэж, өмнөх оны мөн үеэс 1.8 нэгж хувиар буурсан. Нийт эдийн засгийг төр болон хувийн хэвшилд хуваан харвал, Засгийн газар болон хувийн хэвшлийн хадгаламжийн бууралтаас хөрөнгө оруулалтын бууралт давсан үзүүлэлттэй байна.

76. Гадаад хөрөнгө оруулалтын позиц сул хэвээр байна. Гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө болон Монгол Улс бусад улсад төлөх үүрэг бүхий өр төлбөрийн зөрүүг харуулдаг гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2025 оны эцэст -46.2 тэрбум ам.долларт хүрч, ДНБ-ий -188 хувьтай тэнцэж байна. Монгол Улсад байршиж буй гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн дүн 58.6 тэрбум ам.долларт хүрсэн нь гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгөөс 4.7 дахин их байна. Гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн 61 хувь буюу 35.1 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт, 25 хувь буюу 14.5 тэрбум ам.доллар нь зээл байна. Харин гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн 53 хувь буюу 7.0 тэрбум ам.доллар нь нөөц хөрөнгө байна.

77. Төрийн болон хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдэл өслөө. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2025 оны эцэст 40.3 тэрбум ам.доллар болж, өмнөх оны эцсээс 3.0 тэрбум ам.доллаар буюу 8.2 хувиар өслөө. Сектороор харвал, өмнөх оны мөн үеэс төв банкны гадаад өр 14 сая ам.доллаар, Засгийн газрын гадаад өр 353 сая ам.доллаар, хадгаламжийн байгууллагын гадаад өр 1,423 сая ам.доллаар, бусад хувийн хэвшлийн гадаад өр 286 сая ам.доллаар тус тус өссөн байна.


78. Хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдлийн өсөлтийн дийлэнхийг санхүү болон уул уурхайн салбар бүрдүүлээ. Хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдлийн өсөлтийн 65 хувь буюу 1,730 сая ам.долларыг санхүү болон даатгалын салбар, 41 хувь буюу 1,107 сая ам.долларыг уул уурхайн салбар бүрдүүлсэн байна. Бусад салбаруудын хувьд, худалдаа, мэдээлэл холбоо, зочид буудлын салбаруудын гадаад өрийн үлдэгдэл өмнөх оноос өссөн буурсан үзүүлэлттэй байна.

79. Улсын нийт гадаад өрийн дийлэнхийг шууд хөрөнгө оруулалт болон зээл бүрдүүлж байна. Улсын нийт гадаад өрийн үлдэгдлийн 45 хувь

буюу 18.2 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалттай компанийн өглөг, 36 хувь буюу 14.5 тэрбум ам.доллар нь зээл, 11 хувь буюу 4.5 тэрбум ам.доллар нь бонд байна. Тэр дундаа, зээлийн үлдэгдлийн 45 хувь нь Засгийн газар болон төв банкны зээл, 55 хувь нь хувийн хэвшлийн зээл байна.


Зураг 3.5. Урсгал данс, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад өр

1.Урсгал дансны тэнцэл
(ДНБ-д эзлэх хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

2.Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц
(ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

3.Гадаад өрийн өөрчлөлт
(сая ам.доллар)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

Тэмдэглэл: ДНБ-д эзлэх хувийг 4 улирлын нийлбэрээр тооцов.

Бүлэг 5

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

5.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага

5.3. Олон улсад 2025 онд зарлагдсан индексүүд

4. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

ТОЙМ

Худалдааны дайн, геополитикийн хурцадмал байдал, бодлогын тогтворгүй байдал зэргийн нөлөөгөөр дэлхийн тодорхой бус байдал сүүлийн 10 жилийн дунджаас 4 дахин өндөр байна. Үүний улмаас хөрөнгө оруулагчид аюулгүй хөрөнгөд хандах хандлагаа нэмэгдүүлж, алтны эрэлт өсөж үнэ нэмэгдсэн бол, дэлхийн эдийн засгийн идэвхжил буурснаар нүүрсний эрэлт суларч үнэ буурав. Харин тарифын түр завсарлага, технологийн хөрөнгө оруулалт, төсвийн дэмжлэгийн бодлогын нөлөөгөөр ОУВС 2026 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг дээшлүүлэв.

5.1. Дэлхийн эдийн засаг

80. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд явагдаж, худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал эрчимтэй өөрчлөгдөж буй энэ цаг үед дэлхийн улс төр, эдийн засгийн өрнөлд тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. Тухайлбал, Дэлхийн тодорхой бус байдлын индекс (World Uncertainty Index)-ийн үзүүлэлт 2025 оны 3 дугаар улиралд түүхэн дээд түвшинд хүрч, 4 дүгээр улиралд бага зэрэг саарсан ч индекс сүүлийн 10 жилийн дунджаас 4 дахин өндөр байна. (Зураг 5.1).



81. ОУВС дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлээ. Олон Улсын Валютын сан 2026 оны 1 дүгээр сард 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг 3.3 хувь болгон шинэчлээд байна. Энэ нь цар тахлын өмнөх дунджаас (3.7 хувь) бага боловч 2025 оны 10-р сарын төсөөллөөс 0.1 хувиар, 7-р сарын төсөөллөөс 0.3 хувиар, 4-р сарын төсөөллөөс 0.5 хувиар тус тус өндөр байна. Өсөлтийн тооцоог нэмэгдүүлэхэд АНУ–Хятад тарифыг түр хугацаагаар хойшлуулсан, хиймэл оюун ухааныг дагасан технологийн хөрөнгө оруулалт нэмэгдсэн, хөрөнгийн зах зээл сэргэсэн, АНУ, Хятад, Герман зэрэг том эдийн засгуудын төсвийн тэлэлт зэрэг нөлөөлсөн. Хэдийгээр худалдааны дайны эдийн засагт үзүүлэх нөлөө анхны хүлээлтээс (2025 оны 4-р сард ОУВС дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2026 оны 1-р сарын төсөөллөөс 0.5

хувиар бууруулж 2.8 хувь болгосон) бага нөлөөтэй буюу 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл өмнөх оны мөн үеийн төсөөлөлтэй ижил түвшинд байна. ОУВС-аас дэлхийн эдийн засгийн өсөлт 2026 онд 3.3 хувьд хүрнэ гэж төсөөлж байна.

82. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2025 онд засгийн газрын зорилт 5 хувьд хүрлээ. Эдийн засгийн өсөлтийг үйлчилгээний салбар болон дэвшилтэт боловсруулах үйлдвэрлэл голчлон дэмжсэн бол үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт, дотоод эрэлт сул хэвээр байгаа нь эдийн засгийн идэвхжилийг хязгаарлав. Улирлаар авч үзвэл өсөлтийн эрч саарч, ДНБ-ийн өсөлт 1 дүгээр улиралд 5.4 хувиас 4 дүгээр улиралд 4.5 хувь болж буурсан байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2026-2027 онуудад 4-4.5 хувьд хүрч саарна гэж олон улсын байгууллагууд тооцоолж байна.

83. Евро бүсийн эдийн засаг 2025 онд 1.4 хувиар өсөж, өмнөх оны 0.9 хувийн өсөлтөөс эрчимжлээ. Бүсийн өсөлтөд дотоод эрэлт, ялангуяа үйлчилгээний салбарын сэргэлт эерэг нөлөө үзүүлсэн бол бүсийн эдийн засгийн 30 орчим хувийг бүрдүүлдэг ХБНГУ-ын аж үйлдвэрийн салбарын идэвхжил сул хэвээр байгаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байна. 2026 онд ХБНГУ-ын төсвийн тэлэлтийн нөлөөгөөр евро бүсийн эдийн засгийн өсөлт 1.3 хувьд хадгалагдана гэж ОУВС тооцоолж байна.

84. Технологийн хөрөнгө оруулалт болон төсвийн зарлага нэмэгдсэний нөлөөгөөр АНУ-ын эдийн засаг 2025 онд 2.1 хувиар тэллээ. Худалдааны хурцадмал байдал түр намдаж, АНУ төсвийн тэлэх бодлого хэрэгжүүлж, хиймэл оюун ухааныг дагасан технологийн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээс шалтгаалан ОУВС тус улсын эдийн засгийн 2025 оны өсөлтийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг 2.1 хувь болгож, өмнөх төсөөллөөс 0.1 нэгж хувиар, 2026 оны өсөлтийн төсөөллийг 2.4 хувь болгож, өмнөх төсөөллөөс 0.3 нэгж

хувиар нэмэгдүүлээд байна. Гэсэн хэдий ч бодлогын тодорхой бус байдал, худалдааны саад, хөдөлмөрийн зах зээлийн өсөлт саарснаар

эдийн засгийн өсөлт 2024 оны түвшин (2.8 хувь)-тэй харьцуулахад суларсан үзүүлэлттэй байна.

5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага

85. Лондоны металлын бирж дээрх цэвэр зэсийн дундаж үнэ 2025 онд 9,947 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 8.8 хувиар өссөн байна. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар цэвэр зэсийн дундаж үнэ 12,979 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 30.5 хувиар өссөн байна. Индонези, Чили улсад байрлах зэсийн томоохон уурхайнуудын үйл ажиллагаа ослын улмаас доголдож, зэсийн нийлүүлэлт буурснаар оны эхэнд дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ өсөхөд голлон нөлөөлөв. Дунд хугацаанд цахилгаан эрчим хүч болон технологид суурилсан салбаруудын өсөлтөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж, үнэ өсөх хүлээлттэй байна.

86. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2025 онд 189 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 22.4 хувиар буурсан байна. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар 233 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 23.6 хувиар өслөө. Австрали улсад их хэмжээний бороо орсноос шалтгаалан уурхай, тээвэр логистикийн үйл ажиллагаа доголдож, мөн уурхайн засвар үйлчилгээний саатлууд давхацсанаар нийлүүлэлт богино хугацаанд хумигдаж, үнэ өслөө.

87. Лондоны металлын бирж дэх алтны дундаж үнэ 2025 онд 3,446 ам.доллар/унц болж, өмнөх оноос 44.3 хувиар өссөн байна. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар 4,926 ам.доллар/унц болж, өмнөх оноос 42.9 хувиар өссөн байна. Геополитикийн зөрчил нэмэгдэж, олон улсын хурцадмал байдал өндөр хэвээр байгаа энэ үед

дэлхийн төв банкнуудын алтны худалдан авалт нэмэгдсэн нь алтны үнэ өсөхөд нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал нэмэгдэж байгаатай холбоотойгоор алтны үнэ тогтвортой байх төлөвтэй байна.


88. Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) үнэ 2025 онд 102 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 7.5 хувиар буурсан байна. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар 105 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 3.2 хувиар өслөө. Австрали, Бразил зэрэг улсуудын нийлүүлэлтийн өсөлт, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт төмрийн хүдрийн үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар богино хугацаанд сэргэх төлөвгүй байгаагаас гадна Австрали, Бразил зэрэг улсуудын олборлолт тогтвортой өсөхөөр байгаа тул төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байна.

89. Brent төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 онд 66 ам.доллар/баррель болж, өмнөх оны эцсээс 10.2 хувиар буурсан байна. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар 72 ам.доллар/баррель болж, өмнөх оны эцсээс 9.4 хувиар өслөө. Персийн булангийн бүсэд үүссэн зөрчлөөс шалтгаалан Ормузын хоолойн тээвэрлэлт багассантай холбоотойгоор дэлхийн газрын тосны нийлүүлэлтэд буурч, үнэ өсөхөд голлон нөлөөллөө. Геополитикийн тодорхой бус байдал нэмэгдэж, нийлүүлэлт тасалдах эрсдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор 2026 онд газрын тосны үнэ өсөх төлөвтэй байна.


Зураг 4.2. Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ

1. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн гүйцэтгэл (\$/тонн)

2. Зүүн хойд БНХАУ дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмалын гүйцэтгэл (\$/тонн)




Эх сурвалж: Блүүмберг



Эх сурвалж: Блүүмберг

3. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний гүйцэтгэл (\$/тонн)

4. Брент газрын тосны гүйцэтгэл (\$/баррель)



Эх сурвалж: Блүүмберг



Эх сурвалж: Блүүмберг

5.3. Олон улсад зарлагдсан индексүүд

90. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс: Фрэйзэр институтээс жил бүр тооцоолон гаргадаг Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр Монгол Улс 2025 онд дэлхийн 165 улсаас 75 дугаарт эрэмбэлэгдэж өмнөх оноос 1 байр урагшиллаа. Манай улсын үнэлгээг бүлгээр задалбал дараах байдалтай байна.

Зураг 4.3. Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн Монгол Улсын оноо, эрэмбэ

Бүлэг	2024		2025	
	Оноо	Байр	Оноо	Байр
Засгийн газрын хэмжээ	6.54▲	#91▼	6.75▲	#77▲
Хуулийн тогтолцоо ба өмчийн эрх	5.85▲	#58▼	5.77▼	#60▼
Мөнгөний үнэ цэнэ	7.51▲	#90▼	7.78▲	#83▼
Олон улсын худалдааны эрх чөлөө	7.29▲	#80▼	7.28▼	#80▼
Зохицуулалт	6.49▲	#73▲	6.57▲	#71▼
Нэгдсэн индекс	6.74▲	#76▼	6.83▲	#75▲

Манай улсын хувьд 2025 онд Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр 6.83 оноо авсан байна.

Үзүүлэлтээр задлан харвал Засгийн газрын хэмжээ бүлгийн үнэлгээ 0.21 оноогоор буюу 14 байраар, Мөнгөний үнэ цэнэ бүлгийн үнэлгээ 0.27 оноогоор буюу 7 байраар, Зохицуулалт бүлгийн үнэлгээ 0.08 оноогоор буюу 2 байраар тус тус ахисан байна.

Эдгээр үзүүлэлтүүдээр оноо ахисан боловч бусад улс орнуудын үнэлгээ мөн сайжирсан тул манай улсын эрэмбэ төдийлөн сайжраагүй байна. Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг тооцохдоо 5 бүлгийн 25 дэд бүлэг үзүүлэлтээр бүлэг бүрд ижил жин өгч тооцдог. 25 дэд бүлэг нь мөн цааш шалгуур үзүүлэлтүүдэд задардаг бөгөөд дэд бүлэг бүр харилцан адилгүй шалгуур үзүүлэлтүүдээр хэмжигддэг. Тухайлбал Мөнгөний үнэ цэнэ бүлэг зөвхөн 4 тоон үзүүлэлтээр хэмжигдэх бол Зохицуулалт бүлэг тоон болон чанарын 17 үзүүлэлтээр хэмжигдэж байна. Иймд хамгийн бага шалгуур үзүүлэлт

бүхий дэд бүлэг индексийн үнэлгээнд хамгийн их нөлөө үзүүлж байгаа гэж тооцвол Инфляцын түвшин дангаараа индексийн үнэлгээний 10 хувийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, инфляцын үзүүлэлтийг сайжруулснаар Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн үнэлгээг хамгийн хялбараар сайжруулах боломжтой гэсэн үг юм. Инфляцын үзүүлэлтийг инфляцын сүүлийн 5 жилийн стандарт хазайлт болон инфляцын жилийн дундаж түвшнээр хэмждэг бөгөөд үзүүлэлт бага гарах тусам сайн, өндөр гарах тусам муу гэж үнэлэгддэг. Гэтэл Монгол Улсын инфляцын жилийн дундаж түвшин 2022 он (Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2024 оны үр дүн нь 2022 оны тоо, мэдээлэлд суурилж тооцогдсон)-д 15.2 хувьд хүрч нэмэгдсэн нь индексийн үнэлгээг бууруулах гол шалтгаан болсон байна. Харин 2023 он (Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2025 оны үр дүн нь 2023 оны тоо, мэдээлэлд суурилж тооцогдсон)-д инфляцын түвшин 10.4 хувь болж өмнөх оноос 4.8 нэгж хувиар буурснаар тус үзүүлэлт сайжрахад нөлөөлсөн байна.

Тус индексээр Хонконг (БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс), Сингапур, Швейцар, Шинэ Зеланд, АНУ, Ирланд, Австрали ба Тайван (7-р байранд тэнцэж), Дани, Нидерланд зэрэг улсууд тэргүүлж байна. Эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтээр тэргүүлж буй улс орнуудад төрийн зохицуулалт бага, чөлөөт зах зээлийн тогтолцоо бүрдсэн байна. Тухайлбал, Хонконг (БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс) болон Сингапур нь өрсөлдөх чадвартай эдийн засагтай, бизнесийн чухал төвүүд бөгөөд мөнгөний бодлого тогтвортой, төрийн оролцоо бага байдаг нь бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх таатай орчныг бүрдүүлдэг байна. Чад, Ливи, Сир, Аргентин, Мьянмар, Иран, Алжир, Судан, Зимбабве, Венесуэл улсууд эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтээр жагсаалтын төгсгөлд эрэмбэлэгджээ. Эдгээр улсуудад авлига, хээл

хахууль өндөр, хуулийн хэрэгжилт сул, зохицуулалтын чанар муу, төрийн оролцоо өндөр байна. Үүний зэрэгцээ, тухайн улсуудын эдийн засгийн тогтворгүй байдал, инфляц болон валютын ханшийн хэлбэлзэл нь иргэдийн амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж,

дотоодын эдийн засгийн өсөлтөд саад болдог байна. Мөн эдгээр улсуудад дотоодын болон олон улсын худалдаанд оролцох хязгаарлалт, хамгаалалтын арга хэмжээ их байгаа нь эдийн засгийн эрх чөлөөг бууруулж байна.

5.4. Ногоон санхүүжилт

91. Монгол Улсын хөгжлийн бодлогод ногоон хөгжил, тогтвортой санхүүжилтийн зорилтуудыг тусгасан. Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд ногоон эдийн засаг, тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чиглэлээр зорилт, арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан. Тухайлбал, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, эрчим хүчний үр ашиг, ногоон барилга, тогтвортой дэд бүтэц, ус болон хог хаягдлын менежментийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүд тусгагдсан.

Эдгээр бодлогын зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд байгаль орчинд ээлтэй, нүүрстөрөгч багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй төслүүдийг санхүүжүүлэх хэрэгцээ нэмэгдэж байгаа тул ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх шаардлага нэмэгдсээр байна.


92. Дэлхийн хэмжээнд ногоон санхүүжилтийн хэрэгцээ, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж

тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн хэмжээ олон улсад эрчимтэй өсөх хандлагатай байна. Их Британийн TheCityUK байгууллагын төсөөллөөр дэлхийн ногоон санхүүжилтийн хэмжээ 2026 онд 4.7 их наяд ам.долларт хүрч, 2035 он гэхэд 22.7 их наяд ам.долларт хүрэх төсөөлөлтэй байна.


Энэхүү өсөлтөд Парисын Хэлэлцээрийн хэрэгжилт, улс орнуудын Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах бодлого, ногоон санхүүгийн хэрэгслүүдийн хөгжүүлэлт голлон нөлөөлж байна. Тухайлбал, ногоон бонд, тогтвортой санхүүжилт, холимог санхүүжилтийн хэрэгслүүдийн хэрэглээ нэмэгдэж байна. Уур амьсгалын санхүүжилтийн хэмжээ 2011-2012 онд 364 тэрбум ам.доллар байсан бол 2021-2022 онд 1.26 их наяд ам.долларт хүрч өссөн байна. Дэлхийн цаг уурын байгууллага (WMO)-ын тооцооллоор 2030 он хүртэл жил бүр 8.9 их наяд ам.доллар, 2050 он хүртэл 10.7 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа нь ногоон санхүүжилтийн хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

Зураг 4.4. Ногоон санхүүжилтийн өсөлт, эх үүсвэр

1. Дэлхийн ногоон санхүүжилтийн хэмжээ (их наяд ам.доллар)



2. Дэлхийн ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн бүтэц (хувь)



Эх сурвалж: TheCityUK санхүүгийн байгууллага

Эх сурвалж: Climate Policy Initiative – Global Landscape of Climate Finance

байна. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах,

Тогтвортой хөгжлийн санхүүжилтэд хувийн секторын оролцоо өндөр бөгөөд ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн 49 хувийг хувийн хэвшил, 19 хувийг үндэсний засгийн газар болон төрийн төсөв, 16 хувийг үндэсний хөгжлийн санхүүгийн байгууллагууд бүрдүүлж байна.

93. Ногоон төслийн үнэлгээ, бэлэн байдлыг хангах ажлууд хийгдэж байна. Ногоон төслүүдийн санхүүжилтийн бэлэн байдлыг хангах хүрээнд төслийн мэдээллийн сан бүрдүүлж, төслүүдийг Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн таксономийн ангилал, босго шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээд байна. Нийт 282 төслийн мэдээллийг нэгтгэснээс эрчим хүчний үр ашигтай хэрэглээ, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, тогтвортой ус, хог хаягдлын менежмент зэрэг чиглэлийн төслүүд зонхилж байна. Үүнээс 43 төслийг ногоон ангилалд хамруулан үнэлж, 28 төсөл босго шалгуур үзүүлэлт хангасан байна. Мөн 8 төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, 14 төсөлд санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай байгаа бол 6 төсөлд техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах хэрэгцээтэй байна. Төслүүдийн дийлэнх нь эрчим хүч, тогтвортой ус, хог хаягдал, нүүрстөрөгчийн ялгарал багатай тээврийн чиглэлд хамаарч байна.

Цаашид эдгээр төслүүдийн санхүүжилтийн бэлэн байдлыг сайжруулж, дотоодын болон олон улсын ногоон хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй

санхүүжилт татах чиглэлээр үе шаттай хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

94. Эдийн засаг, хөгжлийн яам ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх бодлогын чиглэлийг тодорхойлж байна. Эдийн засаг, хөгжлийн яамнаас бага ялгаруулалттай, уур амьсгалд тэсвэртэй хөгжлийн шилжилтийг дэмжих хүрээнд Ногоон санхүүгийн стратегийн төслийг боловсруулж байна. Тус стратеги нь "Алсын хараа-2050", Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН 3.0) зэрэг баримт бичгүүдтэй уялдсан бөгөөд ногоон шилжилтийг дэмжих төрийн, хувийн болон олон улсын санхүүгийн урсгалыг илүү уялдаатай, стратегийн чиглэлтэйгээр хөгжүүлэхэд чиглэж байна. Мөн төрийн санхүүгийн уялдаа, хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улсын санхүүжилтийг хөтөлбөрт суурилсан байдлаар татах, ногоон санхүүгийн тогтолцооны институтын уялдаа холбоог бэхжүүлэхэд чиглэсэн зохицуулалтын арга хэмжээг хамруулна.

Стратегийн хүрээнд ногоон санхүүжилтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төрийн, олон улсын болон хувийн санхүүгийн урсгалыг үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээг тодорхойлно. Түүнчлэн ногоон хөрөнгө оруулалт татах, төрөөс бодлогын дэмжлэгийг бодитоор үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, санхүүжилтийн механизмыг хөгжүүлэх, төсвийн урсгалыг байгальд ээлтэй зорилтуудтай уялдуулахад чиглэнэ.

Шигтгээ 3. Ногоон санхүүжилтийн тухай ойлголт

Ногоон санхүүжилт нь байгаль орчинд эерэг нөлөөтэй, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, байгалийн нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжих төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд чиглэсэн санхүүгийн урсгал, хөрөнгө оруулалт, санхүүгийн бүтээгдэхүүн, механизмыг хамардаг. Үүнд сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, ногоон барилга, тогтвортой тээвэр, ус болон хог хаягдлын менежмент, байгальд суурилсан шийдэл зэрэг чиглэлийн хөрөнгө оруулалт багтана.


Олон улсын түвшинд ногоон санхүүжилтийг тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан санхүүгийн тогтолцооны нэг хэсэг гэж үздэг. Дэлхийн банк нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, байгалийн нөөц болон биологийн олон янз байдлыг хамгаалах зорилготой санхүүжилтийг ногоон санхүүжилтэд хамруулдаг бол Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) нөөцийн үр ашиг, нүүрстөрөгчийн ялгарал бууруулах, тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих санхүүжилтийг энэ хүрээнд авч үздэг. Мөн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP)-өөс төрийн болон хувийн хэвшлийн санхүүгийн урсгалыг тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах үйл явцыг ногоон санхүүжилтийн үндсэн чиглэл гэж тодорхойлсон байна.

Ногоон санхүүжилтийн хүрээнд олон улсад дараах нэр томьёо, ойлголтууд өргөн хэрэглэгдэж байна.

- 1. Ногоон бонд (Green Bond):** Байгаль орчинд эерэг үр нөлөө бүхий төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор гаргаж буй өрийн санхүүгийн хэрэгсэл.
- 2. Тогтвортой хөгжлийн санхүүжилт (Sustainable Finance):** Байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйлс (Environment, Social, Governance–ESG)-ийг санхүүгийн шийдвэр гаргалтад тусган урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжих санхүүжилтийн тогтолцоо.
- 3. Уур амьсгалын санхүүжилт (Climate Finance):** Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн болон хувийн хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэр.
- 4. Ногоон эдийн засаг (Green Economy):** Нүүрстөрөгчийн ялгарал багатай, нөөцийн үр ашигтай, байгаль орчинд ээлтэй эдийн засгийн хөгжлийн загвар.
- 5. ESG (Environment, Social, Governance):** Байгаль орчин, нийгэм, засаглалын шалгуур үзүүлэлтийг хөрөнгө оруулалт, санхүүжилт болон компанийн үйл ажиллагаанд үнэлэх аргачлал.
- 6. Холимог санхүүжилт (Blended Finance):** Төрийн болон хөгжлийн санхүүжилтийг хувийн хөрөнгө оруулалттай хослуулан хөгжлийн ач холбогдолтой төслүүдийг санхүүжүүлэх механизм.
- 7. Ногоон таксономи (Green Taxonomy):** “Ногоон” гэж ангилах эдийн засгийн үйл ажиллагаа, төсөл, хөрөнгө оруулалтын шалгуур, ангиллын тогтолцоо.
- 8. Нүүрстөрөгчийн зах зээл (Carbon Market):** Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор нүүрстөрөгчийн нэгж, кредитийг арилжаалах тогтолцоо.
- 9. Шилжилтийн санхүүжилт (Transition Finance):** Өндөр ялгаруулалттай салбар, үйлдвэрлэлийг бага ялгаруулалттай, тогтвортой хэлбэрт үе шаттай шилжүүлэхэд чиглэсэн санхүүжилт.


Зураг 4.5. Ногоон зээлийн өнөөгийн нөхцөл байдал

1. Ногоон зээлийн үлдэгдэл, улирлаар



Эх сурвалж: Монгол банк

2. Нийт зээлийн үлдэгдэлд ногоон зээлийн эзлэх хувь, улирлаар




Эх сурвалж: Монгол банк

3. Ногоон зээлийн үлдэгдэл, салбараар (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Монгол банк

4. Банкуудын нийт зээл ба ногоон зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь




Эх сурвалж: Монгол банк

5. Ногоон шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХүү, жилээр



Эх сурвалж: Монгол банк

6. Ногоон шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХугацаа, сараар



Эх сурвалж: Монгол банк

Бүлэг 6-7

МОНГОЛЫН ТҮҮХЭН ЭДИЙН ЗАСАГ

6. Макро эдийн засгийн нөхцөл байдал: 2021-2025

7. Макро эдийн засгийн нөхцөл байдал: 2005-2020

6. Макро эдийн засгийн нөхцөл байдал (2021-2025)


6.1. Эдийн засгийн өсөлт

Монгол Улсын эдийн засаг 2025 онд урьдчилсан гүйцэтгэлээр 6.8 хувиар өсөж, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2020 оны түвшнээс 2.4 дахин тэлж 89.9 их наяд төгрөгт хүрлээ.

Нэг хүнд ногдох нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 2025 онд 7.4 мянган ам.долларт хүрч, 2020 оны түвшнээс 1.8 дахин нэмэгдсэн байна.

Эдийн засгийн бүтцийг авч үзвэл сүүлийн таван жилд уул уурхай, тээвэр, санхүү, даатгалын салбарын эзлэх хувь нэмэгдэж, мэдээлэл холбоо, худалдааны салбарын эзлэх хувь тогтвортой байна. Харин хөдөө аж ахуй, боловсруулах, барилга, эрчим хүчний салбарын эзлэх хувь буурсан байна.

Зураг 6.1. Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2025 оны дунджаар 17.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх өмнөх 5 жилийн дунджаас 128 хувиар өсөж, 2015 үнээр засварласан дүнгээр 3.9 их наяд төгрөг болж, өмнөх таван жилээс 0.8 хувиар буурсан байна. Харин тээврийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2025 оны дунджаар 3.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх 5 жилийн дунджаас 131.6 хувиар, 2015 үнээр

засварласан дүнгээр 1.7 их наяд төгрөг болж, өмнөх таван жилээс 23.8 хувиар тус тус өссөн байна.

Зураг 6.2. Эдийн засгийн бүтэц хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

“Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд гааль, татварын автомат бүрдүүлэлтийн системийг нэвтрүүлж, ашигт малтмалын гэрээг бүртгэлжүүлж, хил холболт, тээвэр, логистикийн зохион байгуулалт сайжирснаар, экспортын хүчин чадал тэлж, уул уурхай, тээврийн салбарын өсөлтийг голлон дэмжлээ. Нүүрс олборлолтын хэмжээ 2023 онд 85.3 сая тонн хүрч өмнөх оноос 2.3 дахин нэмэгдсэн бол нүүрсний экспортын орлого 8.9 тэрбум ам долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 29 хувиар өсөж, нийт экспортын 58 хувийг дангаараа бүрдүүлсэн байна. Түүнчлэн тус тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2022 онд төмөр замын тарифт өөрчлөлт оруулж, салбарыг үе шаттай либералчлах замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлээ. Жишээлбэл, УБТЗ ХНН-ийн дотоодын ачаа тээврийн 16, зорчигч тээврийн 2 бүлгийн үнэ, тарифыг өөрчилж, БНХАУ-ОХУ чиглэлийн чингэлэг тээвэрлэлтэд олгож буй дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн нэгдсэн нэвтрэх

тарифын хөнгөлөлтийг 61 хувиас 51 хувь болгон бууруулав.

Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ⁶ 2021-2025 оны дунджаар 6.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх өмнөх 5 жилийн дунджаас 76 хувиар, 2015 үнээр засварласан дүнгээр 3.7 их наяд төгрөг болж, өмнөх таван жилээс 1 хувиар тус тус өссөн байна. Сүүлийн жилүүдэд тохиолдсон зудын хүндрэлийн нөлөөгөөр тус салбарын үйлдвэрлэлийн 90 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн салбар агшаад байсан ч 2025 онд урьдчилсан гүйцэтгэлээр салбарын нийт үйлдвэрлэл 33.2 хувиар өсөв. Тухайлбал, 2021 онд 3.0 сая толгой мал хорогдож, оны эхэнд тоологдсон нийт малын 4 хувь, 2023 онд 4.9 сая толгой мал хорогдож 7 хувь, 2024 онд 9.4 сая толгой мал хорогдож 14 хувьд тус тус хүрсэн бөгөөд малын тоо 2024 оны эцэст 57.6 сая толгойд хүрч буурсан байна.

Харин 2025 онд цаг агаарын нөхцөл харьцангуй таатай байснаар малын хорогдол буурч, нийт малын тоо жилийн эцсийн байдлаар 58.1 сая толгойд хүрч өсөв. Гэсэн хэдий ч хүнсэнд хэрэглэсэн малын тоо 20 саяд хүрсэн нь малын тоо толгойн өсөлтийг хязгаарлаж, 2025 онд мал сүргийн тоо сэргэх хүлээлттэй байсан ч өсөлтийн хурд нь өмнөх 5 жилийн дунджаас 3 хувиар бага байв.

Нийт тариалсан талбайн 60 орчим хувийг бүрдүүлдэг улаан буудайн тариалалтын хэмжээ 2021-2024 онд алгуур буурсан байна. Үүнтэй холбоотойгоор хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангах, мөн мал аж ахуй, газар тариалангийн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр болсон. Улмаар

⁶ Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 2025 оны эхний хагас жилд 4.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 44 хувиар өссөн байна.

Монгол Улсын Их Хурал 2022 онд “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолыг баталж, уг хөдөлгөөнийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Тус хөдөлгөөнөөр төмс, манжин, лууван, сонгино, байцаа зэрэг өргөн хэрэглээний, гол нэр төрлийн жимс-хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримталж, 2024 оны байдлаар нийт 3,160 аж ахуйн нэгжид 1,261 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, хүнсний ногооны тариалалтыг дэмжсэн байна. Үр дүнд төмс хүнсний ногоо тариалсан талбай 2021-2024 оны дунджаар 36 мянган га талбайд хүрч, өмнөх таван жилийн дунджаас 11 мянган га-аар, хураасан төмс, хүнсний ногооны хэмжээ 397 мянган тоннд хүрч, өмнөх таван жилийн дунджаас 1.4 дахин тус тус нэмэгдээд байв. Харин 2025 оны эхний хагаст тариалангийн гол бүс нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас унаснаар нийт хураасан үр тариа өмнөх оноос 148.6 мянган тонн, төмс 137.3 мянган тонн, хүнсний ногоо 42.5 мянган тонн, тэжээлийн ургамал 61 мянган тонноор тус тус буурсан байна.

Боловсруулах салбарын үйлдвэрлэлийн хэмжээ⁷ 2021-2025 оны дунджаар 4.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх 5 жилийн дунджаас 85 хувиар, 2015 оны үнээр засварласан дүнгээр 2.4 их наяд төгрөгт хүрч, 24 хувиар тус тус өссөн байна. Тус салбарын 55 орчим хувийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ундаа үйлдвэрлэл, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл бүрдүүлж байна. Үүнд, тус салбарын 30 орчим хувийг бүрдүүлдэг мах, махан бүтээгдэхүүний 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2025 онд жилд дунджаар 800 тэрбум төгрөгт хүрч, өмнөх таван жилийн дундаж үйлдвэрлэлээс 21 хувиар тэлж, боловсруулах салбарын өсөлтийг дэмжлээ. Засгийн газар 2023

⁷ Боловсруулах салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 2025 оны эхний хагас жилд 2.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 9 хувиар өссөн байна.

оны 2 дугаар сард махны экспортын тоо хэмжээний хязгаарлалтыг цуцалж, 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс "Экспортын гэрчилгээний нэг цонхны цахим систем"-ийг нэвтрүүлснээр махны экспорт эрчимжин түүхэн дээд хэмжээнд хүрч, мах боловсруулах үйлдвэрлэлийн өсөлтөд томоохон нөлөө үзүүлээ. Боловсруулсан малын мах 2021-2025 онд жилд дунджаар 47.5 мянган тонн хүрч, өмнөх таван жилийн дунджаас 1.5 дахин нэмэгдсэн байна. Боловсруулах салбарын 15 орчим хувийг бүрдүүлдэг ундааны (согтууруулах болон согтууруулах бус ундаа) 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит үйлдвэрлэл 2021-2025 онд жилд дунджаар 377 тэрбум төгрөгт хүрч, өмнөх таван жилийн дундаж үйлдвэрлэлээс 32 хувиар тэлж, салбарын өсөлтийг дэмжлээ. Мөн цэвэр ус, амтат ус, ундаа, шүүсний 2021-2025 оны жилийн дундаж үйлдвэрлэл 416 сая литр хүрч, өмнөх таван жилийн дунджаас 1.4 дахин, шар айргийн үйлдвэрлэл 97 сая литр хүрч, 1.1 дахин, архи үйлдвэрлэл 27.6 сая литр хүрч 1.1 дахин тус тус өссөн байна. Түүнчлэн, тус салбарын 10 орчим хувийг бүрдүүлдэг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүний (цемент, тоосго, шохой, гипс, чулуун тавилга үйлдвэрлэх үйл ажиллагаа зэрэг) 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2025 онд жилд дунджаар 323 тэрбум төгрөгт хүрч, өмнөх таван жилийн дунджаас 109 хувиар тэлсэн байна. Харин боловсруулах салбарын 5 орчим хувийг бүрдүүлж буй сүү, сүүн бүтээгдэхүүний бодит үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх таван жилийн дунджаас 9 хувиар, 2 орчим хувийг бүрдүүлдэг үр тарианы гурил, цардуул, цардуулаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл 13 хувиар, 3 орчим хувийг бүрдүүлдэг нэхмэлийн үйлдвэрлэл 34 хувиар тус тус буурч, өсөлтийг хязгаарлав. Мөн малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний

бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг эрс нэмэгдүүлэх зорилгоор "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолыг баталсан. Тус тогтоолын хүрээнд "Цагаан алт" хөдөлгөөнийг хэрэгжүүлж, 2025 оны байдлаар нийт 46 аж ахуйн нэгжид 228 тэрбум төгрөгийн эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл олгож, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүний үр дүнд самнасан ноолуурын хэмжээ 2025 оны эцэст 4.0 мянган тонн хүрч, өмнөх оны мөн үеэс 6.4 дахин өссөн боловч ноолуурын экспорт 358 сая ам.долларт хүрсэн байна.

Барилгын салбарын үйлдвэрлэлийн хэмжээ⁸ 2021-2025 оны дунджаар 2.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх 5 жилийн дунджаас 111 хувиар өссөн бол 2015 оны үнээр засварласан дүнгээр 0.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх таван жилийн дунджаас 0.1 хувиар буурсан байна. Барилгын салбар дах нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 2021-2024 оны дунджаар 8.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх таван жилийн дунджаас 1.9 дахин буюу 3.8 их наяд төгрөгөөр тэлсний 48 хувийг төсвийн хөрөнгө оруулалт бүрдүүлсэн байна. Төсвийн хөрөнгө оруулалтын 2021-2025 оны дундаж хэмжээ 4.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх таван жилийн дунджаас 132 хувиар тэлэв. Төсвийн хөрөнгө оруулалтын нөлөөгөөр эмнэлэг, сургуулийн барилга, Өмнөговь аймаг дахь үйлдвэрийн зориулалттай барилга байгууламж, Улаанбаатар хотын авто зам, далан, суваг, шугам, сүлжээний ажлууд хийгдэж барилгын салбарын өсөлтийг дэмжив. Түүнчлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр орон сууцны барилгын бүтээн байгуулалт, Тавантолгой-Манлай-Ханги боомт чиглэлийн тусгай зориулалтын авто зам, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам, Бөөрөлжүүт ДЦС, Тосон ДЦС зэрэг эрчим

⁸ Барилгын салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 2025 оны эхний хагас жилд 0.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 29 хувиар өссөн байна.

хүчний барилгын бүтээн байгуулалтын ажлууд эрчимжиж барилгын салбарын өсөлтийг голлон дэмжлээ.

Худалдааны салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2025 оны дунджаар 7.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх 5 жилийн дунджаас 122.4 хувиар, 2015 оны үнээр засварласан дүнгээр 3.5 их наяд төгрөгт хүрч, 20.0 хувиар тус тус өссөн байна. Засгийн газар цар тахлаас үүдэн Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд бий болсон хүндрэлүүдийг даамжрахаас сэргийлэх зорилгоор "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-г баталсан. Хөтөлбөрийн хүрээнд олгогдсон нийт зээлийн 50 орчим хувь нь ажлын байрыг дэмжих зээл хэлбэрээр гарч, эдийн засгийн дотоод идэвхжилийг дэмжсэнээр худалгаа, үйлчилгээний салбарын өсөлтийг дэмжлээ.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2025 оны дунджаар 1.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх 5 жилийн дунджаас 84.7 хувиар, 2015 оны үнээр засварласан дүнгээр 0.7 их наяд төгрөгт хүрч, 35.6 хувиар тус тус өссөн байна. Эдийн засгийн эрчимжилттэй холбоотойгоор эрчим хүчний нийт хэрэглээ жилд дунджаар 6-10 хувиар тогтмол өсөж байгаа ч дэд бүтцийн хүрэлцээгүй байдал, шугам сүлжээ, тоноглолын өндөр насжилт (32-62 жил) зэргээс шалтгаалан нийлүүлэлтийн хэмжээ дутагдалтай байна. Иймд Монгол Улсын Их Хурлын 2021 106 дугаар "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" тогтоолоор эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх хүрээнд "Эрчим хүчний сэргэлт"-ийн зорилтыг дэвшүүлж, эрчим хүчний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Үүний үр дүнд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ жил бүр нэмэгдүүлж байгаа ч, хэрэглээний өсөлтийг гүйцэж чадахгүй байна. Иймд 2024 онд цахилгаан эрчим хүчний

үнийг нэмэгдүүлэн үйлдвэрлэлийн өртөгт хүргэх эрчим хүчний салбарт либералчлалыг эхлүүлж, эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн бие даасан байдлыг дэмжсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Эдийн засгийн өсөлтийг нийт эрэлтийн талаас авч үзвэл цар тахлын улмаас бүх нийтийг хамарсан хөл хорионы дэглэмийг 2020 оны 2 дугаар сараас эхлэн тогтоосноор бүх төрлийн бизнесийн үйл ажиллагаа саатав. Улмаар хэрэглээний зээл олголт 2020 онд 9.2 хувиар буурч, 2021 онд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2.3 нэгж хувиар, өрхийн цалин хөлсний бодит орлого 14.3 хувиар тус тус буурч, өрхийн бодит орлого өсөлтгүй байв. Өрхийн бодит орлогын бууралтыг даган дотоодын нийт бүтээгдэхүүний томоохон бүрэлдэхүүн хэсэг болох өрхийн хэрэглээ алгуур саарснаар 2021 онд 5.9 хувиар хумигдан, эдийн засгийн дотоод эргэлт удаашрав. Тухайлбал, цар тахлын эхэн үед иргэд хүнс нөөцлөх хандлага нэмэгдэж өрхийн хүнсний хэрэглээ 2020 онд 5.7 хувиар өссөн суурийн нөлөөгөөр 2021 онд хүнсний хэрэглээ саарав. Төрөөс айл өрх, зарим аж ахуйн нэгжийн цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тэглэх арга хэмжээ хэрэгжүүлснээр өрхийн хүнсний бус барааны зардал 2020 онд өсөлтгүй, 2021 онд 5.5 хувиар буурсан. Мөн хатуу хөл хорионы үеэр үзвэр үйлчилгээ, тээврийн зардал эрс буурч, өрхийн үйлчилгээнд зарцуулах зардал 2020 онд 5 хувиар, 2021 онд 6.7 хувиар тус тус хумигдаж өрхийн хэрэглээг сааруулах нөлөө үзүүлэв. Хэрэглээний сааралт хуримтлалыг дэмжсэнээс гадна, төрөөс иргэдийн амьжиргааг хамгаалах зорилгоор хүүхдийн мөнгө, халамж, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, вакцинжуулалтад хамрагдсаны урамшуулал зэрэг мөнгөн тэтгэмжийн арга хэмжээг авч хэрэгжүүлснээр иргэдийн хадгаламжийн 2020 оны 26 хувийн, 2021 оны 6.1 хувийн өсөлтийг дэмжив. Хөл хориог 2021 оны сүүлийн хагаст сулруулж, 2022 оноос эдийн засгийн үйл ажиллагаа бүрэн хэвийн

байдалд шилжүүлсэн. Хөл хорионы улмаас хуримтлагдсан эрэлт, хэрэгцээ, хадгаламжийн өсөлтийн нөлөөгөөр 2022 оны төгсгөл, 2023 онд иргэдийн худалдан авалт эрчимжин, дотоод идэвхжил нэмэгдэн өрхийн хэрэглээ 2022 онд 8.1 хувиар, 2023 онд 9.7 хувиар тус тус тэлж, эдийн засгийн сэргэлтийг дэмжсэн.

Цар тахлын үед БНХАУ-ын талаас авч хэрэгжүүлсэн хилийн хатуу хориг, "ТЭГ-КОВИД" цар тахлын эсрэг бодлогын хүрээнд хил гаалийн үйл ажиллагаа зогсож, бараа, үйлчилгээний экспортын өсөлт 2020 онд 5.3 хувиар, 2021 онд 14.6 хувиар буурсан нь эдийн засгийн өсөлтийг бууруулах гол нөлөөг үзүүлэв. Харин 2022 онд тээвэр, логистикийн саатал арилсны зэрэгцээ дэлхийн зах зээл дэх нүүрсний үнэ өсөж, манай улсын экспортын нүүрсний хилийн дундаж үнэ 2022 оны сүүлийн хагасаас 204 ам.долларт хүрч нэмэгдсэн. Үүний зэрэгцээ, Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилго бүхий Засгийн газрын 362 дугаар тогтоолыг батлуулж хэрэгжүүлснээр 2022 оны сүүлийн хагасаас нүүрсний экспортын тоо хэмжээ нэмэгдэж эхэлснээр эдийн засгийн сэргэлтэд томоохон нөлөө үзүүлэв. Нүүрсний үнэ 2023 онд 105 ам.доллар болж буурсан хэдий ч экспортын тоо хэмжээ өссөний үр дүнд экспортын орлого өсөлтөө хадгалж, эдийн засгийн сэргэлтийг дэмжсээр байв. Тухайлбал, барааны экспортын бодит өсөлт 2022 онд 30.0 хувь, 2023 онд 31.2 хувьд хүрч байв.

Төрийн албан хаагчдын цалин, урамшууллыг хэд хэдэн удаа үе шаттай нэмэгдүүлсэн нь төрийн хэрэглээ 2020-2024 онд жилд дунджаар 8.4 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн. Түүнчлэн экспортын орлогын өсөлтийг даган 2021-2023 онд төсвийн орлого бүрдүүлэлтийн нэрлэсэн өсөлт жилд дунджаар 35.0 хувьд хүрч, төрийн хэрэглээний нэрлэсэн өсөлт 2023 онд 22.2 хувь, 2024 онд 36.2 хувьд тус тус хүрэв.

Хил гаалийн хатуу хориг, БНХАУ-ын "ТЭГ-КОВИД" бодлогын улмаас экспортод гараагүй уул уурхайн түүхий эдийн овоолго их хэмжээгээр хуримтлагдсаны улмаас хөрөнгийн хуримтлал 2021 онд 80.7 хувиар өссөн бол 2022 оноос экспорт сэргэснээр нүүрсний овоолго эргэн буурч, хөрөнгийн хуримтлалын өсөлт хэвийн түвшинд буюу 11.2 хувиар нэмэгдсэн. Эх үүсвэр талаас зээл олголт 2019 онд 5 хувиар, 2020 онд 6 хувиар тус тус буурсан байсан бол 2021-2024 онд жилд дунджаар 26.3 хувиар өссөн. Мөн төсвийн хөрөнгө оруулалтын өсөлт 2023 онд 33.7 хувиар, 2024 онд 50.5 хувиар өссөн байна. Хөрөнгийн эх үүсвэр өсөлттэй байсны үр дүнд үндсэн хөрөнгө 2021-2024 онд жилд дунджаар 13.4 хувиар өслөө. Түүнчлэн Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт эрчимжсэн болон нүүрс тээврийн хүнд даацын ачааны машины импорт нэмэгдсэний нөлөөгөөр машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт 2021-2024 онд жилд дунджаар 21.7 хувиар нэмэгдсэн нь мөн хөрөнгийн хуримтлалын өсөлтийг бүрдүүлж байв. Эдийн засгийн өсөлт эрэлт талаас 2025 онд 6.9 хувьд өмнөх жилээс эрчимжсэн байна. Уул уурхайн салбарын үйл ажиллагааны идэвх хадгалагдаж, экспорт нэмэгдсэний зэрэгцээ импортын хэмжээ буурснаар цэвэр экспорт 2025 онд 12 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг голлон дэмжлээ. Мөн эцсийн хэрэглээ 5.7 хувиар өсөж, нийт өсөлтийг дэмжсэн байна. Үүнд, төрийн хэрэглээ буурсан хэдий ч өрхийн бодит орлогын өсөлт оны турш тогтвортой хадгалагдсанаар өрхийн хэрэглээ 2025 онд 9.2 хувиар өсөж, эцсийн хэрэглээг дэмжсэн байна. Төрийн албан хаагчийн цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэх шийдвэрийн голлох нөлөөгөөр өрхийн цалин хөлсний орлого 2025 оны улирлын дунджаар 4 хувьд тогтвортой хадгалагдаж, өрхийн бодит орлогын өсөлт оны турш тогтвортой хадгалагдлаа. Түүнчлэн хөдөө


аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр
өрхийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орлого
нэмэгдэж, өрхийн орлогыг дэмжив.

6.2. Инфляц

Инфляцын түвшин 2021-2025 онд жилд дунджаар 9.8 хувьд хүрсэн нь өмнөх таван жилийн дунджаас 5.3 нэгж хувиар өндөр байсан бөгөөд гадаад, дотоод орчны тодорхой бус байдлын нөлөөгөөр хэлбэлзэл ихтэй байв.

Хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ 2021-2024 онд жилд дунджаар 14 хувиар өсөж, нийт инфляцын 3.7 нэгж хувийг бүрдүүлжээ. Хүнсний инфляцад мах, хүнсний ногоо, гурил, гурилан бүтээгдэхүүн болон сүүн бүтээгдэхүүнүүд голлох нөлөөтэй байв. Тухайлбал, 2021-2022 онд цар тахлын улмаас тээвэр, логистикийн хүндрэл, саатал үүссэн, дэлхийн хүнсний үнийн индекс өссөн, малын гоц халдварт өвчин гарсан зэрэг нийлүүлэлтийн шалтгаантай хүчин зүйлсийн нөлөөгөөр хүнсний инфляц эрчимжсэн байна. Мөн 2022 онд үйлдвэрлэлийн зардал, шатахуун болон цаг уурын хүндрэлээс үүдэлтэйгээр гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ 34.2 хүртэлх хувиар өсөж, инфляцыг 2.4 нэгж хувиар нэмэгдүүлжээ. Харин 2023-2024 онд тохиосон зудын нөлөөгөөр 2024 онд малын зүй бус хорогдол 9.4 сая толгойд хүрснээр 2024 оны сүүлээс махны үнэ улирлын хандлагаасаа өндрөөр өсөж, инфляцыг 1.2 нэгж хувиар нэмэгдүүлсэн байна.

Зураг 6.3. Инфляцын бүрэлдэхүүн (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүнсний бус бараа, үйлчилгээний үнэ 2021-2024 онуудад жилд дунджаар 8.2 хувиар өсөж, нийт инфляцын 6.2 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний бус инфляцад хувцас, бөс бараа, гутал, тээвэр болон боловсролын үйлчилгээний үнийн өсөлт өндөр нөлөөтэй байлаа. Тухайлбал, 2021 онд дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өссөнөөр шатахууны үнэ 1450 төгрөгөөс 2200 төгрөг болж огцом нэмэгдэж, инфляцыг 2.2 нэгж хувиар нэмэгдүүлэв. 2022 онд геополитикийн хурцадмал нөхцөл байдал үүссэн, худалдааны түнш орнуудын инфляц өссөн, шатахууны үнэ нэмэгдэж, тээвэр, логистикийн саатал үргэлжилсэн зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр импортын барааны инфляц 16.5 хувьд хүрч, нийт инфляцын дийлэнх хэсгийг бүрдүүлсэн. Мөн БНХАУ-ын "ТЭГ-КОВИД" бодлогын улмаас хил, гаалийн үйл ажиллагаа зогсож, экспортын орлого буурснаар гадаад валютын нөөц 2022 оны 8 дугаар сард 2.7 тэрбум ам.доллар болж, манай улсын импортын төлбөрийн 3 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрч буурав. Гадаад валютын нөөц буурснаар төгрөгийн ханшийн сулрал эрчимжиж, улмаар импортын барааны үнийн өсөлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. Харин Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоол хэрэгжиж эхэлснээр гадаад валютын албан нөөц нэмэгдэн, валютын зах зээл тогтворжсоноор импортын инфляц алгуур буурч, инфляцыг тогтворжуулахад эерэг нөлөөтэй байв. Үүний зэрэгцээ инфляцад өндөр нөлөө бүхий АИ-92 авто бензинийг 2023 оны 3 дугаар сараас эхлэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон "Роснефть" ХН хооронд хийсэн хэлцлийн хүрээнд хөнгөлөлттэй үнээр авах болсноор үнэ тогтвортой байх боломж бүрдэж, тээврийн бүлгийн инфляцад үзүүлэх нөлөө тогтворжсон. Улмаар 2024 оны эхний хагас хүртэл инфляц буурах хандлагатай, төв банкны зорилтот түвшинд байсан бол эдийн засгийн идэвхжилээс үүдэлтэйгээр эрэлтийн гаралтай инфляц өсөхийн зэрэгцээ импортын болон үйлчилгээний үнийн

өсөлт эрчимжиж, оны сүүлийн хагаст инфляц өссөн байна.

6.3. Хөдөлмөр эрхлэлт

Монгол Улсын хүн амын өсөлт удааширч, хөдөлмөрийн насны хүн амын өсөлтийг сааруулж байна. Тухайлбал, оршин суугаа хүн амын тоо 2016-2020 онд дунджаар 1.7 хувиар өсөж байсан бол өсөлт саарч 2021-2024 онд дунджаар 1.4 хувь болж буурав. Монгол Улсад оршин суугаа нийт хүн амын тоо 2024 оны байдлаар 3.44 сая байна. Үүнээс 66 хувь буюу 3 хүн тутмын 2 нь хөдөлмөрийн насных байх бөгөөд 2024 оны байдлаар хөдөлмөрийн насны хүн ам⁹ 2.35 сая байна.

Ажиллагчдын тоо 2021 онд 1.21 сая хүн байсан бол 2021-2024 онд жилд дунджаар 4 хувиар өсөж, 2024 онд 1.36 саяд хүрч нэмэгдсэн байна. Ажилгүй иргэдийн тоо цар тахлын нөлөөгөөр 2021 онд 109 мянгад хүрч нэмэгдсэнээр ажилгүйдлийн түвшин 8.3 хувьд хүрсэн бол цар тахлын дараа ажилгүйдэл буурч 2023 онд 72.6 мянга, 2024 онд 85.4 мянгад хүрч ажилгүйдлийн түвшин 2023 онд 5.3, 2024 онд 5.9 хувьтай гарсан байна.


Ажиллах хүч 2021 онд 1 сая 317 мянган хүн байсан бол 2024 онд 1 сая 441 мянгад хүрч өссөн боловч хөдөлмөрийн насны хүн амд харьцуулж харвал ажиллах хүчний оролцооны түвшин цар тахлын өмнөх түвшиндээ бүрэн хүрч сэргээгүй байна. Тодруулбал, цар тахлын өмнө 2019 онд ажиллах хүчний оролцооны түвшин 62.8 хувь байсан бол цар тахлын үед 2021 онд 59.1 болтлоо буурч, цар тахлын дараа эдийн засаг идэвхжихэд эргэн сэргэсэн хэдий ч 2024 онд 61.3 хувьтай гарчээ.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо 2021 онд 910 мянга байсан бол 2024 онд 912 мянга болсон байна.

⁹ Хөдөлмөрийн насны хүн ам гэдэг нь 15-аас дээш насны хүн ам бөгөөд ажиллах хүч (ажиллагчид, ажилгүйчүүдийн нийлбэр) болон ажиллах хүчнээс гадуурх хүн амаас бүрддэг.

Ажиллагчдыг салбараар авч үзвэл 2024 онд 3 ажиллагч тутмын 1 буюу 465 мянган хүн үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхэлж байна. Нийт ажиллагчдад эзлэх үйлчилгээний салбарын ажиллагчдын хувь 2021 онд 32 хувь байсан бол 2024 онд 34 хувьд хүрч нэмэгджээ. Харин хөдөө аж ахуйн салбарын ажиллагчдын тоо 2021 онд

Зураг 6.4. Ажиллагчдын тоо, салбараар (нийт ажиллагчдад эзлэх хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

346 мянга байж нийт ажиллагчдын 29 хувийг эзэлж байсан бол сүүлийн 2 жил дараалсан зудын голлох нөлөөгөөр 2024 онд 305 мянга болж нийт ажиллагчдын 22 хувь болон буурчээ. Худалдааны салбарын хувьд 2021 оны байдлаар 152 мянга буюу нийт ажиллагчдын 13 хувийг бүрдүүлж байсан нь 2022, 2023 онд бага зэрэг буурсан хэдий ч 2024 онд салбарын өсөлтийн нөлөөгөөр ажиллагчид нэмэгдсэнээр 195 мянгад хүрч, нийт ажиллагчдын 14 хувийг бүрдүүлэв. Түүнчлэн уул уурхайн салбарт ажиллагчид 2021 онд 63 мянга байсан нь салбарын өсөлтийн нөлөөгөөр жилд дунджаар 9 хувиар өсөж 2024 онд 77 мянгад хүрчээ.

Хөдөлмөрийн бүтээмжийн¹⁰ өсөлт нийт эдийн засгийн өсөлттэй уялдсан хэдий ч салбар хоорондын бүтээмжийн зөрүү улам гүнзгийрсэн байна. 2021 онд нэг ажиллагчид ногдох дундаж

¹⁰ Хөдөлмөрийн бүтээмж нь нэг ажиллагчид ногдох бодит ДНБ-ээр хэмжигдэнэ.

бүтээмж 21.2 сая төгрөг байсан бол сүүлийн 4 жилийн хугацаанд жилд дунджаар 2 хувиар өсөж, 2024 онд 22.6 сая төгрөгт хүрчээ. Салбараар авч үзвэл, 2021 онд хамгийн өндөр бүтээмжтэй байсан уул уурхайн салбарын түвшин 58.5 сая төгрөг байснаас 2024 онд 56.7 сая төгрөг болж 3 хувиар буурсан байна. Харин 2021 онд 52.3 сая төгрөгийн бүтээмжтэй байсан санхүү, даатгалын салбарын бүтээмж 2024 онд 24 хувиар өсөж 64.8 сая төгрөгт хүрсэн нь хамгийн өндөр бүтээмжтэй салбар болжээ. Мөн зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний салбарын бүтээмж 2021 онд хамгийн бага буюу 7.4 сая төгрөг байсан бол 2024 онд 11.5 сая төгрөгт хүрч 56 хувиар өссөн байна. Харин хөдөө аж ахуйн салбарын бүтээмж 2021 онд 11 сая төгрөг байсан ч 2024 онд 8.4 сая төгрөг болж 24 хувиар буурснаар хамгийн бага бүтээмжтэй салбар болсон байна.

6.4. Нэгдсэн төсөв

Нэгдсэн төсвийн нийт орлого цар тахлын өмнө буюу 2019 онд 12.0 их наяд төгрөг буюу ДНБ-ий 31.8 хувь, нийт зарлага 11.7 их наяд төгрөг буюу ДНБ-ий 30.8 хувьтай байсан бол уул уурхайн салбарын өсөлтийг даган сүүлийн 5 жилд тэлж, 2025 онд төсвийн орлого 32.6 их наяд төгрөг буюу ДНБ-ий 36.3 хувьд, төсвийн зарлага 31.3 их наяд төгрөг буюу ДНБ-ий 34.8 хувьд хүрч¹¹, 2019 онтой харьцуулахад ойролцоогоор 3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Тухайлбал, төсвийн орлого дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ өндөр байсан, экспортын хилийн боомтуудын өргөтгөл, шинэчлэлийн ажлуудын үр дүнд 2023 онд нүүрсний экспортын биет хэмжээ 69.6 сая тонн, 2024 онд 83.8 сая тоннд тус тус хүрч цар тахлын өмнөх үетэй харьцуулахад уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх орлого ойролцоогоор 2 дахин нэмэгдсэн байна.


Мөн Засгийн газрын 2022 оны “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоол хэрэгжсэнээр ашигт малтмалыг нээлттэй дуудлага худалдаагаар борлуулах уул уурхайн биржийн тогтолцоо бий болж, ашигт малтмалын олборлолтоос экспорт хүртэлх бүх үе шатанд цахим бүртгэл хийж, татварын тооцоолол, тайлагналыг хялбаршуулж автоматжуулснаар далд эдийн засаг хумигдаж, ил тод байдал нэмэгдсэнээр төсвийн орлого төвлөрөлт сайжирсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага 2021-2025 онд жилд дунджаар 18.1 хувиар өсөж, 2025 онд 31.3 их наяд төгрөг буюу ДНБ-ий 34.8 хувьд хүрсэн байна. Сүүлийн 5 жилийн төсвийг зарлагын бүтцээр авч үзвэл урсгал зардал 2021 онд өмнөх оны мөн үеэс 18.2 хувиар өсөж ДНБ-ий 29.4 хувьд хүрсэн бол 2022 онд хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр өсөлтийн хурд саарч 11.1 хувиар өсөж ДНБ-ий 26.4 хувьд хүрсэн. Урсгал зардлын өсөлт 2023 онд эрчимжиж, өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар өсөж ДНБ-ий 27.5 хувь, 2024 онд өмнөх оны мөн үеэс 29.8 хувиар өсөж ДНБ-ий 26.6 хувьд хүрсэн байна. Төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн, тэтгэврийн итгэлцүүрийг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор 2025 оны төсвийн урсгал зардал өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өсөж ДНБ-ий 26.9 хувьд хүрсэн. Хөрөнгийн зардлын хувьд цар тахлын нөлөөтэй зогсонги байдал сэргэж 2021 онд өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар буурч ДНБ-ий 6.8 хувьд хүрсэн бол 2022 онд 27.5 хувь өсөж ДНБ-ий 7.1 хувь, 2023 онд 36.4 хувь өсөж ДНБ-ий 7.4 хувь, 2024 онд 53.6 хувиар өсөж ДНБ-ий 9.9 хувьд тус тус хүрсэн. Гэсэн хэдий ч 2025 оны төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын зардлыг 458.7 тэрбум төгрөгөөр бууруулж


¹¹ ОУВС-ийн Төрийн санхүүгийн 2006-2023 оны статистикт төсвийн орлого, ДНБ-ий харьцаа 151 орны дундаж үзүүлэлтээр 28.3-30.3 хувь, төсвийн зарлага, ДНБ-ий харьцаа 28.9-34.8 хувь,

төсвийн тэнцэл, ДНБ-ий харьцаа 0-4.4 хувь байна. <https://www.imf.org/external/datamapper/datasets/FPP>

Зураг 6.5. Нийт орлого (ДНБ-д эзлэх хувь)



Зураг 6.6. Нийт зардал (ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Сангийн яам

баталсан бөгөөд урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ий 7.9 хувьд хүрч буурсан байна.

Төсвийн урсгал зардлын дийлэнх хувийг төрийн албан хаагчийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж болон зээлийн хүүгийн төлбөр зэрэг хуулиар зохицуулагддаг, өсөн нэмэгдэх зардлууд бүрдүүлж байна. Цар тахлын дараах үед хэрэгжсэн эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх хөтөлбөртэй холбоотойгоор халамж, тэтгэмжийн зардлууд нэмэгдсэнээр урсгал шилжүүлгийн зардал 2021 онд 46.1 хувиар, 2022 онд 33.4 хувиар тус тус өссөн байна. Мөн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2022 оноос үргэлжлүүлэн сард зуун мянган төгрөгөөр олгох шийдвэр гарч, засгийн газрын дотоод шилжүүлгийн зардалд тусган санхүүжүүлэх болсон нь тус зардлыг 5.2 дахин өсөхөд нөлөөлсөн. Цалингийн суурь итгэлцүүрийг шинэчилж, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан 2023 онд нэмэгдүүлснээр цалин хөлсний зардал 2023 онд 1.4 дахин, 2024 онд 2.3 дахин, 2025 онд 1.2 дахин, тэтгэвэр, тэтгэмжийн зардал 2023 онд 1.2 дахин, 2024 онд 1.3, 2025 онд 1.2 дахин тус тус нэмэгдэж урсгал зардлын өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор хөдөөгийн сум, тосгонд ажиллаж байгаа төрийн албан хаагчдад 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн

алслагдсан дүүрэгт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад 20 хувиар орон нутагт ажилласны нэмэгдэл олгох шийдвэр гаргаснаар тус онд цалингийн зардал өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна.

Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2023 онд 785.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.1 хувийн ашигтай байсан бол 2021 онд 2.9 их наяд буюу ДНБ-ий 6.7 хувийн, 2022 онд 1.0 их наяд буюу ДНБ-ий 1.9 хувийн, 2024 онд 920.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.1 хувийн, 2025 онд 1,231.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.4 хувийн алдагдалтай гарсан байна.

6.5. Гадаад худалдаа

Цар тахал, геополитикийн нөхцөл байдалтай холбоотойгоор 2021-2022 онд дэлхийн хэмжээнд түүхий эдийн нийлүүлэлт хязгаарлагдаж, тасалдал үүссэнээр нүүрсний үнэ 2 дахин, зэсийн баяжмалын үнэ 77 хувиар, төмрийн хүдэр болон газрын тосны үнэ 70 орчим хувиар тус тус өсөв. Үүний нөлөөгөөр Монгол Улсын нийт экспортын орлого 22-35 хувийн өсөлттэй гарав.

Мөн импортын хэмжээ 2021-2022 онд огцом өссөн байна. 2021 онд импорт 29 хувиар, 2022 онд 27 хувиар тус тус нэмэгдсэн бөгөөд өсөлтөд импортын бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт голлон нөлөөлжээ. БНХАУ-ын хил хаагдсан, мөн ОХУ-Украины дайнтай холбоотойгоор бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт удааширч, тээврийн зардал нэмэгдсэн нь импортын үнийн өсөлтийн үндсэн шалтгаан болов. Үүний үр дүнд дизель түлш, гурил болон хүнсний бүтээгдэхүүний үнэ огцом өсөж, импортын үнийн түвшнийг өсгөхөд гол нөлөө үзүүлэв.

Монгол Улсын гадаад худалдааны урсгал 2022-2024 онд алгуур сэргэж, экспортын бүтэц, тээвэр логистикийн зохион байгуулалт, боомтын хүчин чадал сайжирснаар тогтвортой өсөлттэй үргэлжиллээ. Энэ хугацаанд Монгол Улс дунджаар 160 орчим улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 оноос хойш хоёр дахин нэмэгдэж, 2024 онд 27.4 тэрбум ам.долларт хүрсэн нь сүүлийн таван жилийн хамгийн өндөр үзүүлэлт болов.

2023 оноос түүхий эдийн үнэ буурах хандлагатай байсан ч дэлхийн эдийн засгийн сэргэлт болон Засгийн газраас ашигт малтмалын экспорт, тээврийн зохион байгуулалтыг сайжруулах, төрийн өмчит компаниудад онцгой дэглэм тогтоох, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг эхлүүлэх, боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг бодлогын арга хэмжээний үр дүнд нүүрсний экспорт хоёр дахин нэмэгдэж, нийт экспортын орлого 17 орчим хувиар өсөв.

2024 онд хилийн голлох боомтуудын тээврийн зохион байгуулалт сайжирч, ажиллах цагийн хуваарь уртассан нь нүүрсний экспорт 83.8 сая тоннд хүрэхэд нөлөөлсөн. Гэсэн хэдий ч нүүрсний хилийн үнэ 19 хувиар буурснаар экспортын орлогын өсөлт саарсан. Мөн тухайн жил өвөлжилт, хаваржилт хүндэрснээр хөдөө аж ахуйн гаралтай экспортын бүтээгдэхүүний хэмжээ буурч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад махны экспорт 14 хувь, ноолуурын экспорт 11 хувь, арьс ширний экспорт 5 хувиар тус тус буурсан байна.

Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, иргэдийн худалдан авах чадвар сайжирснаар бараа, бүтээгдэхүүний эрэлт өсөж, импортыг өдөөлөө. 2024 онд импорт өмнөх оноос 2.4 тэрбум ам.доллаар нэмэгдсэний 60 орчим хувь нь эдийн засаг, үйлдвэрлэлийг дэмжсэн бараа бүтээгдэхүүн байна.

Гадаад худалдааны 2025 оны гүйцэтгэл

2025 онд байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.2 тэрбум ам.долларт хүрч, 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Экспорт 15.8 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдлаа. Нүүрсний экспорт 90 сая тоннд хүрч, өмнөх оноос 7 хувиар, зэсийн баяжмалын экспорт 1 сая 647 мянган тоннд хүрч, 39 хувиар тус тус өссөн байна.

Импорт 2025 онд 11.3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 303 сая ам.доллаар буюу 2.6 хувиар саарсан байна. Импортын өөрчлөлтийг барааны бүлгээр авч үзвэл нийт бууралтын 1.8 нэгж хувийг хөрөнгө оруулалтын машин механик, тоног төхөөрөмж, 0.6 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 0.1 нэгж хувийг аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна.


2024 онд уул уурхайн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт өндөр байсан суурийн нөлөөгөөр 2025 онд уул уурхайн салбарт ашиглагддаг завсрын болон хөрөнгө оруулалтын барааны импорт саарчээ. Харин уул

уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээний экспорт өссөнтэй холбоотойгоор дизель түлшний импорт 1,337 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 3 орчим хувиар өсөв.


Суудлын автомашин, түүний сэлбэг хэрэгслийн импорт буурсан нь хэрэглээний бүтээгдэхүүний импортыг буурууллаа. Нийслэл хотод 10-аас дээш жилийн насжилттай суудлын автомашинд тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгохгүй гэж шийдвэрлэсэнтэй холбоотойгоор суудлын автомашины импорт өмнөх оноос 6 орчим хувиар буурсан байна.

Суудлын автомашины импортыг даган автобензиний импорт 602 сая ам.долларт хүрч, мөн 6 хувиар буурав. Харин хүнс, эм тариа зэрэг өрхийн зайлшгүй хэрэгцээт бүтээгдэхүүний импорт харьцангуй тогтвортой хадгалагдлаа


Зураг 6.7. Экспорт (сая ам.доллар)




Зураг 6.8. Импорт (сая ам.доллар)



Зураг 6.9. Экспортын бүтэц (хувь)



Зураг 6.10. Импортын бүтэц (хувь)



6.6. Төлбөрийн тэнцэл

2021-2025 оны хооронд дэлхий нийтийг хамарсан цар тахал болон геополитикийн хурцадмал байдал дэлхийн үнийн өсөлтийг эрчимжүүлж, манай улсын импортын зардал нэмэгдэхэд нөлөөлөв.

Төлбөрийн тэнцлийн алдагдал 2021 онд 222 сая ам.доллар болж буурсан ба санхүүгийн дансны ашиг өндөр байсан нь голлон нөлөөлсөн. Засгийн газар 2021 онд Мазаалай бондын үлдэгдэл үндсэн төлбөрийг төлсөн, МИК 250 сая ам.долларын бонд гаргаж, өмнөх бондын 197 сая ам.долларын үндсэн төлбөрийг төлсөн зэрэг санхүүгийн дансны хөдөлгөөнд голлон нөлөөлөв.

Экспортын орлогын өсөлт 2022 онд өндөр байж урсгал дансны алдагдал буурсан ч банкнуудын болон хувийн секторын гадагш чиглэсэн урсгал нэмэгдсэнээр төлбөрийн тэнцлийн алдагдал дахин өссөн байна. 2022 онд Монгол Улсын төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж, томоохон орнууд бодлогын хүүгээ нэмэгдүүлж байсан нь манай улсын гадаад зах зээлээс хөрөнгө босгох өртгийг нэмэгдүүлэн, шинээр хөрөнгө оруулалт татах урсгалыг бууруулах сөрөг үр дагавар үүсгэв.

Засгийн газраас 2023 онд экспорт болон гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн цогц арга хэмжээний үр дүнд

экспорт түүхэн дээд түвшинд хүрсэн. Тухайлбал, ашигт малтмалын тээвэрлэлт, экспортын үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд онцгой дэглэм тогтоох, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Мөн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал байгуулж, автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл ашиглалтад нэвтрүүлснээр экспортын тээвэрлэлтийн үр ашиг мэдэгдэхүйц сайжирсан. Үр дүнд нь 2023 онд гадаад худалдааны тэнцэл 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарав. Ингэснээр урсгал дансны тэнцэл 2007 оноос хойш анх удаа ашигтай гарч, гадаад валютын улсын нөөц түүхэн дээд түвшинд хүрсэн байна.


Эдийн засгийн идэвхжил 2024 онд нэмэгдэж, хөрөнгө оруулалт болон хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импорт өссөний нөлөөгөөр урсгал дансны тэнцэл 2.2 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан боловч гадаад зах зээлд гаргасан шинэ бондуудын орох урсгал нэмэгдсэнээр санхүүгийн дансны ашиг 3.2 тэрбум ам.доллароор өсөж, төлбөрийн тэнцэл 0.6 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Зураг 6.11. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)



Эх сурвалж: Монгол банк

Зураг 6.12. Гадаад валютын албан нөөц, ам.долларын ханш (сая ам.доллар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

7. Эдийн засгийн түүхэн хураангуй (2006-2020)

7.1. Эдийн засгийн өсөлт

Монгол Улсын 2006-2020 он¹² хүртэлх нийт үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлтийн талаарх хураангуй дүгнэлт.

2006-2010 он

Эдийн засгийн дундаж өсөлт 2006-2010 онд 6.6 хувьд байж, өмнөх таван жилийн дунджийн орчимд хадгалагдав. Нэрлэсэн ДНБ 2010 оны байдлаар 9.8 их наяд төгрөгт хүрч 2006 оны түвшнээс 2.4 дахин, нэг хүнд ногдох орлого 2.7 мянган ам.долларт хүрч 2 дахин тус тус тэлэв. Монгол Улсын эдийн засгийн үйл ажиллагааг 2006-2008 онд байгаль, цаг уурын тааламжтай байдал, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлт, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчлэл (2006), Атрын III аянууд голлон тэтгэж байв. Харин 2009 онд дэлхийн санхүүгийн хямралын нөлөөгөөр гадаадын хөрөнгө оруулалт буурч, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ унаснаар Монгол Улсын экспортын орлого буурч, төсвийн орлого тасарч, төсвийн зарлага хумигдаж, эдийн засаг 2009 онд 1.3 хувиар агшсан. Эдийн засгийн дотоод идэвх суларч, бизнес эрхлэгчдийн борлуулалт удааширч, төгрөгийн ханш суларсан зэрэг шалтгаанаас үүдэн зээлийн эрсдэл өсөж, чанаргүй зээл нэмэгдсэн. Мөн гаднын байгууллагууд манай улсын банк, санхүүгийн байгууллага, компаниудад өгсөн зээлээ эргүүлэн татаж, төлөвлөсөн хөрөнгө оруулалтын хугацаагаа хойшлуулсан зэрэг шалтгаанаас Анод банк ХК, Зоос банк ХК-ын төлбөрийн чадвар муудаж, татан буугдсан¹³ байна. Харин эдийн засгийг тогтворжуулах зорилгоор ОУВС-ийн “Стэнд-бай” хөтөлбөр¹⁴ -т хамрагдсанаар хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэхэд эергээр

нөлөөлөв. Дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнэ 2009 оны 2 дугаар улирлаас эхлэн хурдацтай өсөж, уул уурхайн салбарт орж ирэх хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдэв. Түүнчлэн 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ хийгдэж, Оюутолгой төслийн эхний шатны хөрөнгө оруулалт 2010 оноос орж эхэлснээр эдийн засаг 2010 онд 6.4 хувиар өсөж, хямралт нөхцөл байдлыг амжилттай даван гарсан.

Уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх дундаж хувь хэмжээ 2006-2010 онд нүүрс олборлолтын эрчимжилтийн нөлөөгөөр 22.4 хувьд хүрч, өмнөх таван жилийн дунджаас 8.8 нэгж хувиар тэлэв. Тухайлбал, нүүрс олборлолтын хэмжээ 2006 онд 8.1 сая тонн байсан бол 2010 онд 25.2 сая тоннд хүрч 3.1 дахин өссөн байна. Үүнд, Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол болон Засгийн газрын 272 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах зорилго бүхий “Эрдэнэс Тавантолгой” төрийн өмчит хувьцаат компани байгуулагдсан нь томоохон нөлөө үзүүлэв. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар нүүрс олборлолт эрчимжиж, салбарын өсөлтийг дэмжсэн байна. Ингэснээр уул уурхайн салбар нь алт олборлолтоос нүүрс олборлолтын үйл ажиллагаанд шилжих эхлэл тавигдав. Харин дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнэ өндөр түвшинд хадгалагдсан хэдий ч алт олборлолтын хэмжээ буурах хандлагатай байсан. Тухайлбал, 2006 онд 22.6 тонн алт олборлож байсан бол 2010 онд 6.0 тонн болж, 3.8 дахин буурсан байна.

ДНБ-д эзлэх хувь хэмжээгээр уул уурхайн салбарын дараа орох хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааны идэвх цаг агаарын таатай

¹² 2006-2010 он, 2011-2015 он, 2016-2020 он

¹³ Эх сурвалж: “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2019, Монгол банк

¹⁴ Монгол Улсын Засгийн газар 2009 оны 04 дүгээр сард ОУВС-ийн Стэнд-бай хөтөлбөрийн 18 сарын хугацаатай, жилийн ЗТЭ% + 1% хүүтэй, 229.2 сая ам.долларын зээл авсан.

нөхцөл байдал, Атрын гурав дахь аян (2008)-ы нөлөөгөөр 2006-2008 оны хооронд нэмэгдэх хандлагатай байв. Монгол Улсын Засгийн газрын “Хөтөлбөр батлах тухай (Атрын гурав дахь аян)” 2008 оны 70 дугаар тогтоол хэрэгжсэнээр үр тариа тариалсан талбайн хэмжээг өмнөх онтой харьцуулахад 2008 онд 154 мянган га талбайд хүрч, 1.3 дахин, 2009 онд 252 мянган га талбайд хүрч, 1.6 дахин, 2010 онд 259 мянган га талбайд хүрч 1.0 дахин тус тус өссөн байна. Мөн цаг агаарын таатай байдлын нөлөөгөөр 2006-2009 оны хооронд бойжсон төлийн тоо жил бүр 10 сая толгой давснаар нийт малын тоо толгой 2009 онд 44 сая толгойд хүрч 2006 оны түвшнээс 1.3 дахин нэмэгдсэн байна. Харин 2009-2010 оны зудын нөхцөл байдлаас үүдэн салбарын үйлдвэрлэл огцом агшиж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2010 онд 16.6 хувиар буурсан. Тухайлбал, 2009-2010 оны зудын хүндрэлээр том малын зүй бус хорогдол 10.3 сая толгойд хүрч, нийт малын тоо толгой 2010 онд 32 сая толгой болж 2005-2006 оны түвшинд хүрч буурсан байна.

Дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөгөөр 2009 онд агшсан эдийн засгийг сэргээх, тогтворжуулах зорилгоор ОУВС-ийн “Стэнд-бай” хөтөлбөрт хамрагдсан. Тус хөтөлбөрийн хүрээнд төсвийн сахилга батыг сайжруулж, банкны системийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготой Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 оны 06 дугаар сард батлагдаж, эдийн засгийн сахилга сайжрах үндэс суурь тавигдсан байна.

Эрэлт талаас авч үзвэл 2006 оны дунд үеэс 2008 оны эхний хагас хүртэл дэлхийн зах зээлд зэсийн үнэ өндөр түвшинд хадгалагдсанаар экспортын орлого нэмэгдэж, түүнийг даган төсвийн орлого тэлснээр төрөөс цалин, тэтгэврийг нэмэх бодлого хэрэгжүүлсэн. Тухайлбал, төрийн албан хаагчдын 2008 оны дундаж цалин 2004 оноос 3.1 дахин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 2.8 дахин өссөн байна. Цалингийн өсөлт нь өрхийн бодит орлогыг дэмжсэнээр өрхийн бодит орлого 2006 онд 11.0 хувиар, 2007 онд 17.4 хувиар тус тус өсөв. Өрхийн бодит орлого нэмэгдсэнээр 2005-2006 онд эдийн засгийн өсөлтөд сааруулагч хүчин зүйл болж байсан өрхийн хэрэглээ 2007 онд 21.9 хувиар, 2008 онд 14.7 хувиар тэлж, нийт өсөлтөд голлох хувь нэмэр оруулав. Нэгдсэн төсвийн орлогын өсөлтийг даган төрийн секторын хэрэглээ 2006-2008 онд жилд дунджаар 41.5 хувийн нэрлэсэн өсөлт үзүүлэв.


Харин 2008 оноос эхэлсэн дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үед төгрөгийн ханш суларснаар импортын гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ өсөж, инфляц нэмэгдэв. Инфляцын өсөлт иргэдийн худалдан авах чадварыг бууруулж, бодит орлого 2008 онд 0.6 хувиар буурсан. Өрхийн орлого муудсанаар өрхийн хэрэглээ 2009 онд 7 хувиар агшсан байна. Түүнчлэн гадаад эрэлт муудаж, цэвэр экспорт 2009 онд 35.6 хувиар буурахын зэрэгцээ төрийн хэрэглээ 11.5 хувиар хумигдсан. Улмаар эдийн засаг дотоод эрэлт өсөлтийг 5.8 нэгж хувиар бууруулах нөлөөг үзүүлсэн байна.

Зураг 7.1. ДНБ-ий дундаж өсөлт, салбаруудаар (хувь)

Салбар	2006-2010	2011-2015	2016-2020	2021-2025
ДНБ	6.6	10.3	3.2	5.2
ХАА	2.5	12.9	4.5	0.4
Уул уурхай	2.8	13.6	(2.3)	6.1
Боловсруулах	7.9	6.8	7.2	3.2
Цахилгаан	4.8	5.6	5.6	6.9
Барилга	(4.0)	22.3	3.4	3.7
Худалдаа	12.5	12.3	1.3	6.0
Тээвэр	14.1	8.3	1.7	12.5
Мэдээлэл холбоо	13.6	7.8	5.2	13.8
Бусад	65.0	27.2	25.8	6.1
Цэвэр татвар	14.7	10.2	9.3	9.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 7.2. ДНБ-ий өсөлтийн бүтэц, эрэлт талаас, (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2011-2015 он

Эдийн засгийн 2011-2015 оны жилийн дундаж өсөлт 10.3 хувьд хүрч, дундаж өсөлтөөр хамгийн өндөр таван жил байв. Нэрлэсэн ДНБ 2015 оны байдлаар 22.9 их наяд төгрөгт хүрч 2010 оноос 2.4 дахин, нэг хүнд ногдох ДНБ 3.9 мянган ам.долларт хүрч 1.4 дахин тэлэв.

Цаг уурын нөхцөл таатай байснаар хөдөө аж ахуйн салбар тогтвортой өсөж, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өндөр хэвээр байсан, Оюу толгойн хөрөнгө оруулалтаас гадна, уул уурхайн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэх хэмжээ нэмэгдсэн нь эдийн засгийн үйл ажиллагааг 2011-2012 онуудад голлон тэтгэв. Мөн 2011 оноос эхлэн Хятадын зах зээл рүү гаргасан нүүрсний экспортын орлого огцом өсөж, "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, томоохон бондуудын санхүүжилтийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийснээр эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэв.

Уул уурхайн салбарт төвлөрсөн ГШХО-аас үүдэн хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийг тэтгэлээ. Уул уурхайн

салбарын 2011-2015 оны жилийн дундаж өсөлт 13.6 хувьд хүрч, эдийн засгийн өсөлтийг жилд дунджаар 2.8 нэгж хувиар дэмжив. Уул уурхайн салбарын өсөлтийг нүүрс, төмрийн хүдэр, зэс олборлолт, газрын тосны биет хэмжээ нэмэгдсэн нь голлон дэмжив. Тухайлбал нүүрс олборлолтын хэмжээ 2006-2010 онуудад жилд дунджаар 13.4 сая тонн байсан бол 2011-2015 онуудад 28.3 сая тонн болж 2.1 дахин нэмэгдэв. Мөн Оюу толгой ХХК 2012 онд үйл ажиллагаагаа эхлүүлж, үйлдвэрлэлээ эхлүүлснээр зэсийн баяжмал олборлолт 2006-2010 онуудад жилд дунджаар 532 мянган тонн байсан бол 2011-2015 онуудад 850 мянган тонн болж 1.6 дахин нэмэгдсэн байна.

Харин 2012 оны сүүл буюу түүхий эдийн супер циклийн төгсгөлөөс эхлэн ГШХО-н хэмжээ буурч, төсвийн орлого багасан, 2011 онд 17.3 хувиар өсөж байсан эдийн засгийн өсөлт 2015 онд 2.4 хувь болж буурав. Мөн энэ үеэр хэрэгжүүлсэн ашигт малтмалын лиценз олголтыг түр зогсоосон шийдвэрийг байсан шийдвэрийг тодорхойгүй хугацаагаар хоёр ч удаа сунгаж 2014 оны долоо дугаар сард Ашигт малтмалын хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт хүртэл хэрэгжсэнээр хайгуулын ажил ахиж шинээр эхлүүлэх боломжгүй болсон нь гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах шалтгаануудын нэг болов.

Уул уурхайн бус салбарын 2011-2015 оны жилийн дундаж өсөлт 9.4 хувь болж, эдийн засгийн өсөлтийг жилд дунджаар 7.5 нэгж хувиар дэмжив. Уул уурхайн салбарын үйл ажиллагааны тэлэлтийг даган худалдаа, үйлчилгээ, тээвэр, нэн ялангуяа барилгын салбар эдгээр жилүүдэд өндөр өсөлттэй байв. Тухайлбал, экспортын гол нэрийн бүтээгдэхүүний биет хэмжээний өсөлтийн нөлөөгөөр экспортын тээврийн потенциалыг нэмэгдүүлэх чиглэлд төсвийн хөрөнгө оруулалт огцом нэмэгдэж зам, гүүр барилгын ажил ихээр хийгдэв. Ингэхдээ 2012-2014 онуудад гадаад зах зээлээс дунд/урт хугацааны санхүүжилт татан дэд бүтэц, аж үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр, хөдөө аж ахуйн төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор Чингис (1.5 тэрбум ам. доллар), Евро (500 сая ам. доллар), Самурай (600 сая ам. доллар), Дим Сам (~161 сая ам. доллар) бондуудыг гаргасан. Тус бондуудын санхүүжилтээр “Шинэ төмөр зам” төсөл, “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”, “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор”, өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгөөр барих авто замууд, эрчим хүчний барилга байгууламжийн жагсаалтад орсон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн байна.

Зам тээвэр, худалдааны салбарын хувьд уул уурхайн хүнд даацын машин, тоног төхөөрөмжийн импортын өсөлтийг даган авто тээврийн хэрэгслийн шатахуун, тоног төхөөрөмжийн түлшний хэрэглээ нэмэгдсэн, үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд салбарын үйл ажиллагаа тэлж, эдийн засгийн өсөлтийг тэтгэв.

Монголбанкнаас ийнхүү төсвийн шинжтэй үйл ажиллагааг ¹⁵ 2012-2016 онд санхүүжүүлж, зээлээр гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлж байсан нь төв банкны хуримтлагдсан

алдагдлын хэмжээг 3 их наяд төгрөг хүртэл өсгөжээ¹⁶. Тухайлбал, 2013 оноос эхлэн Засгийн газар, Төв банкнаас хэрэгжүүлсэн “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд:

- “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг баталж үүний дэд хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас ипотекийн зээл олгох зорилгоор, хөтөлбөрт оролцогч арилжааны банкнуудад жилийн 4%-ийн хүүтэй богино хугацаат санхүүжилтийг олгосон.
- Мөн хөтөлбөрийн хүрээнд шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрөөр 195 тэрбум төгрөгийн шатахуун импортлогчдод жилийн 3.8 хувийн хүүтэйгээр зээл олгосон.
- Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар төмөр замын шатахууны эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэхээр жилийн 3.8 хувийн хүүтэй гурван жилийн хугацаатай 22 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.
- Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах хүрээнд 87 тэрбум төгрөг, гурилын үнийг тогтворжуулах хүрээнд нийт 61 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Мөн орон сууцны үнийг тогтворжуулах хүрээнд барилгын салбарт 400 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Ингэхдээ гэрээ байгуулсан цементийн бизнес эрхлэгч 43 аж ахуйн нэгжид 48.5 тэрбум, арматурын 17 аж ахуйн нэгжид 81 тэрбум, барилгын материал үйлдвэрлэгч 64 компанид 146.7 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгожээ.

¹⁵ Эх сурвалж: “Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилгод чиглэсэн бодлогын голлох зөвлөмжүүд”, 2024, Дэлхийн банк

¹⁶ Эх сурвалж: “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2019, Монгол банк

Мөн байгаль, цаг уурын таатай байдлын нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар тогтвортой өсөж, малын тоо толгой 50 сая хүртэл нэмэгдэн салбарын өсөлтийг тэтгэв. Гэсэн хэдий ч Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 300 дугаар тогтоолоор баталсан "Арьс, ширний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт" нь Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулж

Зураг 7.3. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орон урсгал (тэрбум, ам.доллар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

гадаад оронд худалдаалахаар гаргаж байгаа бүх төрлийн арьс, ширд боловсруулалт хийхийг шаардах болсон. Үүнээс үүдэн боловсруулаагүй арьс, ширнээс олдог байсан экспортын орлого 2013 онд 4 сая ам. доллароос 2015 онд 1.8 сая ам. доллар болж 2.2 дахин буурав. Үүнээс үүдэн малчдын орлого буурч, арьс ширний үнэ огцом буурсан байна.

Эрэлт талаас авч үзвэл 2011-2012 онд төсвийн тэлэх бодлого үргэлжилж, цалин, тэтгэвэр тэтгэмжийг өсгөсөн ба нэрлэсэн дундаж цалин 13.6-31.4 хувиар, төрийн хэрэглээ 12.5-33.3 хувиар өсөж, дотоод эрэлт тэлсэн нь инфляц 15-20 хувийн өндөр түвшинд хадгалагдахад нөлөөтэй байв. Инфляц өндөр түвшинд хадгалагдаж байсан ч цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт өрхийн бодит орлогыг дэмжиж, өрхийн бодит орлого 2011 онд 17.7 хувиар, 2012 онд 25.5 хувиар тус тус сайжирч, эдийн засгийн

үйл ажиллагааг дэмжиж байв. Тухайлбал, өрхийн хэрэглээ 2011 онд 20.2 хувиар, 2012 онд 18.4 хувиар хурдацтай тэлж, эдийн засгийн өсөлт 2011 онд 17.5 хувиар (түүхэн дээд түвшин), 2012 онд 12.5 хувиар, 2013 онд 11.6 хувиар тус тус өсөж, эдийн засаг халалттай байв.

Эдийн засгийн өсөлтөд оруулах хөрөнгө оруулалтын хувь хэмжээ 2010 онд 19.9 нэгж хувь, 2011 онд 7.5 нэгж хувь, 2012 онд 4.1 нэгж хувь тус тус байв. Үндсэн хөрөнгийн хуримтлалыг машин, тоног төхөөрөмжийн импортын өсөлт, ипотекийн зээлийг олголтын нөлөөгөөр идэвхэжсэн орон сууцны барилгын бүтээн байгуулалт дэмжсэн байна. Харин экспортын гол нэрийн бүтээгдэхүүний биет хэмжээ нэмэгдсэн ч дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн бууралтын нөлөөгөөр цэвэр экспорт 2010 онд нийт өсөлтийг 13.3 нэгж хувиар, 2011 онд 4.4 нэгж хувиар, 2012 онд 2.9 нэгж хувиар тус тус бууруулж байв.

Харин 2014 оноос гадаадын шууд хөрөнгө оруулалт үндсэндээ зогсож, гадаад орчны сөрөг хүчин зүйлсийн голлох нөлөөгөөр бодит ДНБ-ий өсөлт удааширч эхлэв. Түүнчлэн, инфляц тогтмол хоёр оронтой тоонд хадгалагдаж байсан нь 2014 онд өрхийн бодит орлогыг 0.3 хувиар бууруулж, эдийн засаг дахь нийт хэрэглээний өсөлтийг хязгаарлах нөлөө үзүүлэв. Мөн 2013 оноос эрчимтэй олгож эхэлсэн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн нөлөөгөөр өрхүүд орлогынхоо тодорхой хэсгийг зээлийн эргэн төлөлтөд зарцуулж, өрхийн хэрэглээ буурснаар эдийн засгийн эрэлтийг сааруулав.


2016-2020 он

Монгол Улсын эдийн засгийн 2016-2020 оны жилийн дундаж өсөлт 3.2 хувь болж, эдийн засгийн үйл ажиллагааны эрчим саарав. Нэрлэсэн ДНБ 2020 оны байдлаар 37.5 их наяд төгрөгт хүрч 2015 оноос 1.6 дахин, нэг хүнд ногдох ДНБ 4.1 мянган ам.долларт хүрч 1.0 дахин өсөв.

Олон улсын валютын сангийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд эдийн засгийг богино хугацаанд тогтворжуулж, цаашид тогтвортой өсөх суурийг тавих чиглэлд 2017-2020 онд баримтлах макро эдийн засгийн цогц бодлогыг тодорхойлон хэрэгжүүлсний үр дүнд макро эдийн засгийн орчин харьцангуй тогтворжиж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж эдийн засгийн өсөлтийг дэмжив. Оюутолгойн зэсийн баяжмал дахь металлын агууламжийн нөлөө багасаж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл буурсан ч, төгрөгийн ханш харьцангуй тогтвортой хадгалагдаж уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ.

Уул уурхайн салбарын 2016-2020 оны жилийн дундаж өсөлт -2.3 хувь болж, эдийн засгийн өсөлтийг жилд дунджаар 0.4 нэгж хувиар бууруулав. Үүнд, Оюу толгойн зэсийн баяжмал дахь металлын агууламжийн бууралт болон Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад орсон олон удаагийн өөрчлөлт нь хөрөнгө оруулалтын орчны тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, улмаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан нь голлон нөлөөлөв.

Зураг 7.4. Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт (тоо)




Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

Уул уурхайн бус салбарын 2006-2010 оны жилийн дундаж өсөлт 4.3 хувь болж, эдийн засгийн өсөлтийг жилд дунджаар 3.6 нэгж хувиар дэмжив. Тухайлбал, байгаль цаг уур нөхцөл таатай байснаар хөдөө аж ахуйн салбарын

үйлдвэрлэл тогтвортой хадгалагдав. Экспортын тээвэр, импорт нэмэгдэж, транзит тээврийн хэлцлүүд эргэн сэргэснээр тээврийн салбарын үйлдвэрлэл нэмэгдэв. Боловсруулах салбарт жилд тус тус 1 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай Монцемент ХХК, МАК Евро Цемент ХХК ашиглалтад орсноор төмөрлөг бус төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэж, боловсруулах салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн байна.

Эрэлт талаас авч үзвэл төсвийн орлого 2015 онд 4.7 хувиар, 2016 онд 2.4 хувиар буурснаар төрийн хэрэглээний өсөлт саарч 2015 онд 2.3 хувь болов. Эдийн засгийн дотоод идэвхжил муудаж, өрхийн хэрэглээ дөнгөж 1-2 хувиар өсөн, эдийн засаг 2015 онд ердөө 2.5 хувиар, 2016 онд 1.5 хувиар өсөж байжээ. Ингээд 2016 оноос түүхийн эдийн үнэ (голлон нүүрс) өссөнөөр экспорт нэмэгдсэний зэрэгцээ 2017 оноос Олон улсын валютын сангийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдан төсвийн

Зураг 7.5. Түүхий эдийн үнийн индекс ба эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

зардлыг бууруулах, хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэн эдийн засгийн дотоод орчин тогтворжив.

Мөн хөрөнгийн хуримтлал 2017 онд 31.6 хувиар, 2018 онд 52.1 хувиар өссөн нь эдийн засгийн сэргэлтэд түлхэц үзүүлж эхэлсэн. Үүнд түүхий

эдийн үнэ, экспортын эрэлт өндөр байсны нөлөөгөөр уул уурхайн салбар 2018 онд 5.4 хувиар өсөж, боловсруулах болон барилгын салбарууд 2018, 2019 онд сайн байсны нөлөөгөөр машин, тоног төхөөрөмж, барилгын материал болон нефтийн бүтээгдэхүүний худалдан авалт эрчимжсэн нь нөлөөлж байв.

Түүнчлэн 2012 оноос хойш өсөөгүй төсөвт байгууллагад ажиллагсдын цалинг 2018 оны 4 дүгээр улирал, 2019 оны 1 дүгээр сард тус бүр 8 хувиар шат дараатай нэмэгдүүлснээр 2019 онд төрийн албан хаагчдын бодит цалин 10 хувиар өсөж, өрхийн хэрэглээ 2018 онд 9.6 хувиар, 2019 онд 7.0 хувиар өсөв. Үүний зэрэгцээ худалдааны салбар 2019 онд 10.9 хувиар өсөж байв. Харин хэрэглээ, хөрөнгө оруулалтыг даган бараа, үйлчилгээний импорт 2018 онд 32.7 хувиар нэмэгдсэн нь өсөлтийг бууруулж байв.

Харин 2020 онд цар тахлын нөхцөл байдал үүсэж, эдийн засагт гадаад болон дотоод тодорхой бус байдал нэмэгдэв. Цар тахал, түүнтэй холбоотой хориг арга хэмжээнүүдийн нөлөө болон гадаад орчны тогтворгүй нөлөө, түүхийн эдийн үнийн бууралт, хил хаасан зэргээс үүдэн эдийн засаг 4.6 хувиар агшсан. Цар тахлыг цааш тархахаас сэргийлэн удаа дараа хөл хорио тогтоосноор үйлдвэрлэл, үйлчилгээ худалдааны салбар огцом агшиж, хэрэглээ хумигдаж байв.


7.2. Инфляц

2006-2010 он

2006-2010 онд инфляц улсын хэмжээнд дунджаар 12.2 хувь гарсан нь өмнөх таван жилийн дунджаас 5.5 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм. Энэ хугацаанд шатахууны үнийн өсөлт, улирлын шинжтэй хүнсний барааны хомсдол, болон цалин, халамжийн өсөлт, төгрөгийн ханшийн сулрал зэрэг хүчин зүйлс инфляцад голлон нөлөөлжээ. 2006 онд махны үнэ ихээр хэлбэлзсэн, зохиомол үнийн хөөргөдөл үүссэн болон шатахууны үнэ өссөн нь инфляцад голлох нөлөөтэй байв. 2007 онд

дэлхийн зах зээл дээр улаан буудай, нефть, гурил, цагаан будаа зэрэг гол нэрийн бүтээгдэхүүний үнэ өссөн, мөн худалдааны түнш орнуудын инфляц нэмэгдсэн зэрэг нийлүүлэлтийн хүчин

Зураг 7.6. Инфляцын түвшин (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

зүйлс инфляцын өсөлтөд нөлөөлсөн байна. Үүний зэрэгцээ төрийн албан хаагчдын цалин, халамжийн зардлын өсөлт, төгрөгийн ханшийн сулралын нөлөөгөөр эрэлт талаас инфляц өдөөгдөж 15.1 хувь хүртэл өсөв. 2007 оноос Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд мөнгөний бодлогын хүүг ашиглаж эхэлсэн бөгөөд инфляцын зорилтот түвшнийг нэвтрүүлж, зорилтод чиглэсэн бодлогын тохируулгыг хэрэгжүүлэх эхлэл тавигджээ. 2008 онд шатахууны үнэ оны туршид хэлбэлзэж, дундаж үнэ өмнөх онтой харьцуулахад 45.1 хувиар, цалин 30 гаруй хувиар өссөн зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц 22.1 хувь хүртэл өсөв. Харин 2009 онд дэлхийн санхүүгийн хямралын нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил саарч, өрхийн хэрэглээ хумигдан, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарснаар инфляц 4.2 хувь хүртэл саарч, зарим саруудад инфляцгүй байв. 2010 онд Монгол Улс Олон Улсын Валютын Сантай хамтран “Стэнд-бай” хөтөлбөрийг хэрэгжүүлж, мөнгөний бодлогын төлөв чангарснаар инфляц саарсан. Гэсэн хэдий ч 2009-2010 оны өвөл тохиосон цагаан зудын улмаас 9.7 сая мал хорогдож, махны нийлүүлэлт эрс бууран, махны үнэ улирлын хандлагаасаа

өндөрөөр өссөнөөр инфляц эргэн эрчимжсэн байна. Тухайлбал, инфляц 2010 оны эцэст 13 хувь байсны 5.9 нэгж хувийг мах дангаар бүрдүүлж байжээ.

2011-2015 он

2011-2015 онд Монгол Улсын хэмжээнд инфляц дунджаар 10.7 хувь байсан бөгөөд, гадаад зах зээл болон дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр ихэнх үеүдэд зорилтот түвшнээс өндөр, хэлбэлзэл ихтэй байв. 2011 онд Хүний хөгжил сангийн мөнгөн тэтгэмж, төсвийн өндөр зардал, уул уурхайн хөрөнгө оруулалтын идэвхжил зэргээс эрэлтийн гаралтай инфляц идэвхжиж, шүлхий өвчин болон улирлын хандлагаас үүдэлтэйгээр махны үнэ өссөнөөр инфляц 2 оронтой тоонд хадгалагдсан байна. 2012 онд инфляц мах, хүнсний ногооны үнийн хэлбэлзэл, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалан 17.8 хувь хүртэл өссөн бол сүүлийн хагас жилд алгуур буурчээ. 2012 онд Монголбанк болон Засгийн газар хооронд “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулж, үнэ тогтворжуулах хөтөлбөрийн эхлэл тавигдсан. Мөн уг санамж бичгийн хүрээнд шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр буюу “SIFS хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжүүлсэн байна. 2013 онд төгрөгийн ханш суларч, гадаад валютын урсгал буурснаар импортын инфляц өсөж, инфляц төв банкны зорилтоос давсан байна. Улмаар Монголбанк мөнгөний бодлогын тохируулгуудыг үе шаттай хийж, Засгийн газартай хамтран “Гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлснээр хүнсний инфляц тогтворжиж эхэлсэн. Уг хөтөлбөр нь мах, гурил, шатахуун, барилгын материал зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой хангаж, улирлын шинжтэй үнийн хэлбэлзлийг бууруулах, нийлүүлэлтийн гаралтай


инфляцын дарамтыг бууруулахад чиглэжээ. 2014 онд төрийн зохицуулалттай зарим үйлчилгээний үнэ өсөхийн зэрэгцээ төсвийн зардлын тэлэлт, ханшийн сулралын нөлөөгөөр инфляц 2 оронтой тоонд хадгалагдсан байна. 2014 оны эцэст төв банкнаас бодлогын хүүг 13 хувьд хүргэж нэмэгдүүлэн мөнгөний хатуу бодлого баримтлав. 2015 онд бодлогын хүү өндөр хэвээр хадгалагдаж, төгрөгийн ханш тогтвортой байж, махны үнэ 36 хувиар буурч, нийлүүлэлт талаас дарамт буурснаар инфляц 1.9 хувь хүртэл буурч, нам түвшинд хадгалагдсан байна.

2016-2020 он


2016-2020 онд инфляц дунджаар 4.6 хувь байж, өмнөх 5 жилийн дунджаас 6.1 нэгж хувиар буурсан байна. Энэ 5 жилийн хугацаанд инфляцын төлөв байдал эрс өөрчлөгдөж, эдийн засгийн дотоод идэвхжил, төсвийн бодлого, нийлүүлэлт болон гадаад орчны хүчин зүйлсээс үүдэлтэйгээр инфляц өндөр хэлбэлзэлтэй байсан. 2016 онд эдийн засаг агшиж, өрхийн орлого буурсны зэрэгцээ хүнс, махны үнэ тогтвортой байснаар инфляц 1 орчим хувьд хадгалагдаж, зарим саруудад өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ бууралттай буюу дефляцитай байв.

Харин 2017 онд Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжиж эхэлснээр төсвийн сахилга бат болон татваруудад өөрчлөлт оржээ. Мөн эдийн засгийн дотоод идэвхжил нэмэгдэхийн зэрэгцээ улсын хэмжээнд хураасан ургацын хэмжээ буурч, автомашины татвар нэмэгдсэнээр машины үнэ өссөн нь инфляцыг нэмэгдүүлсэн байна. Хэдийгээр инфляц өмнөх оноос эрчимжсэн ч төв банкны зорилтот түвшинд хадгалагджээ. Цаашилбал, 2018 онд эдийн засгийн сэргэлтийн улмаас эрэлтийн инфляц эрчимжихийн зэрэгцээ нийлүүлэлтийн шалтгаантай инфляц өссөн байна. Тухайлбал, хатуу түлш, мах болон шатахууны үнэ огцом өсөж, инфляцын дийлэнх хэсгийн бүрдүүлжээ. 2019 оны эхний хагаст өндөр дотоод

Зураг 7.7. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн)



Зураг 7.8. Ажиллагчид (мян.хүн), ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

эрэлт ба төсвийн зарлагын нөлөөгөөр инфляц өссөн ч хоёрдугаар хагаст эдийн засгийн идэвхжил буурч, үнийн өсөлт саарсан байна. Энэ онд махны үнэ огцом өсөхийн зэрэгцээ цахилгаан, дулаан, ус, сургалтын төлбөр зэрэг төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ нэмэгдсэнээр инфляц өсжээ. Түүнчлэн, 2019 оны 5 дугаар сараас эхлэн төрөөс түүхий нүүрсийг сайжруулсан түлшээр орлуулж, нийлүүлэлт болон үнэд зохицуулалт хийснээр хатуу түлшний үнэ инфляцыг бууруулах нөлөөтэй байв.

Эцэст нь, 2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотойгоор хөл хорио тогтоож, эдийн засгийн дотоод эрэлт хумигдсан. Үүний зэрэгцээ шатахууны үнэ 400-500 төгрөгөөр буурч, сайжруулсан шахмал түлшийг 75 хувиар хямдруулсан нь инфляцыг нам дор түвшинд хадгалан, жилийн эцэст 2.3 хувьд хүргэжээ. Энэ үед төв банк мөнгөний бодлогын хүүг нийт 5 нэгж хувиар бууруулж, мөнгөний бодлогыг төлөвийг зөөлрүүлсэн байна.

7.3. Хөдөлмөр эрхлэлт

2006-2010 он

Хөдөлмөрийн насны хүн ам 2006 онд 1.6 сая байсан бол тус хугацаанд тогтмол өсөж 2010 онд 1.86 саяд хүрсэн байна. Харин дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөгөөр хөдөлмөрийн зах зээл тайлант хугацааны төгсгөлд савлагаатай байсан нь дараах үзүүлэлтүүдээс харагдаж байна: 2006-2008 онд 3 орчим хувьтай байсан ажилгүйдлийн түвшин 2009 онд 11.6 хувь, 2010 онд 9.9 хувьд хүрч огцом өссөн, ажиллах хүчний оролцооны түвшин 2006-2008 онд 63.5-64.4 хувьтай байсан бол 2009 онд 61.4, 2010 онд 61.6 болж буурсан, хөдөлмөр эрхлэлтийн түвшин мөн адил 2006-2008 онд 61.7- 62.4 хувьтай байсан бол 2009 онд 54.3, 2010 онд 55.4 хувьд хүрч буурсан байна.

Ажиллагчдыг салбарын бүтцээр авч үзвэл, 2006-2010 онд хөдөө аж ахуйн салбар дахь ажиллагчдын тоо 391.4 мянгаас 346.6 мянга болж, 45 мянгаар буурсан байна. Харин үйлчилгээний салбарт ажиллагчдын тоо тогтвортой өсөж, 218 мянгаас 296.6 мянгад хүрч нэмэгджээ. Үүнд эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, хотжилт болон үйлчилгээний эрэлт өссөн нь нөлөөлсөн байна. Уул уурхайн салбарын ажиллагчдын тоо 2006-2008 онд өсөж, 46 мянгад хүрсэн боловч хямралын нөлөөгөөр огцом буурч, 2010 онд 34.1

мянга болж буурсан. Мөн барилгын салбарын ажиллагчдын тоо 2008 онд 169 мянгад хүрээд, 2010 онд 146.2 мянга болж буурчээ. Харин боловсрол, эрүүл мэнд, цахилгаан, ус, тээвэр зэрэг салбаруудын ажиллагчдын тоо харьцангуй тогтвортой өсөлттэй байв.

Нөгөө талаас, 2006-2010 онд Монгол Улсад өргөн хүрээтэй халамжийн бодлого хэрэгжсэн нь өрхийн орлогыг богино хугацаанд нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байна. Тухайлбал, “Эх орны хишиг”, “Тавантолгой”-н хувьцааны урьдчилгаа, хүүхдийн мөнгө, оюутны тэтгэлэг, шинээр гэр бүл болсон иргэдэд олгох нэг удаагийн дэмжлэг, ахмад настанд чиглэсэн тэтгэмж зэрэг олон төрлийн бэлэн мөнгөний шилжүүлэг өргөн хүрээнд хэрэгжсэн нь иргэдийн хэрэглээг нэмэгдүүлсэн боловч хөдөлмөрийн идэвхийг бууруулах эрсдэлийг дагуулсан байна.

Энэхүү эрсдэлийг бууруулах зорилгоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр” болон “Ажлын байр нэмэгдүүлэх” төсөл хэрэгжиж, 2007-2010 оны хооронд нийт 160 мянга гаруй иргэн ажлын байранд зуучлагдсан байна. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын цалинг өсгөх бодлого хэрэгжсэн бөгөөд ажил олгогчдын зардлын дарамтыг бууруулах зорилгоор нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 19 хувиас 10 хувь болгон бууруулсан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд эергээр нөлөөлжээ.

2011-2015 он

Монгол Улсын эдийн засгийн өндөр өсөлт гадаадын хөрөнгө оруулалтын хэлбэлзэл, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн савлагаа болон дотоодын төсвийн тэлэлтээс хамааран тус хугацаанд саарсан байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлд шууд нөлөөлж, хөдөлмөр эрхлэлт буурах, ажилгүйдэл өндөр түвшинд хадгалагдах


нөхцөлийг бүрдүүлжээ. 2011 онд эдийн засаг 17.3 хувиар өсөж, гадаадын хөрөнгө оруулалт огцом нэмэгдсэн боловч энэхүү өсөлт нь хөдөлмөрийн зах зээлд тогтвортой, байнгын ажлын байр бий болгож чадаагүй байна. Тодруулбал, 2011-2015 онд хөдөлмөрийн насны хүн ам 1.8 саяас 2.0 саяд хүрч, 200 мянгаар нэмэгдсэн боловч ажиллагчдын тоо 1.03 саяас 1.15 сая болж, 120 мянгаар нэмэгдсэн буюу харьцангуй бага өсөлттэй байв. Үүний үр дүнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2011 онд 57.7 хувь байсан бол 2015 онд 56.9 хувь болж буурчээ. Харин ажилгүйдлийн түвшин энэ жилүүдэд буурч 7-8 хувийн түвшинд хадгалагдсан хэдий ч хямралын өмнөх түвшиндээ хүртэл буураагүй юм. Үүнд уул уурхайгаас бусад салбарт шинээр ажлын байр төдийлөн нэмэгдээгүй, үйлчилгээний салбарт шинээр бий болсон ажлын байр ихэвчлэн улирлын шинжтэй, албан бус хөдөлмөр эрхлэлт давамгайлсан байдаг нь нөлөөлсөн байна.

Хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал сайнгүй энэ онуудад төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого баримталсан. Тухайлбал, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх” зэрэг хэд хэдэн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Эдгээр хөтөлбөрүүдэд жил бүр дунджаар 63 мянган¹⁷ хүн хамрагджээ.

Ажиллагчдыг салбарын бүтцээр авч үзвэл, хөдөө аж ахуйн салбарын ажиллагчдын тоо 2011 онд 343 мянга байсан бол 2015 онд 327 мянга болж 16 мянгаар буурсан байна. Үүнд салбарын бүтээмж сул, бусад салбарын цалингийн өсөлт; хөдөө орон нутаг дахь эрүүл мэнд, боловсролын чанар, хүртээмжийн ялгаатай байдал зэргээс шалтгаалсан дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт нэмэгдсэн гэх мэт хүчин зүйлс нөлөөлсөн байх

¹⁷ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн агуулга, үр дүнгийн үнэлгээний тайлан, 2023 он

Зураг 7.9. Ажиллагчдын тоо, салбараар (нийт ажиллагчдад эзлэх хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

талтай. Үйлчилгээний салбарын ажиллагчдын тоо 2011 онд 444 мянга байсан бол 2015 онд 523 мянгад хүрснээр хамгийн их ажиллагчтай салбар болов. Гэвч энэхүү өсөлт нь ихэвчлэн улирлын шинж чанартай, түр ажлын байр давамгайлсан тул тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлээгүй байна. Тодруулбал, хөдөө аж ахуйгаас бусад салбар дахь албан бус хөдөлмөр эрхлэлт 2011-2015 онд 135 мянгаас 205 мянга болж, 52 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин уул уурхайн салбарын ажил эрхлэлт гадаад зах зээлийн шокод мэдрэмтгий байв. 2011 онд 45 мянга байсан уул уурхайн салбарын ажиллагчдын тоо 2013 онд 50 мянга хүрсэн бол түүхий эдийн үнийн уналттай үед буюу 2015 онд 43 мянгад хүрч буурсан байна.

2016-2020 он

Энэ хугацаанд хөдөлмөрийн насны хүн амын өсөлт, ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин зэрэг хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд өсөх хандлагатай байв. Ажил эрхлэлт харьцангуй тогтвортой байсан ч эдийн засгийн мөчлөгийн савлагаа болон цар тахлын нөлөөгөөр ажилгүйдлийн түвшин богино хугацаанд хэлбэлзэлтэй байв. Гэвч Үндэсний статистикийн хорооны "Ажиллах хүчний судалгаа"-ны түүврийн аргачлалд өөрчлөлт орсон тул 2019 оноос хойших үзүүлэлтүүдийг өмнөх оны

үзүүлэлтүүдтэй шууд харьцуулах боломж хязгаарлагдмал гэдгийг анхаарах нь зүйтэй.

Ажиллагчдын ажиллаж буй салбарын бүтцийн хувьд үйлчилгээний салбар тогтвортой өсөлттэй байсан бөгөөд 2016 оны байдлаар нийт ажиллагчдын 29.9 хувийг бүрдүүлж байсан бол 2020 оны байдлаар 33 хувьд хүрч хамгийн их ажиллагчидтай салбар болов. Нөгөө талаас хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын тооны бууралтад эдийн засаг, нийгмийн хүчин зүйлээс гадна байгалийн хүчин зүйл болох ган, зуд нөлөөлж 2016 онд нийт ажиллагчдын 30.4 хувь буюу хамгийн их ажиллагчтай салбар байсан бол 2020 онд 28 хувьд хүрч буурсан байна. Түүнчлэн худалдааны салбарын хөдөлмөр эрхлэлт 2018 он хүртэл өсөж нийт ажиллагчдын 17 хувийг бүрдүүлж байсан бол цар тахлын нөлөөгөөр буурч 2020 оны байдлаар нийт ажиллагчдын 13 хувийг бүрдүүлэв.

Тус хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гурван удаа дараах байдлаар шинэчлэгдсэн байна: 2016 онд 192 мянган төгрөгөөс 2017 онд 240 мянга, 2019 онд 320 мянга, 2020 онд 420 мянган төгрөг болжээ. Үүний зэрэгцээ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жил бүрийн орлогын 60-70 хувийг ажлын байр хадгалах болон шинээр бий болгоход зориулж, залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлжээ. Тухайлбал, 2016-2020 онд нийт 12 хөтөлбөр, 46 арга хэмжээ батлагдсан байна. Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах үйлчилгээг зохион байгуулсан. Тодруулбал, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд 2017-2020 онд нийт 364 мянган хүн хамрагдаж, ажилд зуучлах үйлчилгээгээр 2017 онд 45.7 мянга, 2019 онд 44.1 мянган хүнийг ажилд зуучилсан бол 2020 онд цар тахлын нөлөөгөөр 33.1 мянга болж буурсан байна. Гэсэн хэдий ч ажил хайгчдын

тоотой харьцуулахад ажилд зуучлагдсан иргэдийн тоо харьцангуй өндөр байсан нь зуучлалын үйлчилгээ тогтвортой, үр дүнтэй байсныг харуулж байна.


7.4. Нэгдсэн төсөв

Дэлхийн санхүүгийн хямралаас үүдэлтэй түүхийн эдийн үнэ хэлбэлзэж, нэгдсэн төсвийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2009 онд 7.6 хувь, 2015 онд 5.3 хувь, 2016 онд 2.5 хувь, мөн цар тахлын хүндрэлтэй нөхцөлөөс улбаатай 2020 онд 13.3 хувиар тус тус буурсан байна. Тус үзүүлэлт бусад жилүүдэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дунджаар 30 орчим хувиар өссөн байна.

эдийн үнийн хэлбэлзэл ихтэй байснаар 2009 онд нэгдсэн төсвийн орлого 2.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар буурсан байна. “Оюутолгой” төслийн гэрээ байгуулагдсанаар уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж, төсвийн орлого 2010 онд өмнөх онтой харьцуулахад 56.7 хувиар өссөн байна.

Төсвийн нийт зарлага 2006-2010 онд төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишгийг таван удаа шинэчлэн тогтоосноор цалин, хөлсний зардал өссөн. Мөн хөрөнгө оруулалтын зардал өссөнтэй холбоотой 2006-2010 онд нийт зарлага дунджаар 34.2 хувиар өссөн байна. Зардлын бүтцээр авч үзвэл, нийт зардалд эзлэх урсгал зардлын хэмжээ дунджаар

Зураг 7.10. Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүд (ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Сангийн яам

2006-2010 он

Нэгдсэн төсвийн орлого 2006-2010 онд дунджаар 32.8 хувь буюу ДНБ-ий 33.2 хувийг, төсвийн зарлага мөн онуудын дунджаар 34.2 хувь буюу ДНБ-ий 34.0 хувьд тус тус хүрсэн байна.

Нэгдсэн төсвийн нийт орлого 2006 онд зэс, алтны үнийн өсөлтийн нөлөөгөөр 1.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 61.5 хувиар нэмэгдсэн нь өмнөх 5 жилийн дунджаас 3 дахин өндөр үзүүлэлтэд хүрсэн байна. Дэлхийн зах зээл, зэсийн үнийн өсөлт 2007-2008 онд үргэлжилж, уул уурхайн салбар орлого нэмэгдсэнээр төсвийн орлогын өсөлтийг дэмжсэн байна. Дэлхийн санхүүгийн хямралаас үүдэн түүхийн

76-80 хувь, хөрөнгө оруулалтын зардлын хэмжээ дунджаар 20-24 хувь тус тус байна. Зээлийн хүүгийн зардал төсвийн нийт зарлагын дүнд эзлэх хэмжээ дунджаар 1-2 хувьд тогтвортой хадгалагдсан байна. Төсвийн тэнцэл 2006 онд 124.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 3.1 хувь, 2007 онд 102.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.1 хувь, 2010 онд 41.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 0.4 хувийн ашигтай байсан бол 2008 онд 305.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 4.7 хувь, 2009 онд 328.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5.0 хувийн тус тус алдагдалтай гарсан байна.

2011-2015 он

Нэгдсэн төсвийн орлого 2011-2015 онд дунджаар 15.0 хувиар өсөж, ДНБ-ий 29.9 хувь, төсвийн зарлага дунджаар 20.2 хувиар өсөж, ДНБ-ий 33.9 хувьд тус тус хүрсэн байна.

Уул уурхайн голлох түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ тасралтгүй буурснаар төсвийн орлого төвлөрөлтөд сөргөөр нөлөөлжээ. Тухайлбал, нэгдсэн төсвийн нийт орлого 2011 онд ДНБ-ий 33.9 хувь байсан бол 2015 онд ДНБ-ий 26.1 хувь болж буурсан байна. Засгийн газраас төсвийн орлогыг нэмэгдүүлэх, далд эдийн засгийг бууруулах, татварын ил тод байдлыг сайжруулах хүрээнд татварын бааз суурийг тэлж, системийн шинэчлэлийг хийж, төсвийн хяналтыг сайжруулсан байна. Тухайлбал, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2015 оны 7 дугаар сард батлагдаж, иргэд НӨАТ-ын баримтаар 2 хувийн буцаан олголт авах, сугалаанд хамрагдах хуулийн зохицуулалт нэвтэрсэн нь татварын орлогыг өмнөх таван жилтэй харьцуулахад хоёр дахин өсөхөд голлон нөлөөлсөн байна. Мөн зарим бүтээгдэхүүний өсөлтийн албан татварын тухай хуулийг 2011 онд хүчингүй болгож, өсөн нэмэгдэх АМНАТ-ийн хууль хэрэгжиж эхэлсэн нь төсвийн орлогыг нэмэгдүүлсэн байна.

Төсвийн нийт зарлага 2011 онд 5.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 62.2 хувиар өссөн бөгөөд үүнд авто зам, эрчим хүч, цахилгаан дулаан, барилга, хот байгуулалт, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна. Мөн нийгмийн халамж, хөрөнгийн зардал 2011-2015 онд өмнөх таван жилийн дунджаас 3 дахин ихэссэн үзүүлэлттэй байна. Төсвийн зардал өсөхөд уул уурхайн салбарын өсөлт, 2012 оны сонгуулийн өмнөх амлалт, хүний хөгжил сангаас бэлэн мөнгө тараасан зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн. Төсвийн зарлагын хувьд 2015 онд өмнөх оны мөн үеэс 6.6 тэрбум төгрөгөөр буурснаас бусад жилүүдэд дунджаар 25.2 хувийн өсөлттэй байжээ. Тус бууралтад төсвийн тухай хуульд нийцүүлэн

зарим хөрөнгө оруулалт, хөтөлбөр, урамшууллын зардлыг танаж, шинэ төсөл эхлүүлэхийг хориглосон нь голлох нөлөө үзүүлсэн байна. Уул уурхайн хөрөнгө оруулалтын оргил үе буюу 2011 оны түүхэн өндөр өсөлтийн дараа түүхий эдийн үнэ ба гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурснаас үүдэн эдийн засгийн өсөлт саарч, төсвийн алдагдал нэмэгдэж тус хугацаанд таван жил дараалан төсөв алдагдалтай гарсан бөгөөд дунджаар ДНБ-ий 4.6 хувьтай тэнцсэн байна.

Төсвийн хууль эрх зүйн шинэчлэл, нийгмийн халамж, хөрөнгө оруулалтын зарцуулалтаар эдийн засгийн өсөлт түр хугацаанд дэмжигдсэн ч, түүхий эдийн үнэ унаснаар төсвийн орлого тасарч, зарлага өндөр түвшинд хэвээр үлдсэн байна. Тус хугацаанд төсвийн алдагдал тогтмол өндөр, өрийн дарамт огцом нэмэгдсэн бөгөөд төсвийн бодлого уул уурхайн мөчлөгөөс шууд хамааралтай байсан тул үр дүнд суурилсан төсөв онолын хувьд нэвтэрсэн ч практикт бодит нөлөө үзүүлээгүй байна.

2016-2020 он

Нэгдсэн төсвийн орлого 2016-2020 онд дунджаар 13.3 хувиар өсөж, ДНБ-ий 30.6 хувийг, төсвийн зарлага 2016-2020 онд дунджаар 15.1 хувиар өсөж, ДНБ-ий 33.7 хувьд тус тус хүрсэн байна.

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурснаар 2012-2016 онд үргэлжлэн зэс, нүүрсний үнэ түүхэн доод түвшинд хүрч, нэгдсэн төсвийн нийт орлого 2016 онд ДНБ-ий 24.4 хувьд хүрсэн. Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалтай уялдуулан 2017 онд ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсанаар эдийн засаг тогтворжиж, төсвийн орлого өссөн. Мөн дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ болон эрэлт нэмэгдэж, 2017-2019 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дунджаар 49.3 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар дунджаар 30.3 хувиар өссөн нөлөөгөөр

төсвийн нийт орлого 2019 онд 12.0 их наяд төгрөг буюу ДНБ-ий 31.8 хувьд хүрсэн байна.

Цар тахлын эсрэг үе шаттай хөл хорио, хязгаарлалтуудыг 2020 онд тогтоосноос үүдэн бизнесийн идэвхжил саарч, гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын хэмжээ буурсан. Улмаар нэгдсэн төсвийн нийт орлого уул уурхай, бөөний худалдаа зэрэг голлох салбаруудын орлого тасалдсан шалтгаанаар 2020 онд 10.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 13.3 хувиар буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага 2016 онд хөрөнгө оруулалтын зардлын өсөлтийн нөлөөгөөр ДНБ-ий 39.7 хувьд хүрч, түүхэн хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсанаар төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулах, үр ашиггүй зардлыг танах үүрэг хүлээснээр нийт зарлагын дүн 2017 онд өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар буурсан ба бусад жилүүдэд өсөлтийн хандлага хадгалагдсан байна. Төсвийн нийт зарлагын бүтцийг авч үзвэл тус 5 жилд урсгал зардал дунджаар 70-79 хувь, хөрөнгө оруулалтын зардал 18-26 хувийг эзэлж байна. 2012-2015 онд Засгийн Газрын авсан гадаад зээл (Чингис, Самурай, Евро бонд)-ийн эргэн төлөлт, хүүгийн дарамт 2016 оноос эхлэн нэмэгдэж, зээлийн үйлчилгээний төлбөр 2016-2020 онд нийт зардлын 7-13 хувийг эзэлж байсан. Улмаар 2018 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ДНБ-ий 0.1 хувийн ашигтай, бусад жилүүдийн хувьд төсвийн алдагдал 2016 онд түүхэн доод түвшинд буюу 15.3 хувь, 2017 онд 6.2 хувь, 2019 онд 2.0 хувь, 2020 онд 11.9 хувийн тус тус алдагдалтай гарсан байна.

7.5. Гадаад худалдаа

Монгол Улсын 2006-2020 он хүртэлх гадаад худалдааны хураангуй дүгнэлт.

2006-2010 он

2006-2010 онд гадаад худалдааны нийт бараа эргэлт дунджаар 4.6 тэрбум ам.доллар, худалдааны тэнцэл дунджаар 260 сая ам.долларын алдагдалтай байв.

2005 оноос эхэлсэн түүхий эдийн үнийн огцом өсөлтийн нөлөөгөөр Монгол Улсад чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалт эрчимжиж, 2006 онд нүүрс, газрын тос, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний экспорт өмнөх оноос хоёр дахин өссөн байна. Үүний үр дүнд уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн нийт экспортын 75 орчим хувийг эзэлж, 2006-2008 онд нийт экспорт жил бүр дунджаар 30 орчим хувиар өссөн байна.

Гэвч 2008-2009 онд дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын улмаас зэсийн баяжмалын үнэ 40 хувь, газрын тосны үнэ 38 хувь, нүүрсний үнэ 5 хувиар тус тус буурч, 2009 онд экспортын орлого 26 хувиар агшсан байна. Харин 2010 онд “Эрдэнэс Тавантолгой” ХК үйл ажиллагаагаа эхлүүлснээр нүүрсний экспортын биет хэмжээ хоёр дахин нэмэгдэж, нийт экспортын орлого өмнөх оноос 54 хувиар өссөн байна.

Импортын бүтцийн хувьд машин, механик, тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгсэл болон нефтийн бүтээгдэхүүний импорт нийт импортын 41.7 хувийг бүрдүүлсэн байна.

2011-2015 он

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2011-2015 онд дунджаар 10.5 тэрбум ам.доллар, худалдааны тэнцэл дунджаар 960 сая ам.долларын алдагдалтай байсан.

2011 онд “Оюутолгой” зэрэг уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж, гадаад шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн. Үүний үр дүнд зэсийн баяжмал, нүүрсний экспортын биет хэмжээ 26-27 хувиар өсөж, нийт экспортын орлого 64 хувиар нэмэгдэж, түүхэн дээд түвшинд хүрсэн.

Гэвч АНУ-ын ипотекийн зах зээлийн уналтаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн хямралын дам нөлөөгөөр БНХАУ-ын гадаад эрэлт буурч, түүхий эдийн үнэ 2012 оноос эхлэн буурч эхэлсэн. Улмаар 2012-2013 онд экспортын гол бүтээгдэхүүний биет хэмжээ тогтвортой байсан ч, дэлхийн зах зээл дээрх үнийн бууралтаас шалтгаалан экспортын орлого хоёр жил дараалан буурсан байна. Харин 2013 онд "Оюутолгой"-н зэсийн баяжмалын олборлолт эхэлснээр 2014-2015 онд зэсийн баяжмалын экспорт хоёр дахин нэмэгдэж, нийт экспортын орлого 20 орчим хувиар өссөн байна.

Төсвийн бодлогын хувьд хүний хөгжлийн сангаас 2010 онд иргэн бүрд 120 мянган төгрөг, 2011 онд 252 мянган төгрөг бэлнээр олгож, мөн орон сууцны хөнгөлөлт, оюутны сургалтын төлбөрийн дэмжлэг зэрэг төсвийн тэлэх бодлого хэрэгжсэн нь импортын барааны урсгалыг огцом нэмэгдүүлсэн байна. Мөн уул уурхайн томоохон төслүүдийн бүтээн байгуулалттай холбоотойгоор тоног төхөөрөмж, барилгын материалын импорт эрс нэмэгдэж, 2011 онд импортын урсгал хоёр дахин өссөн байна. Гэвч бүтээн байгуулалтын идэвхжил буурсантай холбоотойгоор 2014 оноос импорт буурч, 2015 онд импорт 3.8 тэрбум ам.доллар болж, 2011 оноос 42 хувиар буурсан байна.

2016-2020 он

Монгол Улсын гадаад худалдаанд 2016-2020 онд анх удаа таван жил дараалан ашигтай тэнцэл бүртгэгдсэн. Энэ хугацаанд гадаад худалдааны нийт бараа эргэлт дунджаар 11.7 тэрбум ам.доллар, худалдааны тэнцэл дунджаар 1.7 тэрбум ам.долларын ашигтай байв.


2015-2016 онд нүүрсний үнэ тонн тутамд 40 ам.доллар болж, сүүлийн 10 жилийн доод түвшинд хүрснээр нийт экспортын өсөлт саарсан. Харин 2017-2019 онд голлох түүхий эдийн үнэ өсөж, гадаад эрэлт сайжирснаар нүүрс, зэсийн баяжмалын экспорт тасралтгүй нэмэгдэж, нийт

экспортын орлого жил бүр 10-20 орчим хувиар өссөн байна.


2020 онд цар тахлын улмаас хилийн хязгаарлалт, логистикийн доголдол үүсэж, экспортын орлого буурсан.

Импортын хувьд, 2017 оноос "Оюутолгой"-н хөрөнгө оруулалтын нөлөө буурч, дотоодын эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор импорт дөрвөн жил дараалан буурсан уналтаас сэргэсэн. Үүний үр дүнд импорт 30 хувиар өсөж, 4.3 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд уг өсөлт 2020 он хүртэл хадгалагдсан. Гэсэн хэдий ч цар тахлын улмаас эрэлт саарч, хилийн хязгаарлалт, тээврийн доголдлоос шалтгаалан импортын урсгал дахин буурсан байна.


Зураг 7.11. Экспорт (сая ам.доллар)




Зураг 7.12. Импорт (сая ам.доллар)



Зураг 7.13. Экспортын бүтэц (хувь)



Зураг 7.14. Импортын бүтэц (хувь)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

7.6. Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын 2006-2020 он хүртэлх төлбөрийн тэнцлийн хураангуй дүгнэлт.

2006-2010 он

Төлбөрийн тэнцэл 2006-2010 онуудад харьцангуй тогтвортой ашигтай байв.

Манай улс руу чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалт 2006 оноос нэмэгдэн, дэлхийн зах зээл дээр экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнэ өндөр байж урсгал данс эерэг гарснаар төлбөрийн тэнцэл 389 сая ам.долларын ашигтай байв. Ингэснээр гадаад валютын цэвэр албан

нөөц 687.3 сая ам.долларт хүрч 5 сарын импортын хэрэгцээг хангах түвшинд байв. Мөн 2006 оны эцэст төгрөгийн ам.доллартой харьцах ханш 1,165 төгрөгт хүрсэн нь оны эхнээс 4.6 хувиар чангарсан үзүүлэлт юм. Гадаад болон дотоод нөхцөл байдал тогтвортой байснаар 2007 онд гадаад валютын албан нөөц 5.4 сарын бараа, үйлчилгээний импортыг хангах түвшинд байж төгрөгийн ханш тогтвортой байв.

Гэвч, 2008 онд дэлхийн зах зээл дээр нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлт эрчимтэй явагдсанаар импорт 57 хувиар өсөв. Түүнчлэн дэлхийн санхүү, эдийн засгийн хямралтай холбоотойгоор мөнгөн гуйвуулга, гадаад зээл

болон хөрөнгө оруулалт буурч, гадаад валютын орох урсгал тасалдаж, нөгөө талаа манай улсын экспортын голлох бүтээгдэхүүн зэсийн үнийн огцом уналт зэргийн нөлөөгөөр төлбөрийн тэнцэл 238 сая ам.долларын алдагдалтай гарч, гадаад валютын албан нөөц 637 сая ам.доллар хүрсэн нь бараа, үйлчилгээний импортын 2.6 сарын хэрэгцээг хангах буюу 3 сарын хэрэгцээнээс доош орсон. Гадаад валютын огцом буурснаар 2008 оны эцсийн байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш 8.3 хувиар суларч, 1,268 төгрөгт хүрэв. Төгрөгийн ханш хүчтэй сулрахад гадаад нөхцөл байдлаас гадна дотоод зохиомол эрэлт хүчтэй нөлөөлөв. Эдийн засаг дах зохиомол эрэлтийг удирдах, зах зээлийн гажуудлыг арилгах хүрээнд 2009 оны 4 дүгээр сараас Монгол банк хязгаарлалт хийж, стратегийн ач холбогдол бүхий импортын барааны гүйлгээг хийх зарчимд шилжсэн. Ингэснээр нефтийн бүтээгдэхүүн, эрчим хүч, нэн яаралтай эм, хүнс зэрэг эдийн засгийн ач холбогдол өндөртэй барааны хомсдолд ороогүй.

ОУВС-аас “Стэнд-бай” хөтөлбөрийн 229.2 сая ам.долларын зээл, бусад хандивлагч орнуудын Засгийн газраас 151.3 сая ам.доллар болон Оюутолгой төслийн 100 сая ам.долларын орж ирснээр гадаад валютын албан нөөц нэмэгдэж 1,327 сая ам.доллар буюу 7 сарын бараа үйлчилгээний импортыг хангах түүхэн дээд түвшинд хүрсэн.

Эдийн засгийн өсөлт 2010 онд 6.1 хувьд хүрч сэргэн, үйл ажиллагаа идэвхжиж импорт 49.7 хувиар өссөнөөр урсгалт дансны алдагдал 932 сая ам.долларт хүрэв. Гэвч нөгөө талаас гадаадыг шууд хөрөнгө оруулалт 2.8 дахин нэмэгдэж, багцын хөрөнгө оруулалт 879 сая ам.долларын ашигтай байснаар хөрөнгийн, санхүүгийн данс 1,250 сая ам.долларын ашигтай гарч, төлбөрийн тэнцэл эерэг байв. 2010 эцэст гадаад валютын албан нөөц 2,289 сая ам.долларт хүрсэн нь 6.5 сарын төлбөрийг гүйцэтгэх хэмжээнд хүрэлцэхээр байв. Түүнчлэн төгрөгийн

ам.доллартой харьцах ханш 2010 онд 13 хувиар чангарч 1,257 төгрөгт хүрсэн.

2011-2015 он

Гадаад худалдаа, тэр дундаа импортын бараа, бүтээгдэхүүн 2011-2015 онуудад огцом нэмэгдсэнтэй холбоотойгоор урсгал дансны алдагдал нэмэгдсэн ч гадаадын шууд хөрөнгө оруулалт болон Хөгжлийн банк, Засгийн газрын бондын нөлөөгөөр хөрөнгийн данс нэмэгдсэнээр төлбөрийн тэнцэл ашигтай байна

Эдийн засаг 2011 онд 17.3 хувиар, гадаад худалдааны бараа эргэлт 83.1 нэмэгдсэн нь эдийн засаг ихээхэн өргөжсөнийг илэрхийлж байна. Оюу Толгой зэсийн ордын бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж нийлүүлэхтэй холбоотойгоор импортын өсөлт өндөр байснаар урсгал данс 2,757 сая ам.долларын алдалтай байсан ч хөрөнгө, санхүүгийн данс 2,864 сая ам.долларын ашигтай байснаар төлбөрийн тэнцэл 28 сая ам.долларын ашигтай байв. Гадаад валютын нөөц 2,458.4 сая ам.доллар буюу түүхэн дээд түвшинд хүрсэн ч импортын сарын хэрэглээ өндөр байснаар 4.3 сарын төлбөрийг гүйцэтгэхээр байв.

Урсгал дансны алдагдал 2012 оноос улам тэлж 3,362 сая ам.долларт хүрч 22 хувиар өссөн ч хөрөнгө, санхүүгийн дансны ашиг 4,929 сая ам.долларт гарч 72 хувиар өссөн байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтаас гадна Хөгжлийн банкны 578 сая ам.долларын бонд, Худалдаа хөгжлийн банкны 300 сая ам.долларын бонд, Засгийн газрын 1,500 сая ам.долларын бондын нөлөөгөөр валютын орох урсгал өндөр байв. Улмаар гадаад валютын албан нөөц 4.1 тэрбум ам.долларт хүрч 30 хувиар өсөв.

Урсгалт тэнцлийн алдагдал 2013 онд 6 хувиар буурсан ч гадаадын шууд хөрөнгө оруулалт, багцын хөрөнгө оруулалт буурснаар хөрөнгө, санхүүгийн дансны ашиг 1.5 тэрбум ам.долларт хүрч 70 хувиар буурчээ. Улмаар төлбөрийн тэнцэл 1.9 тэрбум ам.долларын алдагдалд орж,

Зураг 7.15. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)




Эх сурвалж: Монгол банк

гадаад валютын албан нөөц 2.3 тэрбум ам.долларт хүрч оны эхнээс 45 хувиар буурсан. Төлбөрийн тэнцлийн алдагдал, гадаадын албан нөөцийн буурснаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш 19 хувиар суларч 1,659 төгрөгт хүрэв. Төлбөрийн тэнцлийн алдагдал 2014-2015 онд үргэлжилж гадаад валютын албан нөөц буурснаар импортын төлбөрийн 3 сарын хэрэгцээг хангахгүй хэмжээнд хүрсэн.

2016-2020 он

Экспортын орлого 2016-2020 онуудад тогтвортой өссөнөөр гадаад худалдааны тэнцэл таван жил дараалан ашигтай гарав. ОУВС-ийн хөтөлбөрт нэгдсэнээр 2017 оны сүүлийн

Зураг 7.16. Гадаад валютын албан нөөц, ам.долларын ханш (сая ам.доллар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

саруудад гадаад валютын албан нөөц 3.0 тэрбум ам.долларт хүрч импортын 5.9 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрэв. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өндөр байж гадаад худалдааны тэнцэл ашигтай байгаа хэдий ч үйлчилгээний гадаад худалдааны гадаад худалдаа алдагдалтай байснаар 2019 онд урсгал дансны алдагдал 2.2 тэрбум ам.долларт хүрэв.

Гадаад худалдааны тэнцэл 2020 онд 2.3 тэрбум ам.долларт хүрч 53 хувиар өсөж, үйлчилгээний гадаад худалдааны тэнцлийн алдагдал 27 хувиар буурснаар урсгал алдагдал ч урсгал данс алдагдал 0.6 тэрбум ам.долларт байв.

Шигтгээ 4. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталсан.

Уг төлөвлөлтийн баримт бичгийг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан судалгаа, шинжилгээнд тулгуурлан, зорилго, зорилт нь хэмжигдэхүйц, шалгуур үзүүлэлт нь зорилгодоо нийцсэн, төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байдлаар бүх талын оролцоог хангаж, нийт 40 төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтран боловсруулсан.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөл нь “Шинэ итгэл-Эрс шинэчлэл”-д зорин “Хүний хөгжил”, “Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил”, “Байгаль орчин, ногоон эдийн засаг”, “Төрийн бүтээмж, засаглал”, “Бүсийн хөгжил”, “Үндэсний өрсөлдөх чадвар”, “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх бөгөөд энэ хүрээнд Үндэсний, Салбарын, Төсвийн ерөнхийлөн захирагчийн, Хөтөлбөрийн гэсэн 4 түвшний үр дүнг, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлсон. Дээрх үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулж тодорхойлсон нь олон улсад хүлээсэн манай улсын үүрэг амлалтыг биелүүлэх, нөгөө талаас уг баримт бичгийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чухал алхам юм.

Дээрх бодлогын 8 чиглэлийн хүрээнд үндэсний 10 үр дүнг дараах байдлаар тодорхойлж тусгалаа. Үүнд:

1. Боловсролын чанар болон хүртээмжийн ялгааг арилгаж, эрүүл мэндийн тогтолцооны гүйцэтгэлийн хүрээг тогтоож, хүн-төвтэй, хүртээмжтэй, чанартай, санхүүгийн эрсдэлгүй тусламж, үйлчилгээг иргэн бүрд тэгш хүргэж, дундаж наслалтыг 2 насаар нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцсэн хүний нөөцийг бэлтгэн, хүний хөгжлийн үзүүлэлт 0.756 байгааг 0.85 оноонд хүргэх;
2. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдаа холбоог сайжруулж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын эзлэх хувь тооцохгүй байгааг тооцож, 2030 онд 20 хувиар нэмэгдүүлэх;
3. Иргэдийн оролцоо, соён гэгээрэл, хамтын хариуцлагыг нэмэгдүүлж, тэгш боломжийг ханган, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн үндэсний соёлын дархлааг бэхжүүлэн, эв нэгдэл, эх оронч үзлийг бататган, үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн үзүүлэлт 2021 онд 49 хувь байгааг 55 хувьд хүргэх;
4. Эрүүл, аюулгүй амьдрах орчин, хүртээмжтэй орон сууц, чанартай нийгмийн хамгааллын үйлчилгээгээр амьдралын чанарыг дээшлүүлж, гэр бүлийн эрүүл тогтвортой байдлыг дэмжиж, хүний эрхийн баталгааг ханган, хүүхдийн хөгжил хамгааллыг шинэ шатанд гаргаж, нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг тооцохгүй байгааг тооцож, 20 хувиар өсгөж;
5. Боловсруулах салбарын боловсруулалтын түвшнийг дээшлүүлж, бүтээмж, төрөлжилтийг нэмэгдүүлснээр эдийн засгийн тогтвортой өсөлт 5.1 хувьтай байгааг 6 хувиас дээш түвшинд тогтвортой хадгалах;
6. Анхдагч экосистемийн тэнцвэрийг хангаж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, байгалийн нөөц баялгийн нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг дэмжин, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнээс үүсэх бохирдол, хаягдлыг бууруулж, орчны чанар стандартыг сайжруулж байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт 37.2 байгааг 59.0 оноонд хүргэх;
7. Авлигыг бууруулж, иргэдийн шүүхэд итгэх итгэл, шударга ёсны тогтолцоог бэхжүүлж, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлж, батлан хамгаалах, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулж, “Цахимаар түрүүнд” зарчмыг хэрэгжүүлж, иргэн төвтэй үйлчилгээг бүрдүүлж, зөв засаглалын үзүүлэлтээр 114 дүгээр байрт байгааг 90 дүгээр байрт хүргэх;
8. Бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгаж, эдийн засгийн хувьд төрөлжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тэнцвэржүүлэх замаар орон нутгийн хөгжлийн үзүүлэлт 0.506 байгааг 0.604 болгож нэмэгдүүлэх;
9. Бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, татварын болон гаалийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр 61 дүгээр байрт байгааг 50 дугаар байрт хүргэх;
10. Монгол Улсын хөгжилд оруулах шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмрийг дээшлүүлж, төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, судалгааны үр дүн, оюуны өмч, шинэ технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжийг нээж, Дэлхийн мэдлэгийн индекс 47.6 байгааг 52.4 оноонд хүргэхээр төлөвлөсөн.

8. Хавсралт

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2021	2022	2023	2024	2025
БОДИТ СЕКТОР					
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөгөөр)	43,555	53,852	70,442	79,956	89,937
Бодит ДНБ өсөлт - үйлдвэрлэл (хувиар)	1.6	5.0	7.4	4.9	6.8
Бодит ДНБ өсөлт - эцсийн ашиглалт (хувиар)	1.6	5.0	7.2	5.1	6.9
Дотоод эрэлтийн оролцоо (нэгж хувиар)	17.6	11.4	5.4	21.2	1.8
Бараа, үйлчилгээний экспортын оролцоо (нэгж хувиар)	-7.5	13.9	18.0	0.5	4.0
Бараа, үйлчилгээний импортын оролцоо (нэгж хувиар)	-8.5	-20.3	-16.2	-16.6	-1.1
Бодит ДНБ-ий өсөлт дэх оролцоо (нэгж хувиар)					
Эцсийн хэрэглээ	-2.3	6.5	7.0	11.5	5.3
Өрхийн хэрэглээ	-4.0	5.1	6.3	8.7	6.6
Төрийн байгууллагын хэрэглээ	1.7	1.4	0.7	2.8	-1.3
Хөрөнгийн нийт хуримтлал	19.9	4.9	-1.6	9.7	-3.6
Цэвэр экспорт	-16.0	-6.4	1.8	-16.1	5.1
ҮНИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцэст, хувиар)	13.8	13.2	7.9	9	7.5
Зэсийн үнэ* (\$/тонн)	9,315	8,815	8,479	9,145	9,947
Алтны үнэ* (\$/трой. унц)	3,008	3,490	2,647	2,389	3,346
ДНБ дефлятор (хувиар)	14.4	17.7	21.8	8.2	4.4
(тэрбум төгрөгөөр)					
НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
Нийт орлого ба тусламжийн дүн	14,306	18,522	24,387	31,457	32,646
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	12,711	17,127	23,295	29,671	30,058
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	15,630	18,160	22,509	30,591	31,289
Нийт тэнцэл	-1,324	362	1,878	1,641	1,357
Нийт үндсэн тэнцэл	-488	1,160	3,028	2,877	2,914
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,919	-1,033	786	-920	-1,232
ЗГ-ын нийт өр (нэрлэсэн, ДНБ-д эзлэх хувиар)	62.6	61	45	42.2	39.4
ЗГ-ын нийт өр (нэрлэсэн, тэрбум төгрөгөөр)	26,918	31,965	30,774	33,430	35,420
МӨНГӨНИЙ СЕКТОР					
M2 мөнгөний өсөлт (хувиар)	13.8	6.5	24.2	15.5	10.6
Нөөц мөнгөний өсөлт (хувиар)	6.5	39.9	7.4	51.9	39.5
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	1.6	1.8	1.9	1.9	1.9
Мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	5.8	4.4	5.1	3.9	3.1
Зээлийн өсөлт** (хувиар)	18.5	7.5	22.8	31.0	20.0
(сая ам.доллороор)					
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ					
Төлбөрийн тэнцэл	-222	-727	1,457	622	1,034
Урсгал дансны тэнцэл	-2,108	-2,304	121	-2,485	-2,191
ГВУН	4,366	3,400	4,922	5,510	7,005
сарын бараа, үйлчилгээний импортын хүрэлцээ	5.7	3.4	4.4	4.0	5.3
Гадаад валютын ханш					
Валютын ханш USD/MNT (дунджаар)	2,849	3,140	3,466	3,390	3,546
Валютын ханш USD/MNT (хугацааны эцсээр)	2,849	3,445	3,411	3,420	3,557
Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	41.3	38.8	37.6	39.6	37.3
Бодит үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	102.8	105.7	111.1	120.2	126.3

*Bloomberg Terminal

**Ипотекийн зээлээр баталгаажсан бондыг оруулсан дүн

БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2021	2022	2023	2024	2025
Нэрлэсэн ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	43,555	53,852	70,442	80,663	89,937
Бодит ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	27,092	28,455	30,567	32,133	34,332

(өсөлт, хувиар)

Бодит ДНБ-ий өсөлт	1.6	5.0	7.4	5.1	6.8
Уул уурхайн	0.8	-15.3	23.4	10.8	6.8
Уул уурхайн бус	1.8	8.2	5.4	4.3	6.3
Хөдөө аж ахуй	-5.5	12.0	-8.9	-28.7	33.2
Уул уурхай	0.8	-15.3	23.4	10.8	10.6
Боловсруулах аж үйлдвэр	-0.9	6.1	5.1	-4.2	10.0
Цахилгаан дулаан	10.6	3.5	5.2	5.0	10.2
Барилга	-22.8	8.2	3.1	14.0	15.9
Бөөний болон жижиглэн худалдаа	5.8	10.1	6.8	11.9	-4.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-7.3	9.2	39.6	16.4	4.8
Мэдээлэл, холбоо	20.7	6.6	17.0	17.4	7.2
Бусад үйл ажиллагаа	5.1	5.5	6.8	9.7	3.9
Цэвэр татвар	12.2	11.5	6.6	14.7	0.3
Дефлятор	14.4	17.7	21.8	8.9	4.4

(нэгж хувиар)

ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо

Хөдөө аж ахуй	-0.8	1.7	-1.3	-3.6	2.9
Уул уурхай	0.1	-2.1	2.6	1.4	1.4
Боловсруулах аж үйлдвэр	-0.1	0.5	0.4	-0.3	0.7
Цахилгаан дулаан	0.2	0.1	0.1	0.1	0.2
Барилга	-0.9	0.2	0.1	0.4	0.5
Бөөний болон жижиглэн худалдаа	0.6	1.1	0.8	1.4	-0.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-0.3	0.4	1.8	1.0	0.3
Мэдээлэл, холбоо	0.5	0.2	0.5	0.5	0.2
Бусад үйл ажиллагаа	1.1	1.6	1.7	2.5	1.1
Цэвэр татвар	1.3	1.4	0.8	1.8	0.0

(тэрбум төгрөгөөр)

Нэрлэсэн ДНБ (эцсийн ашиглалтын аргаар)	44,703	54,878	71,202	80,208	92,588
Анхдагч орлого	(2,232)	(1,615)	(2,233)	(2,671)	(3,555)
Үндэсний нийт орлого	37,197	48,696	62,716	71,614	79,845
Хоёрдогч орлого	429	434	398	421	312
Үндэсний нийт эзэмшлийн орлого	38,419	50,048	64,097	73,039	81,105
Нийт дотоод эрэлт	45,574	58,219	64,404	81,027	87,704
Үндэсний хадгаламж	14,360	21,083	31,730	32,382	34,261
Хөрөнгийн нийт хуримтлал	15,993	22,796	23,880	28,672	28,252

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2021	2022	2023	2024	2025
(тэрбум төгрөгөөр)					
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	14,306	18,522	24,387	31,457	32,646
Ирээдүйн өв сан	967	0	416	841	1,572
Тогтворжуулалтын сан	628	1,395	676	444	562
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	12,711	17,127	23,295	29,671	30,058
Татварын орлого	11,300	15,459	21,484	27,417	27,086
Орлогын албан татвар	3,326	3,827	5,703	8,971	8,539
Нийгмийн даатгалын орлого	2,286	3,038	3,951	4,732	5,624
Хөрөнгийн албан татвар	201	238	395	459	608
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,838	3,946	4,777	5,867	6,224
Онцгой албан татвар	827	848	790	1,107	955
Тусгай зориулалтын орлого	17	19	22	26	25
Гаалийн албан татвар	939	1,256	1,465	1,792	1,849
Бусад татвар, төлбөр, хураамж	866	2,288	4,382	4,463	3,261
Татварын бус орлого	1,412	1,668	1,811	2,253	2,972
Нийтлэг татварын бус орлого	1,250	1,364	1,452	1,779	2,622
Хөрөнгийн орлого	2	4	8	6	10
Тусламжийн орлого	160	300	351	469	339
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,630	18,160	22,509	30,591	31,289
Урсгал зарлага	12,804	14,229	17,091	22,177	24,186
Цалин, хөлс	2,532	1,666	2,327	5,368	6,223
Бараа, үйлчилгээний бусад зардал	2,170	2,140	2,758	4,188	1,033
Татаас	454	537	580	955	799
Урсгал шилжүүлэг	6,813	9,088	10,276	10,429	11,762
Зээлийн үйлчилгээний төлбөр	836	798	1,150	1,236	1,557
Гадаад	681	694	1,054	1,187	1,197
Дотоод	155	104	95.5	49	360
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	2,826	3,930	5,418	8,414	7,103
Хөрөнгийн зардал	2,982	3,803	5,188	7,971	7,090
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-156	127	229	444	12
НИЙТ ТЭНЦЭЛ	-1,324	362	1,878	1,641	1,357
ҮНДСЭН тэнцэл	-488	1,160	3,028	2,877	2,914
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН тэнцэл	-2,919	-1,033	786	-920	-1,232
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,919	1,033	-786	-920	-1,232
Гадаад	487	583	1,041	258	493
ЗГ-ын бонд*	-176	-521	97	-899	373
ЗГ-ын зээл*	663	1,104	944	1,157	120
Дотоод	2,432	-1,659	-1,827	662	739
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,919	-1,276	-1,028	-11	251
ЗГ-ын бонд*	-216	378	-801	672	483
ЗГ-ын зээл*	0	0	0	0	0
Өмч хувьчлал	0.75	2.05	2.55	1.13	4.36
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0	0	0	0	0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	729	752	0	0	0
Бусад	0	0	0	0	0

*Цэвэр дүн

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2021	2022	2023	2024	2025
	(сая ам.доллароор)				
I. УРСГАЛ ДАНС	-2,108	-2,304	121	-2,485	-2,191
Бараа	1,370	1,233	4,549	3,081	3,864
Экспорт Ф.О.Б (кредит)	8,136	9,854	13,914	14,750	14,932
Импорт Ф.О.Б (дебит)	6,766	8,622	9,366	11,668	11,068
Үйлчилгээ	-1,675	-2,355	-2,592	-3,317	-2,855
Кредит	814	1,135	1,587	1,604	2,011
Дебит	2,490	3,490	4,179	4,922	4,866
Анхдагч орлого	-2,232	-1,615	-2,233	-2,671	-3,541
Кредит	292	344	455	559	548
Дебит	2,524	1,959	2,687	3,230	4,088
Хоёрдогч орлого	429	434	398	421	341
II. ХӨРӨНГИЙН ДАНС	114	154	135	171	127
Кредит	115.7	165.9	148.6	183.3	143
Дебит	1.7	11.7	13.8	12.0	16
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэг+/зээллэг-)	1,982	1,644	1,477	3,330	3,321
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	2,060	2,428	2,172	2,727	2,616
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	-25	-445	-818	1,105	833
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	8	11	2	13	-7
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-60	-351	121	-515	-121
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	-245	-298	-354	-1,075	-945
Зээл	501	-67	529	630	586
Худалдааны зээл	-413	15	-54	-70	239
IV. Алдаа болон орхигдуулга	-209	-222	-276	-393	-223
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	-222	-727	1,457	622	1,034
V. Нөөц хөрөнгө	-222	-727	1,457	622	1,034
ГВУН	-225	-751	1,398	540	974
ОУВС-гийн зээл	-3.3	-23.7	-59.1	-82.5	-59.9
Тусгай санхүүжилт	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллароор)	15,286	17,124	20,325	23,793	25,367
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	4,366	3,400	4,922	5,510	7,005
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	5.7	3.4	4.4	4.0	5.3
Валютын ханш MNT/USD (дунджаар)	2,849	3,140	3,466	3,390	3,546
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	2,849	3,445	3,411	3,420	3,557

МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2021	2022	2023	2024	2025
(тэрбум төгрөгөөр)					
Гадаад цэвэр актив	3,806	2,492	8,959	8,704	8,700
Дотоод цэвэр актив	24,057	27,173	27,872	33,847	38,377
Дотоодын цэвэр зээл	24,298	25,648	29,106	35,343	43,287
Бусад цэвэр зүйлс	(241)	1,525	(1,233)	(1,496)	(4,911)
M2 мөнгө	27,863	29,665	36,832	42,551	47,077
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	847	831	906	978	999
Харилцах болон хадгаламж	27,016	28,834	35,926	41,573	46,078
(өсөлт, хувиар)					
Жилийн өсөлт					
M2 мөнгө	13.8	6.5	24.2	15.5	10.6
Гадаад цэвэр актив	-34.6	-34.5	259.5	-2.8	0.0
Дотоод цэвэр актив	28.9	13.0	2.6	21.4	13.4
Дотоодын цэвэр зээл	27.0	5.6	13.5	21.4	22.5
ЗГ-аас авах авлага	-49.8	107.6	91.3	64.2	3.2
Бусад салбараас авах авлага	19.2	9.9	19.8	27.0	19.3
Улсын байгууллагаас авах авлага	25.0	-5.0	-16.7	13.1	-7.8
Хувийн сектороос авах авлага	18.8	10.8	21.7	27.5	20.1
(нэгж хувиар)					
M2 мөнгөний өсөлт дэх оролцоо					
M2 мөнгө	13.8	6.5	24.2	15.5	10.6
Гадаад цэвэр актив	-8.2	-4.7	21.8	-0.7	0.0
Дотоод цэвэр актив	22.0	11.2	2.4	16.2	10.6
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Мөнгөний эргэлтийн хурд	1.6	1.8	1.9	1.9	1.9
Нэрлэсэн ДНБ-ий өсөлт (хувиар)	16.3	23.6	30.8	14.5	11.5
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	13.8	13.2	7.9	8.3	7.5

